

Лиахоно

**Өөдрөг үзэл, хайр,
алсын хараатай
ерөнхийлөгч Гордон
Б.Хинкли, 22-р хуудас**

Асуулт тавихын гол учрыг олох нь,
14-р хуудас


Сургаал ба Гэрээ: Эцэг, Хүү хоёрын
тухай шууд эх сурвалжаас авсан
ойлголт, 16-р хуудас

Ганцаараа зогсох үедээ нэн хүчтэй
байхыг сонго, 28-р хуудас



Хожмын үеийн гэгээнтэн гэрэл зурагчин Жорж Эдвард Андерсон 1907 оны энэ цаг мөчийг хальснаа буулгажээ. Тэр энэ зургаараа өдөр бүрийг ойн төллийн орчимд болсон мөнхийн чухал үйл явдал болох Анхны үзэгдэлтэй сэргүүлэн тавьсан юм. Нью-Йоркийн Палмирагийн ариун ойн төгөлд 14 настай Иосеф Смит аль сүмд нэгдэх ёстой тухай мэдэж авахаар залбирч, түүн дээр ирсэн Бурхан Эцэг, Түүний Хүү хоёроос хариултаа авчээ.

Гэрэл зургийг Сүмийн түүхийн номын сангийн зөвшөөрлөөр нийтлэв



4

ЗАХИАСУУД

- 4 **Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Байныхаа гол руу онилох нь**
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
- 7 **Айлчлагч багшийн захиас бичиг: Халамжийн нийгэмлэгийн зорилго**



ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Жорж Фрэйгийн авсан гэрэл зураг. Нүүрний дотор талд: Жорж Эвард Андэрсоны авсан гэрэл зургийг Сүмийн түүхийн номын сангийн зөвшөөрлөөр нийтлэв.

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 16 **Сургаал ба Гэрээн дэх Эцэг, Хүү хоёрын тухай ойлголтууд**
Норман В.Гарднэр
Илчлэлт номон дээр илчлэгдсэн үнэнүүдээс алдагдсан учраас Сургаал ба Гэрээ бидэнд Эцэг, Хүүгийн тухай ойлголтоо гүнзгийрүүлэхэд тусалдаг.
- 22 **Гордон Б.Хинкли: Өөдрөг үзэлтэй, алсын хараатай бошиглогч**
Андрю Д.Олсэн
Сүмийн 15 дахь бидний хайрт ерөнхийлөгч Гордон Б.Хинкли ирээдүйгээ өөдрөг үзлээр харах, хайрлах, алсын хараатай байх үлгэр жишээгээр удирдсан.

28 Аврагчийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх нь

Ахлагч Кристоффэл Голдэн
Хүндхэн цаг мөчүүд биднийг хамгийн ихээр тодорхойлох болно.

34 Олж авсан бүхнээрээ ухааныг олж ав

Ахлагч Гари И.Стивэнсон
Судлах, залбирах, үйлчлэх үүрэг хүлээж авах болон Их Эзэнд итгэхийн хоорондох уялдаа холбоог ойлгосноор жинхэнэ ойлголт ирэх болно.

БУСАД ӨГҮҮЛЭЛ

- 8 **2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы тэмдэглэл**
- 10 **Бид юунд итгэдэг вэ?: Сүм дэлхийг дүүргэх болно гэдэгт бид итгэдэг**
- 12 **Бидний гэр орон, гэр бүл: Би тантай үүрд хамт амьдармаар байна!**
Леонжина Адамэс де Убрий
- 14 **Аврагчийн арга барилаар заах нь: Ярилцлагын ямар асуулт тавихаа бодож үзэх нь**
Тэд Барнэс
- 40 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**
- 80 **Биднийг дахин уулзах хүртэл: Амьд бошиглогчийн орших шалтгаан**
Ерөнхийлөгч Хью Б.Браун




44

- 44 Итгэлийн талаарх бошигллын зарчмууд**
Ахлагч С.Скотт Грөү
Та нардын одоо гаргаж буй шийдвэр, амлалт ирээдүйдээ итгэлтэй үлдэхэд тусалж чадна.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: Чи хаана өвдөг сөгдөн залбирч болох вэ?

58



- 50 2017 оны Мючелийн сэдэв: Иаков 1:5–6**
Стэфэн В.Өүэн,
Бонни Л.Оскарсон хоёр
- 53 Зурагт хуудас: Асуу**
- 54 Залбирлын талаарх таван амлалт**
Карлиса Крамэр
Залбирал нь Тэнгэр дэх Эцэгтэйгээ харилцах арга замаас илүү утга учиртай зүйл юм. Залбирлаас ирдэг бусад адислалын талаар хуваалцъя.
- 56 Залбирлын хариулт ирэхгүй байгаа юм шиг санагдах үед тавих таван асуулт**
Маргарэт Виллдэн
Залбирлын хариулт ирэхгүй байгаа юм шиг санагдах үед хэцүү байдаг ч цөөн асуулт танд аливаа зүйлийг шинэ арга замаар бодож үзэхэд тусалж болно.
- 58 Мючелийн уриа бүхий дуу: Бурханаас гуй**
Ник Дэй
- 61 Шат шатаар: Иаков 1:5–6**
- 62 Селестиел цаг мөч**
Холли Мэган Лаура Хантэр
Иймэрхүү мөчүүдэд тэнгэр гэнэт тийм ч хол санагдахаа больдог.
- 63 Бидний орон зай**
- 64 Сүмийн удирдагчдын хариулт: Сайн мэдээг хэрхэн хуваалцах вэ?**
Ахлагч М.Рассэлл Баллард
- 65 Нүдээ олсон хариулт**
Уучлахад хэцүү байна уу? Сэтгэл гутралтай тэмцэж байна уу?



76

- 66 Сүмийн түүхийн уншлагын хүснэгт: Сэргээлт**
- 69 Төлөөлөгчдийн хариулт: Тэнгэрлэг Эцэг миний залбиралд үргэлж хариулах уу?**
Ахлагч Даллин Х.Өүкс
- 70 Бидний хуудас**
- 71 Номын тавиур дээрх ном**
Ахлагч Волтэр Ф.Гонзалэз
Би уншигчмаар аятайхан ном хайж байгаад Мормоны Номыг олсон ба энэ ном амьдралыг маань өөрчилсөн.
- 72 Мин Жун шалгуурт тэнцсэн нь**
Кэлли Хансакэр
Мин Жун бохир бас нойтон харагдаж байсан ч хэрхэн Сүм рүү орж чадсан бэ?
- 74 Эрикийн төлөө залбирахаа мартуузай**
Жюли Корнэлиус-Хуанг
Ах нь сүмд явахыг хүсэхгүй байгаа болохоор Карид гунигтай байсан ч залбирлын талаар чухал сургамж авчээ.
- 76 Есүсийн тухай түүхүүд: Есүс надад хайртай**
Ким Вэбб Рэйд
- 79 Будах хуудас: Би Тэнгэрлэг эцэг эхийн хүүхэд**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Рассэлл М.Нэлсон,
Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Роберт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд
А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Иосеф В.Ситати

Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрл Ф.Макконки
Зөвлөхүүд: Бризэн К.Эштон, Жийн Б.Бингхам, Бага Лигранд
Р.Куртис, Кристоффэл Голдэн, Даглас Д.Холмс, Эрих
В.Келишкэ, Ларри Р.Лорэнс, Кэрл М.Стэфэнс

Удирдах захирал: Питэр Ф.Эванс

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Мэган Вэрхөф

Редакцийн баг: Бэтани Бартокомэв, Бриттани Бийти, Дэвид
Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жилл Хакин, Шарлотт
Ларкэбэл, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджэкер, Жошуа
Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Аннэ
Сэлү, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрссон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрюс, Фэй
П.Андрус, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн,
Коллин Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан Лофгрэн,
Скотт М.Моой, Марк В.Робисон, Рачэл Смит, Брэд Тиэри,
К.Никол Вокэнорт

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэй Анн Пэтэрс

Хэвлэх баг: Глэн Адэйр, Конни Вауторл Бриж, Жюли
Бардэтт, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Гэйл Тэйт
Раффэрти, Дэрж Ричардсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой К.Вэллинга
Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт

liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монголи, нидерланд, норвеги, орос, польши, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга,
украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад
(хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг.
(Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2017 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй
бол хувь хүмүүс *Лиахона* сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа
(мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал
хувиран авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй.
Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд
ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй.
Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар
хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St.,
FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон
шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

January 2017 Vol. 18 No. 1. ЛИАХОНА (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required
for change of address. Include address label from a recent issue;
old and new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).

NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаа

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох олон өгүүлэл, үйл ажиллагааг
оруулав. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



"Аврагчийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх нь," 28-р хуудас: Ахлагч
Голдэн хүн бүр амьдралдаа хэцүү
боловч шийдвэрлэх цаг мөчтэй тулгар-
даг тухай ярих. Та гэр бүлийнхээ гишүү-
дийн хүндхэн шийдвэртэй тулгардаг
хэд хэдэн нөхцөл байдлыг жүжигчлэн
тоглож болно. Жишээлбэл, та гэрийн
даалгаврыг чинь хуулахыг хүссэн ангийн
найздаа үгүй гэж хэлж эсвэл найзаасаа
зөв зохистой үг хэллэг хэрэглэхийг
хүсэж байгаагаар дадлага хийж болно.
Аврагчийн тухай хүчтэй гэрчлэлтэй
болсноор иймэрхүү нөхцөл байдал

үүсэхээс өмнө хэрхэн бэлтгэж болох
тухай ярилц.

**"Тэнгэрлэг Эцэг миний залбиралд
үргэлж хариулах уу?"** 69-р хуудас: Та
залбирлынхаа хариултыг ирж байгааг
хэрхэн харсан бэ? Хүсэн хүлээсэн эсвэл
хүсэн хүлээгээгүй арга замаар ирсэн
эсэхээс үл харгалзан та Их Эзний зал-
биралд тань хариулсан тодорхой жишээг
хуваалцаж болно. Залбиралд тань
хариулж, та нарыг адисалсан Их Эзний
тодорхой арга замуудыг тэмдэглэлийн
дэвтэртээ тэмдэглэж авахад бие биенээ
урамшуулан дэмжих тухай бодож үз.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Лиахона-г болон Сүмийн бусад материалыг олон хэлээр languages.lds.org хаягаар
орж үзэж болно. *Лиахонагийн* өгүүлүүдийг аудио хэлбэрээр англи, португаль, испани
хэлээр liahona.lds.org сайтаас үзэх боломжтой. Та мөн сүнслэг захиасуудыг үзэж,
бусадтай хуваалцахын тулд facebook.com/liahona.magazine вэб хуудсанд зочилж
болно (англи, португаль, испани хэлээр үзэх боломжтой).

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа болно.

Амар амгалан, 54, 62
Ариун Сүнс, 42, 54, 62,
64, 74

Ариун сүм, 12, 22, 44,
62, 63, 70

Асуултууд, 14, 56, 58
Бошиглогчид, 22, 80

Бурхан Тэргүүтэн, 16
Гэр бүлийн түүх, 41, 63

Гэрчлэл, 22, 28, 44, 64
Гэрээнүүд, 44

Дуулгавартай байдал,
44, 61

Есүс Христ, 4, 16, 28, 34,
70, 76

Залбирал, 34, 42, 50, 53,
54, 56, 58, 61, 71, 74

Зарлигууд, 4, 28, 76

Иосеф Смит, 10, 16, 28,
34, 66, 71, 80

Итгэл, 12, 22, 34, 44, 50,
53, 58, 61, 72, 80

Мормоны Ном, 71

Мөнхийн гэр бүлүүд,
12, 41, 44, 63, 79

Номлолын ажил, 10, 34,
63, 64, 71

**Нэн тэргүүнд тавих
зүйлс,** 43, 44

Өршөөл, 54, 65

Порнограф, 44

Сонгох эрх, 44, 74

Судраас судлах, 34, 43,
66, 71

Сургаал ба Гэрээ, 16, 66

Сэргээлт, 16, 66

Сэтгэл гутрал, 65

Сүмийн түүх, 10, 16, 28,
34, 66

Хайр, 4, 22, 76

Халамжийн нийгэмлэг, 7

Хоёр дахь ирэлт, 10

Хувь хүний үнэ цэн, 72

Эмэгтэйчүүд, 40



Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх

Ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф

БАЙНЫХДАА ГОЛ РУУ ОНИЛЛОХ НЬ

Би саяхан сур харвах сургуулилт хийж байсан хэдэн хүнийг ажигласан юм. Тэднийг ажиглаж байхад нум сумаар гарамгай харвадаг болохыг үнэхээр хүсэж байвал цаг хугацаа, дадлага хэрэгтэй болох нь ойлгомжтой байв.

Хоосон хана руу харваад, сумаа тойруулан бай зурснаар мэргэн харваач гэсэн нэр хүндийг авч чадахгүй. Та байны голыг олж, онч мэргэн онох урлагт суралцах хэрэгтэй болно.

Байгаа зурах нь

Эхлээд харвачихаад, дараа нь байгаа тойруулж зурна гэдэг нь бага зэрэг утгагүй санагдаж магадгүй. Гэхдээ бид заримдаа яг ийм дүр төрхийг амьдралынхаа бусад нөхцөл байдалд олж хардаг.

Сүмийн гишүүд бид заримдаа өөрсдийгөө сайн мэдээний хөтөлбөр, асуудал, тэр ч байтугай сонирхолтой, чухал эсвэл зугаатай санагдах сургаалд хүртэл дасгах хандлагатай байдаг. Бид тэдгээрийг тойруулан байгаа зурахдаа өөрсдийгөө сайн мэдээний төв рүү онилж байгаа гэдэгт итгүүлэхээр соригддог.

Үүнийг хийхэд хялбар л даа.

Эрин зууны туршид бид Бурханы бошиглогчдоос онцгой зөвлөгөө, сүнслэг илчлэлт хүлээн авсаар ирсэн. Түүнчлэн бид янз бүрийн хэвлэмэл бүтээл, удирдамж, Сүмийн гарын авлагуудаас удирдамж, тодруулга хүлээн авдаг. Бид сайн мэдээний дургтай сэдвээ хялбархан сонгож, түүнийгээ тойруулан бай зурчихаад, сайн мэдээний гол цөмийг таньж мэдсэн гэдгээ зөв гэж нотолдог.

Аврагч тодруулга өгдөг

Энэ бол бидний үед л тохиолдож байгаа асуудал биш юм. Эрт цагт шашны удирдагчид жагсаалт гаргах,

зэрэг дэвийг тодорхойлох, аль тушаал нь хамгийн чухал болох талаар маргалдах, цэц булаалдах зэрэгт их цаг зарцуулдаг байжээ.

Нэгэн өдөр шашны хэсэг эрдэмтэн Аврагчийг мэтгэлцээндээ оролцуулахыг оролдов. Тэд цөөхөн хүний санал нийлсэн асуудлаар Түүнтэй мэтгэлцэхийг хүссэн байна.

Тэд “-Багш аа, Хууль дахь агуу тушаал нь аль вэ?” гэж асуув.

Есүсийн “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн. Удаах нь, Чи хөршөө өөрийн адил хайрла.

Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг юм гэлээ”¹ хэмээн хариулсныг бид бүгд мэддэг.

“Энэ хоёр тушаал дээр *бүх* хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг” хэмээх сүүлийн өгүүлбэрийг анхаарна уу.

Аврагч бидэнд зөвхөн байг харуулаад зогсохгүй бас байны төв хэсгийг тодорхойлж өгсөн.

Байг онох нь

Сүмийн гишүүд бид өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авахаар гэрээнд ордог. Тэрхүү гэрээний далд утга нь Бурханы тухай судлах, Түүнийг хайрлаж, эрхэмлэн хүндэтгэх мөн Түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлэн, замаар нь замнаж, гэрч нь болон тууштай зогсохыг хичээн чармайх болно гэсэн ойлголт юм.

Бид Бурханы талаар судалж, биднийг хайрладаг хайрыг нь мэдрэх тусмаа Есүс Христийн хэмжээлшгүй золиослол бол Бурханы тэнгэрлэг бэлэг гэдгийг улам илүү ухаардаг. Бурханы бэлэг өршөөлийн гайхамшигт хүргэх чин сэтгэлийн наманчлалын замаар алхахад



бидэнд сүнслэгээр нөлөөлж байдаг. Энэ үйл явц биднийг өөрсдийнхөө эргэн тойронд байгаа хүмүүсийг илүү агуу хайр, энэрлээр хайрлах боломжтой болгодог. Бид хаяг шошгоны цаадхыг харахад суралцах болно. Бид хүмүүсийг хийсэн гэм нүгэл, алдаа дутагдал, сул тал, улс төрийн чиг хандлага, шашны итгэл үнэмшил, үндэс угсаа эсвэл арьсны өнгөөр буруутгах юм уу шүүхээр уруу татагдахгүй байх болно.

Бид хүн нэг бүрийг Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхэд, бидний ах, эгч хэмээн хардаг болно.

Бусдыг онцгойлон хайрлахад тийм ч амар хялбар биш нэгнийг хүртэл ойлгож, хайрлан, тэдэнд хүрч дэмжих болно. Бид гашуудах тэдний хамт гашуудаж, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах болно.²

Мөн бид сайн мэдээний зөв байны талаар зөвж шаналах шаардлагагүй гэдгийг ухаарах болно.

Хоёр агуу зарлиг бол бай нь юм. Эдгээр хоёр тушаал дээр бүх Жууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг.³ Үүнийг бид хүлээн авах л юм бол бусад бүх сайн зүйл утга учир, авцалдаатай болно.

Хэрэв бид юуны өмнө бодол санаа, хүчин чармайлтаа Бүхнийг Чадагч Бурханыг хайрлах хайраа

нэмэгдүүлэх, зүрх сэтгэлээ бусдад зориулахад төвлөрүүлбэл байгаа зөв олж, байныхаа гол руу онилох буюу Есүс Христийн жинхэнэ дагалдагчид болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Матай 22:36-40.
2. Мозая 18:9-ийг үзнэ үү.
3. Матай 22:40-ийг үзнэ үү.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Захиасаас хуваалцахын өмнө “Аврагчийн маань хайр” дууллыг дуулж болно (*Hymns*, дугаар 113). Дараа нь айлчилж очдог хүмүүсээ амьдралынхаа “бай”-ны талаар эргэцүүлэн бодоход урамшуулан дэмж. “Өөрийн Бурхан Эзэнээ хайрлах,” “хөршөө өөрийн адил хайрлах” (Матай 22:37, 39-ийг үзнэ үү) гэсэн агуу хоёр тушаал бидний хэрхэн юу үйлдэхийг байнга удирдан залж байдаг гэдгийг нотлох арга замуудын талаар ярилцаж болно. Та өөрийн амьдралыг Христ дээр төвлөрүүлсэн арга замыг болон хэрхэн таныг адисалсан тухай гэрчлэлээ хуваалцаж болох юм.

Инээмсэглэл байдлыг өөр болгодог

Ерөнхийлөгч Угдорф Бурханыг болон бусдыг хайрлах гэсэн бидний үйлдэх хоёр зорилгыг тодорхойлж өгсөн. Бусдыг хайрлах нь тийм ч амар хялбар байдаггүй. Таныг хэн нэгэн гомдоосон эсвэл хэн нэгэнтэй харьцахад хэцүү, хоорондоо таарахгүй байх зэргээр амьдралын туршид бусадтай харьцахад хэцүү цаг үеүд байсан байж болох юм. Ийм үед та найз нөхөд, гэр бүл, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христээс мэдэрч байсан хайрынхаа тухай санаарай. Эдгээр нөхцөлд та мэдэрч байсан баяр баясгалантай мөчийнхөө тухай санан, хүн бүхэнд ийм хайрыг мэдрэх боломж байна хэмээн төсөөлөхийг хичээ. Хүн бүр Бурханы охин, хүү гэдгийг болон тэд Түүний болон таны хайрыг амсах эрхтэй гэдгийг санаарай.

Та өөрийнхөө амьдрал дахь таарч тохирдоггүй тодорхой хэн нэгний талаар бод. Тэднийг залбиралдаа багтаан, зүрч



сэтгэлээ тэдэнд нээж өгөхөд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуй. Та хайр хүртэх эрхтэй хүүхдүүдийнх нь нэгний хувьд тэдэнтэй Бурхан хэрхэн ажиллахыг тун удалгүй харах болно.

Залбирсныхаа дараа тэдэнд зориулан ямар нэгэн сайн үйл хий. Тэднийг Мючелийн эсвэл Сүмийн бусад үйл ажиллагаанд урьж болох юм. Гэрийн даалгавраа хийхэд нь тусалъя гэсэн санаа гарга. Ердөө л "Сайн уу" гэж мэндлээд, тэдэн рүү инээмсэглэ. Жижиг зүйлс та хоёрын амьдралд . . . том өөрчлөлт гаргаж чадна!

ХҮҮХДҮҮД

Байны төв рүү!

Ерөнхийлөгч Угдорф сайн мэдээ бол байг онох сургуулилт хийхтэй адил хэмээн хэлэв. Бид хамгийн чухал гэсэн зүйл рүү чиглэх хэрэгтэй. Хамгийн чухал тушаалууд бол Бурханаа хайрлах мөн хөршөө хайрлах явдал юм. Хэрэв бид эдгээр хоёр зүйлд төвлөрвөл байны төв хэсгийг байнга онож чадна.

Бурханыг болон бусдыг хайрлах хайрыг харуулахад туслах байн дээр сум зур. Хийхэд сайн биш зүйлийн байн дээр Х тэмдэг зур.



ТОГЛООМООРОО
ХАМТ ТОГЛОХ



ХЭН НЭГНИЙГ МУУХАЙ
НЭРЭЭР ДУУДАХ



ХЭН НЭГНИЙГ ТЭВРЭХ



ЧИХЭР
ХУЛГАЙЛАХ



ЗАЛБИРАХ



АХ, ЭГЧ, ДҮҮ НАРТАЙГАА
ХЭРЭЛДЭЖ, ЗОДОЛДОХ



Халамжийн нийгэмлэгийн зорилго

Энэ материалыг залбирч судлаад, юу хуваалцахаа мэдэхийн тулд сүнсэлг өдөөлт эрэлхийл.

Халамжийн нийгэмлэгийн зорилго бол “эмэгтэйчүүдийг мөнх амьдралын адислалд бэлтгэх явдал юм.”¹ Энэ нь итгэл, гэр бүл болон “Ажлын чухал хэсэг”-г бидний оруулдаг хувь нэмэр болох тайвшралаар дамжуулан хэрэгжинэ.”²

Халамжийн нийгэмлэг бол “материаллаг болоод сүнсэлг ажил юм. Энэ бол Аврагчийн өдрүүдэд эмэгтэйчүүдийн хийж байсан ажил бөгөөд бидний үргэлжлүүлэн хийж буй ажил” гэж Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэрол М.Стэфэнс хэлсэн билээ.³

Худгийн дэргэд усны саваа орхиод, Есүсийг эш үзүүлэгч гэдгийг бусдад хэлэхээр гүйсэн эмэгтэй (Иохан 4:6–42-ийг үзнэ үү) эсвэл амьдралынхаа туршид бусдад баяр хөөртэй үйлчилж байсан Фойбе (Ром 16:1–2-ыг үзнэ үү) нарыг харвал бид Христ рүү очихоор идэвх зүтгэл гаргаж байсан Аврагчийн өдрүүдэд амьдарч байсан эмэгтэйчүүдийн жишээг олж харах болно. Тэр мөнх амьдрал руу очих бидний замыг нээж өгдөг юм (Иохан 3:16-г үзнэ үү).



Итгэл,
гэр бүл,
халамж

Бид өөрсдийн байгууллагыг байгуулахын тулд 1842 онд Наувугийн Иллинойд Сара Кимбаллын гэрт цугларч байсан анхдагч эмэгтэйчүүдийн тухай бодох үедээ Халамжийн нийгэмлэгийг байгуулж, санваартай хамт нэг эгнээнд байхад зориулсан Бурханы төлөвлөгөө байгааг олж хардаг. Элиза Р.Снөү нэгэн үндсэн баримтыг бичсэн бөгөөд бошиглогч Иосеф Смит түүнийг хянан нягталжээ. Эмэгтэйчүүд зохион байгуулагдах хүртэл Сүм хэзээ ч төгс байгаагүй гэдгийг тэрээр ойлгосон аж. Бошиглогч Их Эзэн тэдний саналыг хүлээн авсан ч бас ямар нэгэн илүү сайн зүйл байгаа хэмээн хэлсэн. “. . . Би эмэгтэйчүүдийг санваарын удирдлаган доор санваартнуудын жаягаар зохион байгуулна” хэмээн тэрээр хэлжээ.⁴

Халамжийн нийгэмлэг бол ердөө л дэлхийд сайн сайхан үйлс бүтээхийг хүсэж буй өөр нэгэн бүлэг эмэгтэй биш юм. Энэ бол огт өөр зүйл. Энэ нь санваарын эрх мэдлээр зохион байгуулагдсан учраас ‘юунаас ч илүү сайн зүйл’ юм. Үүнийг байгуулсан нь газар дэлхий дээр Бурханы ажлыг дэлгэрүүлэхэд чухал алхам болсон.”⁵

Нэмэлт судар, мэдээлэл

Сургаал ба Гэрээ 25:2–3, 10; 88:73; reliefsociety.lds.org

ЭШЛЭЛҮҮД

1. Линда К.Бертон, “Relief Society Celebrates Birthday and More March 17,” *Church News*, 2015 оны 3-р сарын 13, news.lds.org.
2. Линда К.Бертон, “Relief Society Celebrates Birthday.”
3. Кэрол М.Стэфэнс, “Relief Society Celebrates Birthday.”
4. Иосеф Смит, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 11-12.
5. *Daughters in My Kingdom*, 16.



Үүнийг эргэцүүлэн бод

Халамжийн нийгэмлэг эмэгтэйчүүдийг тэдний төлөөх болон тэднийг мөнх амьдралд хүргэх Тэнгэрлэг Эцэгийн бурханлаг үүргийг биелүүлэхэд хэрхэн тусалдаг вэ?

2016 ОНЫ 10-Р САРЫН ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛ

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

Та 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы талаар тоймлон үзэхдээ амьд бошиглогч, төлөөлөгчдийн болон Сүмийн бусад удирдагчийн саяхан заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд эдгээр хуудсыг (мөн дараачийн дугаарууд дахь Чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.



СУРГААЛЫН ЧУХАЛ ХЭСЭГ

Наманчлал бол Бурханы бидэнд өгсөн бэлэг

“Бурханы хайранд ‘нөхцөл байдаггүй’ гэдэг тодорхойлолтыг бид байнга сонсдог. Энэ нь хэдийгээр үнэн ч *нөхцөл байдаггүй* гэдэг тодорхойлолт нь судрын хаана ч байдаггүй. . . .

Бурхан биднийг үргэлж хайрлах боловч нүгэлтэй байхад маань аварч чадахгүй. Аврагч Өөрийн хүмүүсийг *нүгэлд* нь гэтэлгэхгүй харин *нүглээс* нь гэтэлгэх болно хэмээн Зиезромд ярьсан Амюлекийн үгсийг санагтун. Учир нь нүгэл үйлдсэн үедээ бид цэвэр бус болдог ба ‘цэвэр бус нэг ч зүйл тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй’ [Алма 11:37] эсвэл Бурханы оршихуйд байж чадахгүй. . . .

Мормоны Номоос бид Христийн зовлон шаналлын зорилго, хайрын эцсийн илэрхийлэл бол ‘шударга ёсыг давамгайлах тэр, мөн хүмүүнд, тэд наманчлалд итгэлтэй байх тэр замыг авчрах нигүүлслийн зүрх сэтгэлийг бий болгох нь’ [Алма 34:15] юм гэдгийг мэдэж авдаг. . . .

Наманчлал нь маш өндөр үнээр худалдаж аван, бидэнд өгч буй Түүний бэлэг юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон, “Миний хайр дотор бай,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 48-ыг үзнэ үү.

БОШИГЛОГДСОН АМЛАЛТ



АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Бидний Аврагч, Есүс Христ энэ төлөвлөгөөний зайлшгүй нэгэн чухал хэсэг билээ. Түүний цагаатгагч золиослолгүйгээр хүн бүр төөрөлдсөн хэвээрээ үлдэх байсан. Зүгээр л Түүнд болон Түүний номлолд итгэх нь хангалтгүй юм. Бид хөдөлмөрлөж, суралцаж, эрэлхийлж мөн залбирч, наманчилж, өсөж хөгжих хэрэгтэй. Бид Бурханы хуулиудыг мэдэж, тэдгээрийн дагуу амьдрах хэрэгтэй. Бид Түүний авралын ёслолуудыг хүлээн авах хэрэгтэй. Бид эдгээрийг хийснээр л жинхэнэ, мөнхийн аз жаргалыг олж авах болно.

Бид үнэнээр адислагдсан ба уг үнэнийг хуваалцах үүрэгтэй. Эцэгийн бидэнд хадгалсан бүхнийг хүлээн авахын тулд уг үнэнээр амьдарцгаая. Түүний хийж буй бүх зүйл бидний сайн сайхны төлөө байдаг. Тэрээр “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” [Моисе 1:39] хэмээн бидэнд хэлсэн.

Би бодьгалынхаа бүхий л эрч хүчээр мөн даруу байдлын гүнд бидэнд зориулсан Эцэгийн төлөвлөгөө болох энэхүү агуу бэлгийн талаар гэрчилж байна. Энэ нь энэ дэлхийд болон ирэх дэлхийд амар амгалан, аз жаргалд хүргэх цорын ганц төгс зам юм.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Аз жаргалд хүргэх төгс зам,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 80–81.



Христийн хязгааргүй Цагаатгал

“Аврагч, Эдгээгч Эзэнд бидний зүрх сэтгэлийг өөрчлөх, гэм нүглээс маань үүдэлтэй уй гашуугаас тайтгаруулах хувиршгүй тайтгаруулах хүч байдаг. . . .

. . . [Тэрээр] биднийг бусдын зөв шударга бус үйлдлийн улмаас өвчин шаналал мэдрэх үед тайвшруулан, хүчирхэгжүүлж чаддаг. . . .

. . . [Тэр] биднийг гай гамшиг, сэтгэцийн эмгэг, өвдөлт, архаг хууч өвчин, үхэл зэрэг “мөнх бус бодит байдлын” шаналалтай тулгарахад тайвшруулан, дэмжиж чадна . . .

Аврагч:

“Хэрэв та нар надад ирэх аваас та нар мөнх амьдралыг авах болно. Болгоогтун, миний нигүүслийн мутар та нарын зүг сунгаастай байна, мөн ирэх хэнийг боловч түүнийг би хүлээн авах болно” [3 Нифай 9:14]” хэмээн хэлсэн.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэррол М.Стэфэнс, “Эдгээгч Эзэн,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 10, 11, 12-ыг үзнэ үү.



ӨӨРЛӨХ ХҮЧ, МАЙКЛ Т.МОЛМ

Христийг болон
Түүний сургаалыг
эсэргүүцдэг ямар ч зүйл
бидний баяр баяслыг үгүй
хийх болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын
ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон,
“Баяр баясгалантай байж, сүнслэг
байдлын хувьд тэсэж үлдэх нь,”
2016 оны 10-р сарын Ерөнхий
чуулган, 84-ийг үзнэ үү.

Ирээд, Намайг дага

Хэд хэдэн үг хэлэгч биднийг Христтэй адил зан чанаруудыг хөгжүүлж, Хүндэтгэлийн өдөр шүтэн бишрэхдээ Аврагчийг санаж байхад урамшуулан дэмжсэн. Тэдний хэлсэн үгийг уншихын тулд 2016 оны 11-р сард хэвлэгдэн гарах сэтгүүлийг ашигла эсвэл conference.lds.org сайтаар зочилно уу.

- Би хэрхэн Христийн шашинтны хайр, үйлчлэлийг харуулах вэ? —Робэрт Д.Хэйлс, “Христийн шашинтны хайр, үйлчлэлийг үзүүлснээр ‘Ирээд, Намайг дага,’” 22-ыг үзнэ үү.
- Би хэрхэн илүү сайн гэрийн багш болох вэ? —Жэффри Р.Холланд, “Сүмийн төлөөлөгчид,” 61-ийг үзнэ үү.
- Би Хүндэтгэлийн өдөр хэрхэн чин сэтгэлээсээ шүтэн биширдэг болох вэ? —Дийн М.Дэйвийс, “Шүтлэг бишрэлийн адислал,” 93-ыг үзнэ үү.
- Би хэрхэн ариун ёслолоос хүртэх явцыг илүү утга учиртай болгох вэ? —Петр Ф.Мэурс, “Ариун ёслол ариун болоход маань тусалж чадна,” 85-ыг үзнэ үү.

Ерөнхий чуулганы үгсийг conference.lds.org-оос унших, үзэх эсвэл сонсох боломжтой.

СҮМ ДЭЛХИЙГ ДҮҮРГЭХ БОЛНО ГЭДЭГТ БИД ИТГЭДЭГ

Сүмийг анх 1830 онд Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотын жижигхэн тосгонд зохион байгуулах үед зургаахан Сүмийн гишүүн байсан. Түүнээс хойш Сүм 150 улс дахь тойрог, салбарт 15.5 сая гаруй гишүүнтэй болон өсөж хөгжсөн. Энэхүү өсөлт хөгжилт нь Хуучин Гэрээн дэх Сүм урагш өнхөрч, бүх дэлхийг дүүргэх болно хэмээх бошиглолын биелэлт юм (Даниел 2:31–45-ыг үзнэ үү). Сүмийг буюу дэлхий дээрх Бурханы хаант улсыг “хүний гар хүрэлгүйгээр . . . цавчигдаж” (Даниел 2:45) унасан чулуугаар дүрсэлдэг бөгөөд энэ нь хүмүүний гараар бүтээгүй тэнгэрлэг ажил гэдгийг илчилдэг.

Сүмийн нөлөө дэлхийг дүүргэсэн ч гишүүд нь харьцангуй цөөхөн байх болно. Нифай үүнийг урьдчилан харсан бөгөөд бидний өдрүүдийн талаар “би Бурханы Хурганы сүмийг болгоов, мөн . . . ёсон бус хийгээд жигшүүрт хэргүүдийн учир, тоогоороо цөөн байв” хэмээн бичжээ (1 Нифай 14:12). Есүс Христийн Хоёр дахь ирэлтийн цаг ойртох тусам дэлхий улам бүр ёс бус болж, “хожмын үеийн гэгээнтэн байх нь улам л нэр хүндгүй болох болно.”¹

Хэдий тийм ч Нифай “Бурханы гэгээнтнүүд байсан Хурганы сүмийнхэн түүнчлэн бүх дэлхийн гадаргуугаар оршин байхыг” харжээ (1 Нифай 14:12). Дэлхий даяар тойрог, салбарууд байгаа бөгөөд Ерөнхий чуулганыг 90 гаруй хэлнээ орчуулж, бараг 75000 бүрэн цагийн номлогч 418 номлолд сайн мэдээг түгээж байна. Сайн мэдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Mormon.org, LDS.org гэх мэт вэбсайтаар дамжин дэлхий даяар түгж байна.

Эдгээр хүчин чармайлт чухал, өргөн цар хүрээтэй байдаг ч тийм ч их анхаарал татдаггүй юм. “Их Эзэний энэ ажил үнэхээр агуу, гайхамшигтай төдийгүй бараг бүх хүн төрөлхтний улс төр, соёл, боловсролын салбарын удирдагчдад мэдэгдэхгүйгээр урагшилсаар байдаг. Энэхүү төлөвлөгөө нь нэг зүрх сэтгэл, нэг гэр бүлээс нөгөөд дамжин аниргүй агаад анзаарагдалгүй давшин, ариун мэдээгээр хүмүүсийг адисалсаар байна.”²

Эрт дээр үед бошиглосон чулуу үнэхээр урагш өнхөрч байгаа бөгөөд бид өөрсдийн үүргийг биелүүлэх үед сайн мэдээ дэлхий ертөнцийг үргэлжлүүлэн дүүргэсээр байх болно (Даниел 2:31–45-ыг үзнэ үү). ■

Сүмийн ирээдүйн талаар илүү их зүйлийг мэдэхийг хүсвэл Сургаал ба Гэрээ 65; Гордон Б.Хинклигийн “Stone Cut Out of the Mountain” (2007 оны 10-р сарын Ерөнхий чуулган); Л.Витни Клэйтоний “Цаг нь ирэх болно” (2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган) зэрэг хэлсэн үгсийг уншина уу.

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Жинхэнэ мянган жилийнхэн мэт байх нь,” *Лиакхона*, 2016 оны 10-р сар, 50.
2. Л.Витни Клэйтон, “Цаг нь ирэх болно,” *2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 14.



СҮМИЙН ИРЭЭДҮЙ

“Өнөө орой энд хуруу дарам цөөхөн санваартан байгааг та

нар харж байна. Гэвч энэ Сүм Хойд, Өмнөд Америкийг дүүргэнэ, энэ дэлхийг дүүргэнэ.”

Бошиглогч Иосеф Смит (1805–1844), 1834 оны санваарын хуралдаан дээр хэлсэн үг, Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 157.

Бид сайн мэдээг урагшлуулахад туслахын тулд юу хийж болох вэ?



Зарлигуудыг сахиж, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх нь сайн мэдээг түгээхэд туслах үндэс суурийг тавьж өгдөг.



Дуудлагаа биелүүлэх нь орон нутгийнхаа Сүмийг хүчирхэгжүүлэхэд тусалдаг.



Гэр бүлдээ сайн мэдээг заах нь эсрэг зүйл зааж буй дэлхийд итгэлтэй амьдрах хүч чадлыг тэдэнд өгдөг.



Бид хүмүүстэй сайн мэдээний тухай энгийн яриа өрнүүлснээр сайн мэдээг түгээхэд тусалж чадна.



Бид сайн мэдээг сонсолгүй нас барсан хүмүүсийн төлөө энэ дэлхий дээр ариун сүмд ёслолуудыг гүйцэтгэж чадна.

БИ ТАНТАЙ ҮҮРД ХАМТ АМЬДАРМААР БАЙНА!

Леонжина Адамэс де Убри

Зургаан настай хүүхдийн итгэл намайг итгэлээ олж авахад тусалсан.

Намайг 22 настай байхад ээж минь өнгөрч, амьдрал маань оронгоороо эргэсэн юм. Миний ээж, аав хоёр агуу итгэлтэй хүмүүс байсан бөгөөд намайг сайн мэдээнд өсгөж хүмүүжүүлсэн билээ. Ээжийг өнгөрөхөд аав амьдарч байсан улсаасаа АНУ руу нүүв. Би айлын ганц хүүхэд байсан тул цаг хугацаа өнгөрөх тусам улам их ганцаардаж байв. Ээж минь энэ дэлхий дээр миний дэргэд байхгүй, аав минь хол амьдарч, жилдээ гуравхан долоо хоног л барааг нь хардаг байлаа.

Ингээд би коллежийн “найз нөхөд,” ажиллаж байсан газраасаа тайтгарах аргаа хайх болсон юм. Улмаар дэлхийн зүйлсээс хуурамч аз жаргалыг бага багаар эрэлхийлэх болов. Би сүмдээ явахаа больж, яваандаа Сүмийн идэвхгүй нэгэн боллоо. Хожим нь би сайн мэдээний тухай мэддэггүй ч маш зарчимч нэгэн гайхамшигтай залуутай гэрлэсэн юм. Бид Леа, Исаак, Ишмэйл гэсэн гурван хүүхэдтэй боллоо.

Нэгэн удаа аравдугаар сард аав маань шинэ төрсөн хүүхдийг минь эргэж ирэв. Түүнийг зочилж ирээд байх үед зургаан настай Леа өвөөгөөсөө ягаад эмээтэй хамт

ирдэггүйг нь асуужээ. Аав минь тэгэхэд эмээ нь Тэнгэрлэг Эцэгтэй ойр байдаг онцгой газарт байгаа хэмээн тайлбарлаж өгчээ. Аавыг явангуут Леа надад “Би эмээтэйгээ уулзмаар байна. Би түүнийг тэнгэрт байгаа гэдгийг мэдэж байна. Гэхдээ хэзээ нэгэн өдөр эмээ, өвөө, аав, Исаак, Ишмэйл, та, би бүгдээрээ тэнд хамтдаа байгаасай хэмээн би хүсэж байна. Би тантай үүрд хамт амьдармаар байна. Бид энд байдаг шигээ бас яг энэ гэр бүлээрээ эмээтэйгээ тоглож байхыг хүсэж байна” хэмээн нухацтай нь аргагүй хэлэв.

Би юу хэлэхээ мэдэхгүй байлаа. Би түүний хөөрхөн гэнэн царайнд гараа хүргэж илчихээд, унтлагын өрөө рүүгээ оров. Би өвдөг сөгдөн суугаад, нулимсаа бартал уйллаа. Би Тэнгэрлэг Эцэгээс өөрийгөө өршөөхийг гуйв. Бид мөнхийн гэр бүл болж хамтдаа амьдрах боломж олгодог замаас гарсан байсныг би ойлгов. Би тэднийг зөв замаар удирдан авч явах үүрэг хариуцлагаа биелүүлж чадсангүй. Мөн би нөхөртэйгөө сайн мэдээний талаар ярилцаагүй байв.

Би босох тэнхэлтэй болж сөхөө



ТЭНГЭРТ ХОЛБОГДСОН

Аврагч мөнх бус амьдрал дахь тохинууллынхаа үед Өөрийн ахлах төлөөлөгч Петр “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдох бөгөөд газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт мөн тайлагдах болно” (Матай 16:19) хэмээн хэлэх үедээ гэр бүлүүдийг лацдан холбох хүчний тухай ярьжээ.

Бид гэр бүлээрээ үүрд мөнх хамт амьдарч чадах газар бол зөвхөн селестиел хаант улс юм. Бид тэнд Тэнгэрлэг Эцэгийнхээ болон Аврагчийн оршихуйд гэр бүлээрээ хамтдаа байж чадна.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, “Гэр бүлүүд мөнхөд хамт байж чадна,” *Лиакхона*, 2015 оны 6-р сар, 4.



аваад, Сүмийн удирдагчтай холбоо барихад тэрээр тойргийн маань ахлагчидтай холбож өгсөн юм. Тэр оройдоо тэд манайд ирж, нөхөрт минь сургаал заав. Тэр оройноос эхлэн бидний амьдрал мөнхөд өөрчлөгдсөн юм. Одоо бид гэр бүлээрээ ням гараг болгон сүмдээ явж байгаа. Би идэвх султай эгч нарт туслах боломжтой дуудлагад дуудагдсан. Бид бас ариун сүмд орохоор бэлтгэж байна.

Бурханы Ариун Сүнс биднийг заримдаа төсөөлж ч байгаагүй хүмүүсээр минь дамжуулан удирддаг. Энэ удаа уг хүн нь миний зургаан настай охин байсан. Би ариун сүмд лацдан холбуулснаар гэр бүлийнхэнтэйгээ үүрд хамт амьдарч болно гэдгийг одоо мэддэг болсон. ■

Энэхүү өгүүллийн зохиогч Бүгд Найрамдах Доминикан улсын Санто Домингод амьдардаг.

ЯРИЛЦЛАГЫН ЯМАР АСУУЛТ ТАВИХАА БОДОЖ ҮЗЭХ НЬ

Тэд Барнэс

Сүмийн санваар болон гэр бүлийн алба

Та нар өдрийн хоолны үеэр найзуудтайгаа хамт үзсэн киноныхоо талаар ярилцаж байна гэж төсөөл. Нэг найз чинь “Киноны хамгийн чухал хэсэг чухам аль нь байсныг надад хэлж өгөөч” гэж хэлжээ.

Та нар эргэлзсэн байдалтай хэсэг зуур бодоод, хамгийн сүүлийн хэсэг хамгийн чухал нь байсан гэж хэллээ. “Тийм шүү, сайхан хариулт байлаа” гэж найз чинь хэлэв. “Гэхдээ миний бодож байсан хариулт биш

байна. Өөр хэн хэлмээр байна? Хуваалцаагүй хэн нэгний үгийг сонсоцгооё.”

Иймэрхүү маягаар чи найз нөхөдтэйгөө ярьдаггүй ч ийм яриа ихэнхдээ Ням гаргийн ангид болдог юм шиг санагддаг. Багш нарын хувьд бид сайн мэдээний үнэнийг энгийн бөгөөд тайван байдлаар ярилцахын оронд бусад нөхцөлд хачин жигтэй гэмээр, бас ярилцлагыг унтраахад ч хүргэж болох зүйлүүдийг заримдаа хэлэх нь бий. Бид ангийн гишүүдийг найзуудынхаа дунд байгаа юм шиг мэдрэмжтэй байгаасай

мөн суралцаж байгаа зарчмуудынхаа талаар санал бодлоо дуртайяа хуваалцах байх гэж найддаг. Ингэж хуваалцах нь Сүнснийг урьж, хүн бүрийн туршлагыг баяжуулдаг.

Бид асуулт маань илүү энгийн, утга учиртай ярилцлага руу хөтөлж байгаа эсэхэд хэрхэн анхаарах вэ? Хийж болох мөн хийж болохгүй зарим зүйл гэж байдаг ба энэ нь олон багшид ашиг тусаа өгдөг юм. Хариулт нь тодорхой асуулт бүү тавь. Нэгээс илүү хариулттай асуулт тавь. Хэт хувийн чанартай асуулт тавьсны хэрэггүй.

Ангид ямар асуулт тавихаа шийдэхээс өмнө *Энэ асуултыг тавьж байгаа үндсэн шалтгаан маань юу билээ?* гэж өөрсдөөсөө асуух нь үнэ цэнтэй байдаг.



*Багш нарын ангидаа ирэхээсээ өмнө
өөрсдөдөө тавих асуулт хамгийн
чухал асуулт байж болно.*

Яагаад та нар асуулт тавьдаг вэ?

Асуултуудын цаадах учир шалтгаан нь маш том өөрчлөлтийг авчирдаг. Жишээлбэл, бид заримдаа ямар нэгэн хэлэх зүйл байгаа учраас үүнийгээ ангийнхнаар хэлүүлэхийн тулд асуулт тавьдаг уу? Бид зөвхөн өөрсдөө яриад байхыг хүсэхгүй байгаа ч гол санааг нь гаргамаар байгаа учраас сонсохыг хүсэж байгаа хариултаа гаргаж ирэхийн тулд заримдаа асуулт тавьдаг. Энэ нь “Порнографтаас зайлсхийх нь оюун санаагаа цэвэр байлгахад хэрхэн туслах вэ?” “Өдөр бүр залбирах нь чухал уу?” зэрэг үнэн учрыг далдалсан асуулт тавихад хүргэдэг.

Тодорхой хариулттай асуултуудад тохирсон төгс нөхцөл байдалууд бас бий. Тэдгээр нь гол санааг онцлох юм уу хичээлийг урьдчилан бэлтгэхэд тус болно. Гэхдээ эдгээр асуулт нь утга учиртай хэлэлцүүлэгт оролцоход ангийн гишүүдийг урамшуулахад тохиромжгүй байдаг.

Өөрөөр хэлбэл, хэрвээ бид ангийнхаа гишүүдийн оюун санаа, зүрх сэтгэл, амьдрал ямар байгааг мэдэхийн тулд асуулт тавьж байгаа бол энэ нь бидний тавьж байгаа асуултуудаас харагдах болно.

Сүнслэг суралцахуйг дэмжин, чин сэтгэлээсээ ярилцахад ангийн гишүүдийг урьдаг асуултууд нь

“Чамайг энэ шүлгийг уншиж байх үед юу нь онцгой санагдсан бэ?” “Ямар туршлага чамд Их Эзэний амлалтуудад найдах ёстойг заасан бэ?” “Чи юу гэж бодож байна . . .?” гэх мэт асуултыг багтаадаг.

Дараах жишээнүүдийг авч үзнэ үү.

- Сүнс Нифайгаас “Юуг хүснэв та?” (1 Нифай 11:10) хэмээн асуусан.
- Есүс шавь нараасаа “Та нар намайг хэн гэх вэ?” (Матай 16:15) гэж асуусан байдаг.
- Есүс Мартад “Би бол амилагт ба амь мөн . . . Чи үүнд итгэж байна уу?” (Иохан 11:25, 26) гэж хэлсэн байдаг.

Эдгээр асуулт бүр нь хэн нэгнийг зүрх сэтгэл доторхоо уудлахад урьсан юм. Эдгээр нөхцөл байдал бүрд хүчирхэг сүнслэг туршлага ирсэн.

Асуултууд нь хайрын илэрхийлэл юм

Гайхалтай нь, бараг хүн бүр, бүр өөрсдийгөө сайн багш гэж боддоггүй хүмүүс хүртэл ярилцлага өрнүүлдэг асуулт тавьж чаддаг. Бид гэр бүлтэйгээ эсвэл найзтайгаа утга учиртай ярилцлага өрнүүлэх бүрдээ үүнийг өөрсдөө ч мэдэлгүй хийчихдэг буюу өдрийн хоолны үеэр дуртай киноныхоо тухай яг ингэж ярилцдаг. Бид

өөрийн эрхгүй хийчихдэг зүйлээ ангид хичээл заахдаа гэв гэнэт мартаж орхидог.

Ярилцлагын сайн асуулт тавихын чухал бүрэлдэхүүн хэсэг нь “Хэрэв би ангид байгаагүй бол үүнийг яаж асуух байсан бол? Хэрэв би гэртээ хэсэг найзтайгаа сайн мэдээний талаар ярьж байсан бол юу гэж асуух байсан бол?” гэж өөрсдөөсөө асуух явдал юм. Би тэднийг бодол сэтгэгдэл, мэдрэмжээ хуваалцахад хэрхэн урих вэ? Заах нь найзуудтайгаа энгийн яриа өрнүүлэхтэй яг адил биш боловч адилхан талтай. Эдгээр нь чин сэтгэлээсээ сонсох хүсэл, өгөөмөр хайраар өдөөгдөх ёстой.

Хэрэв та уран цэцэн үгтэй асуулт олж чадахгүй байгаа бол бүү санаа зов. Таныг зааж буй хүмүүсээ хайрлахаас өөр зүйл хийж чадахгүй байх үед ч Сүнс таныг удирдаж, та юу хэлэхээ илүү сайн мэдсээр байх болно. Паул “Хайр хэзээ ч дуусдаггүй” (1 Коринт 13:8) хэмээн тунхагласан бөгөөд багш ангид асуулт тавих гэх мэт энгийн зүйлийн хувьд ч энэ нь үнэн юм. ■

Та Заах.нь.lds.org дахь *Teaching in the Savior's Way* (2016), “Ask Inspired Questions,” 31–32-р хуудсаас зургаан төрлийн асуултын талаар суралцаж болно.



СУРГААЛ БА ГЭРЭЭН ДЭХ

Эцэг, Хүү хоёрын

ТУХАЙ ОЙЛГОЛТ

*Илчлэлтийн энэхүү ном нь Бурхан
Тэргүүтэний талаарх алдагдсан үнэнийг
болон бид хэрхэн Аврагч, Тэнгэрлэг Эцэг хоёр-
той дахин хамт амьдарч болохыг илчилдэг.*

Институт ба семинар
Норман В.Гаднэр

Сайн мэдээний сэргээлт дэлхийд Бурхан Тэргүүтэний мөн чанар болон Тэдний зорилгын талаар илүү агуу мэдлэг өгдөг. Ийм мэдлэгтэйгээр Тэдэнд итгэх бидний итгэл өсөн, Тэдний зарлигуудыг сахих хүсэл маань нэмэгддэг.

Ялангуяа Сургаал ба Гэрээ “түүний бурханлиг чанар, түүний сүр жавхлан, түүний төгс чанар, түүний хайр, мөн түүний гэтэлгэгч хүч” (Сургаал ба Гэрээний удиртгал)-тэй холбоотой хүчирхэг үнэнийг заадаг учраас энэ нь Есүс Христийн талаар судлахад бидэнд тусалдаг. Орчин үеийн илчлэлтийн энэ ном нь “Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун” (С ба Г 19:23) гэсэн Их Эзэний урилгыг агуулдаг. Энэ нь бидний Түүний талаарх ойлголтыг мөн Түүнтэй харьцах харилцаа ямар байх, биднийг цагаатгахын тулд юу хийсэн болон биднээс юу хүсэн хүлээж байгаа зэрэг ойлголтыг гүнзгийрүүлж чадна.



Бид Сургаал ба Гэрээнээс Есүс Христийн дуу хоолойг сонсож чадна

Сургаал ба Гэрээ нь эртний судар биш боловч Иосеф Смит болон өнөө үеийн түүний залгамжлагчдад өгөгдсөн илчлэлтүүдийг агуулдаг. Есүс Христийн тэнгэрлэг дуу хоолой Эцэгийн төлөөлөгч ярьж буйн адил сонсогддог.¹ Их Эзэн Есүс Христийн дуу хоолой Шинэ Гэрээ, Мормоны Ном, Агуу Үнэт Сувд зэрэг судруудаас илүү олон удаа Сургаал ба Гэрээн дээр цэдэглэгджээ.²

С ба Г 18:33–35 “Мөн бибээр Есүс Христ, та нарын Их Эзэн мөн та нарын Бурхан, үүнийг ярилаа. Эдгээр үгс нь хүмүүсийнх биш, харин минийх бөлгөө; . . . Учир нь тэдгээрийг та нарт ярьсан нь миний дуу хоолой болой.”



Иосеф Смит Аврагчаас олон илчлэлт хүлээн авсан.

JOSEPH SMITH JR. RECEIVING REVELATION, ДАНИЭЛ А. ЛЬЮС



THE LORD APPEARS IN THE KIRTLAND TEMPLE, ДЭЛ ПАРСОН

Иосеф Смит, Оливер Каудери хоёр Көртландын ариун сүмд Есүс Христийг харсан.

Сургаал ба Гэрээ Бурханыг харсан хүмүүсийн цэдгийг агуулдаг

1820 оны Анхны үзэгдлээр Иосеф Смит хөвгүүн Эцэг, Хүүгийн оршин буй талаарх анхны мэдлэгийг олж авсан. Сургаал ба Гэрээ бошиглогч болон бусад хүний Эцэг, Хүүт үзэгдлээр эсвэл нүдээрээ харсан тухай нэмэлт тохиолдлуудыг цэдэглэжээ. Эдгээр цэдэг Тэднийг амьд, Тэд сайн мэдээний сэргээлтийг удирдан чиглүүлсэн гэх орчин үеийн гэрч болдог.

С ба Г 76:19–23 Эцэг, Хүү хоёр 1832 оны 2-р сард үзэгджээ.

С ба Г 137:1–3 Эцэг, Хүү хоёр 1836 оны 1-р сард үзэгджээ.

С ба Г 110:2–4 Агуу Иехова Есүс Христ 1836 оны 4-р сард үзэгджээ.

Сургаал ба Гэрээ Бурхан Эцэгийн талаар судлахад тусалдаг

Бошиглогч Иосеф Смит “Биднийг Бурханы мөн чанарыг ойлгоод, Түүн рүү хэрхэн ирэхээ мэдэх үед Тэрээр бидэнд тэнгэрийг нээж эхэлдэг. Биднийг Түүн рүү ирэхэд бэлэн болох үед Тэрээр бидэн рүү ирэхэд бэлэн болдог” хэмээн заасан.³ Сургаал ба Гэрээ Тэнгэрлэг Эцэгийн мөн чанар, хандлага, зорилго зэргийг зааж, Түүн рүү улам илүү ойр очиход бидэнд тусалдаг.

С ба Г 20:12, 17–18 Бурхан Эцэг төгсөшгүй бөгөөд хувиршгүй.

С ба Г 76:20, 23 Эцэг, Хүү хоёр тусдаа салангид биес юм.

С ба Г 93:3–5 Эцэг, Хүү хоёр нэг юм.

С ба Г 130:22 Эцэг, Хүү хоёр мах хийгээд ясан биетэй.

С ба Г 138:3–4 Тэнгэрлэг Эцэг хүүхдүүддээ хайртай учраас хүн төрөлхтөнийг аврахын тулд Хүүгээ илгээсэн юм.



Үхтлээ чулуугаар цохиулсан Стефен Эцэг, Хүү хоёрыг харсан.

MOSES SEEING JEHOVAH, ИОСЕФ БРИКИ



Иехова (Есүс Христ) Мосетэй нүүр нүүрээ харан ярилцсан.

Сургаал ба Гэрээ Есүс Христийн талаар судлахад бидэнд тусалдаг

Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн бүх сүнсэн хүүхдийн Ууган нь юм. Мөнх бус амьдралын өмнөх амьдралд Есүс бүх мэдлэг, хүчийг эзэмшсэн байсан бөгөөд Эцэгийг төлөөлөн дэлхийнүүдийн Бүтээгч болсон. Их Эзэн Есүс Христ тэнгэрлэг хүчээрээ дамжуулан бүх бүтээлийнхээ гэрлийн эх сурвалж, амь амьдрал болдог юм. Сургаал ба Гэрээ Эцэгийн төлөвлөгөөн дэх Түүний гүйцэтгэх үүргийг тодорхой болгосон.

С ба Г 93:21 Есүс Христ Бурханы бүх сүнсэн хүүхдийн Ууган нь билээ.

С ба Г 38:1–3 Есүс Христ энэ дэлхийг бүтээхээс өмнө бүх мэдлэг, хүчийг эзэмшсэн.

С ба Г 76:24 Есүс Христ Эцэгийг төлөөлж дэлхийнүүдийг бүтээсэн.

С ба Г 88:6–13 Есүс Христ бүх бүтээлийнхээ гэрлийн эх сурвалж, амь амьдрал юм.

С ба Г 45:11; 136:21, 22 Есүс Христ бол Хуучин Гэрээний агуу Иехова байсан.

С ба Г 43:34 Есүс Христ бол энэ дэлхийн аврагч юм.

С ба Г 18:11–13; 20:21–25 Есүс Христ зовж шаналан, цовдлуулж, амиа өргөөд, дараа нь амилсан.

С ба Г 29:10–12 Есүс Христ дэлхийд дахин ирэхдээ хүч, алдар суундаа ирэхээ амласан.



Орчин цагийн илчлэлтээр дамжуулан бид хэрхэн Эцэг, Хүү хоёртой илүү адил болох талаар суралцдаг.

Сургаал ба Гэрээ Эцэг, Хүү хоёрыг биднээс юу хүсэн хүлээж байдаг талаар суралцахад бидэнд тусалдаг

Судрын өөр бусад номоос илүү Сургаал ба Гэрээ Эцэг, Хүү хоёртой хамт эргэн амьдрахын тулд буцаж очих, Эцэгт байгаа бүхнийг хүлээн авах, Тэдэнтэй адил болох гэх мэтээр мөнх амьдрал гэж юу болохыг энгийн байдлаар тайлбарласан. Мөн Есүс Христ хэрхэн Цагаат-галаараа дамжуулан энэ зүйлийг боломжтой болгодгийг мөн Түүний тогтоосон шаардлагуудыг биелүүлэхийн тулд бидний юу хийх хэрэгтэй байгааг хэлж өгдөг. Түүнчлэн бид Сургаал ба Гэрээнээс Есүс Христ бидэн шиг эхлээд бүрэн байдалд байгаагүй ч бүх хүч, алдар сууг олж авах хүртлээ ач ивээл дээр ач ивээл хүлээн авч байсан учраас Есүс Христийн жишээг дагана гэдэг нь ямар учир утгатай талаар суралцдаг.

- С ба Г 1:32; 19:16–19; 58:42–43; 95:1–2** Аврагч наманчилдаг хүмүүст өршөөлийг санал болгодог.
- С ба Г 20:37, 41, 72–74;** мөн **33:11**-ийг үзнэ үү. Бурхан Тэргүүтэн баптисм, Ариун Сүнсийг хүлээн авахад итгэж найддаг хүмүүсийг урьдаг.
- С ба Г 84:19–21** Мелкизедек санваарын ёслолуудаар дамжуулан бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг.
- С ба Г 93:12–14, 16–17** Есүс Христ бүрэн байдлыг хүлээн автлаа ач ивээл дээр ач ивээлийг хүлээн авсан.
- С ба Г 20:30–31** Аврагч Өөрийг нь хайрладаг, Өөрт нь үйлчилдэг хүмүүст ач ивээл өгдөг.
- С ба Г 35:2; 50:40–43** Бид Эцэг, Хүү хоёртой нэг болж чадна.
- С ба Г 93:19–20** Бид Эцэгийн алдар суу, бүрэн байдлыг хүлээн авах боломжтой.

Сургаал ба Гэрээ сүнслэг мэдлэг олж авах загварыг өгдөг

Сургаал ба Гэрээ Эцэг, Хүү хоёрын тухай зааж, гэрчлэхээс гадна Их Эзэний ажлын талаар судлах, ойлгож авахын төлөө Тэнгэрлэг Эцэгээс асуух, Есүс Христийн зарлигуудыг дагаснаар Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэх зэргээр Ариун Сүнсээр дамжуулан Бурхан Тэргүүтэний бүх гишүүний тухай сүнслэг мэдлэг олж авах загварыг өгдөг.

Гэрэл ба үнэнийг Их Эзэний үгийг дагаж амьдардаг хүмүүст амласан бөгөөд Бурхан Тэргүүтэний мөн чанар, Тэдний зорилгын талаар нарийн сайн судлах нь чухал юм. Энэ мэдлэг үнэний тухай сүнслэг ойлголт, итгэл үнэмшлийн төлөө шаргуу эрэл хайгуул хийхэд хүргэж болно. Энэ мэдлэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр биднийг нэг бүрчлэн мэдэж, хайрладаг мөн мөнх амьдралаар адислахыг хүсдэг гэдгийг баталж өгдөг.

С ба Г 6:5; 76:5–10, 114–118 Тэнгэрлэг Эцэг хуваалцах мэдлэг, амлалтыг гуйгаасай хэмээн биднээс хүсдэг.

С ба Г 84:43–48 Эцэг биднийг Түүний үгийг хичээнгүйлэн анхааралтай сонсох үед заадаг.

С ба Г 88:118 Судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэгтүн.



Судлах, залбирах нь сүнслэг мэдлэгийн цоожийг онгойлгодог.

ИОСЕФ СМИТ НОМЛОЖ БАЙГАА НЬ, СЭМ ЛОВЛОР



Иосеф Смит Эцэг, Хүү хоёрын мөн чанар, зорилгыг илчилсэн

Дүгнэлт

Сургаал ба Гэрээ Тэнгэрлэг Эцэг, Түүний Цорын Ганц Төрсөн Хүү Есүс Христийн мөн чанар, зорилгуудыг илчилдэг учраас Тэдэнтэй илүү ойртоход бидэнд тусалдаг. Бошиглогч Иосеф Смит “Бидний Бурханы зорилго бол агуу, Түүний хайр хэмжээлшгүй, Түүний мэргэн ухаан төгсөшгүй, Түүний хүч хязгааргүй учраас гэгээнтнүүд ‘энэ Бурхан бол мөнхийн мөнхөд бидний Бурхан билээ’ гэдгийг мэдээд, баярлах, баясгалантай байх шалтгаантай (Дуулал 48:14)” хэмээн дүгнэн хэлсэн.⁴ ■

ЭШЛЭЛҮҮД

1. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972) “Уналтаас хойших бүх илчлэлт нь Хуучин Гэрээний Иехова болох Есүс Христээр дамжин ирсэн байдаг” хэмээн тайлбарласан. Бүх сударт Бурханыг дурдсан, Бурхан үзэгдсэн тохиолдол бүр нь Иехова байсан. . . . Эцэг уналтаас хойш хүмүүнтэй шууд, өөрийн биеэр огт харьцаж байгаагүй бөгөөд Тэр Хүүг таницуулж, мөн гэрчлэхээс бусдаар огт гарч ирээгүй байна (*Doctrines of Salvation*, эмхэтгэсэн Брүс Р.Макконки, 3-р боть [1954–56], 1:27).
2. Гордон Б.Холбрүк, “The Voice of Jesus Christ in the Doctrine and Covenants,” *Ensign*, 2013 оны 9-р сар, 40, 45 (note 2).
3. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 40.
4. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*, 39.

ГОРДОН Б.ХИНКЛИ:
ӨӨДРӨГ
ҮЗЭЛТЭЙ,
АЛСЫН
ХАРААТАЙ
БОШИГЛОГЧ



*Та нар энэ жил Санваарын
болон Халамжийн
нийгэмлэгийн ангидaa*

*Teachings of Presidents of the
Church: Gordon B. Hinckley -ийг
судлахдаа дундаригүй өөдрөг
үзэл, хайр, алсын хараатай
бошиглогчоос суралцах болно.*



Гордон Б.Хинкли 1910 оны 6-р сарын 23-нд Брайнт Стрингхам Хинкли, Ада Битнэр Хинкли нарын гэр бүлд төрсөн. Тэрээр 1937 оны 4-р сарын 29-нд Солт Лэйхийн ариун сүмд Маржорий Пэйтэй гэрлэж, таван хүүхдийн эцэг эх болжээ. Мөн 1995 оны 3-р сарын 12-ноос 2008 оны 1-р сарын 27 хүртэл Сүмийн 15 дахь ерөнхийлөгчөөр үйлчилсэн байна.

Сүмийн хэвлэлийн алба
Андрю Д.Олсэн

“**Б**и хавар бүр хэдэн мод тарих ёстой байдаг” гэж ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 82 насандаа өөрийнхөө тэмдэглэлийн дэвтэрт тэмдэглэн үлдээжээ. “Би ядаж л сүүлийн 50 жил үүнийг хийсэн гэж бодож байна. . . . Модонд ямар нэгэн гайхалтай зүйл байдаг. Мод анхандаа маш жижигхэн байдаг ч улирал бүрд ургаж томорсоор байдаг. Мод зуны аагим халуунд сүүдрээ тусгаж, амтат жимсийг ч бас ургуулдаг. Бас модны дотор фотосинтезийн гайхамшигтай урвал явагдаж байдаг. . . . Мод нь Бүхнийг Чадагчийн гайхамшигтай нэгэн бүтээл юм.”¹

Ерөнхийлөгч Хинкли 90 нас хүртлээ мод тарьжээ. Түүнийг мод тарих дуртай байсныг олон арга замаар, Сүмийн төлөөлөгч, ерөнхийлөгчийн үйлчлэлээс нь харж болно. Тэрээр модоо тарихдаа өөрийнх нь сургаал, бусадтай харилцах харилцааных нь нэг хэсэг болсон зан чанар болох өөдрөг үзлийг харуулдаг байсан. Тэр хүн бүрийг хайрладаг шигээ мод бүрийг

арчилдаг. Тэрээр хүн нэг бүрийн мөнхийн чадавхыг мөн Бурханы ажлын гайхамшигт ирээдүйг хардаг шигээ ирээдүй өөд хараад, модод ямар болохыг хардаг.

“Бидэнд өөдрөг байх олон шалтгаан бий.”

“Би өөдрөг хүн!” Ерөнхийлөгч Хинкли ихэнхдээ “Би та нарыг шуурга салхинаас хайхаа зогсоож, нарны илчинд илүү сайн

ээгээсэй гэж хүсэж байна”² хэмээн хэлдэг байсан. Тэр өөдрөг хандлагыг бий болгож чадсан бөгөөд өөдрөг үзэл нь хандлагаас хавьгүй гүн гүнзгий байсан юм. Түүний өөдрөг үзлийг хүчирхэг болгосон эх сурвалж нь Бурханд итгэх итгэл, Бурханы хүүхдүүдийнхээ аз жаргал, авралын төлөө зохиосон төлөвлөгөөний талаарх гэрчлэл юм.

Ерөнхийлөгч Хинклигийн өөдрөг үзлийн

нэгэн илэрхийлэл нь “бүх зүйл сайхан болно” гэдэгт итгэх түүний бат итгэл байсан.³ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Ерөнхийлөгч Хинкли гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагчдаа итгэл үнэмшлээ хамгийн олон дахин нотолсон байж болох юм. Тэрээр ‘Хичээсээр бай. Итгэсээр бай. Аз жаргалтай бай. Сэтгэлээр бүү уна. Бүх зүйл сайхан болно’ гэж хэлдэг байсан”⁴ гэжээ.

Энэ захиас зөвхөн бусдад хандаагүй юм. “Би өглөө бүр өөртөө бас ингэж хэлдэг” гэж ерөнхийлөгч Хинкли цугларагсдад



хэлжээ. “Хэрэв та нар чадах бүхнээ хийвэл бүх зүйл сайхан болно. Бурханд итгэл найдвараа тавь. Ирээдүйд итгэх итгэл, найдвараар урагшил. Их Эзэн биднийг орхихгүй.”⁵

Ерөнхийлөгч Хинклигийн өөдрөг үзэл өөрийгөө зовлон бэрхшээлтэй, хангалтгүй байна гэж бодох үед мөн маш их ачаалаалтай үед ч бас тус болдог байсан. Тэр зовлон зүдгүүр, сэтгэл гутрал, зүрхний шаналал, ганцаардалтай тулгарахдаа хүртэл “бүх зүйл сайхан болно” гэдэг итгэл үнэмшилдээ бат зогсдог байв.

Ерөнхийлөгч Хинкли өөдрөг үзэлтэй ч асуудлуудыг бага гэж боддоггүй байв. Тэр “Би энэ дэлхийн олон зүйлийг харсан. . . . Би дайн дажинтай мөн хүмүүс нь зүрх сэтгэлдээ үзэн ядалт тээсэн газруудад байсан. Би олон газар нутгийг хамарсан аймшигт ядуурлыг харсан. . . . Мөн нийгмийн ёс суртахуун унан доройтож байгааг сэтгэл эмзэглэн харж байсан.

Гэсэн ч би өөдрөг хүн. Зөв шударга ёс ялж, үнэн ноёлох болно гэдэг энгийн, гэгээлэг итгэл надад байдаг”⁶ гэжээ.

Америкийн Нэгдсэн Улсын Иллиной мужийн Науву дахь *New York Times* сонин сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа ерөнхийлөгч Хинкли гай зовлон, сорилт бэрхшээлийн цар хүрээг хүлээн зөвшөөрч мөн өөдрөг үзлийн талаар заахдаа Сүмийн түүхийг хайрлах хайраа жишээ болгожээ.

“Бидэнд өөдрөг байх олон шалтгаан бий. . . . Наувуг хар л даа. Тэд долоон жилийн турш юуг бариад, орхиод явсныг хар. Тэд юу хийсэн бэ? Тэд зүгээр л үхлээ хүлээгээд хэвтсэн үү? Үгүй ээ! Тэд хөдөлмөрлөхөөр ханцуй шамлан орсон. Тэд энэ тивийн талыг туулж, цөл газарт сарнай цэцэгсийг цэцэглүүлэн хөгжүүлсэн. Сүм энэхүү суурин дээр 140 гаруй үндэстний хүмүүсийн амьдралд сайнаар нөлөөлөх дэлхий дахины нэгэн агуу байгууллага болсон юм. Та нар гутранги үзэл, эргэлзээ бүхий байвал юуг ч хийж, бүтээж чадахгүй. Өөдрөг үзлээр хөдөлмөрлө. Итгэлээр үйлд. Бүх зүйл сайхан болно.”⁷

Ерөнхийлөгч Хинклигийн өөдрөг үзэл бусадтай найрсаг харилцаа тогтоодог алиа хошин, хөгжилтэй, уриалгахан, эелдэг занд их түлхэц болсон юм. Тэрээр

нэг өдөр хуучин сургуулийн байранд амьдардаг нэгэн гадасны ерөнхийлөгчийнд очжээ. Тэр орой ерөнхийлөгч Хинклид нэгэн ангийг унтлагын өрөө болгон өгчээ. Дараагийн өдөр нь гадасны чуулганы үеэр тэр “Би урьд нь олон ч удаа ангид унтаж байсан ч хэзээ ч ангид орон дотор унтаж байсангүй”⁸ гэж хошигнон хэлсэн байна.



“Бид үргэлж хувь хүмүүст санаа тавьдаг байх ёстой”

Гордон Б.Хинкли Сүмийн ерөнхийлөгчийн хувьд анх удаа Ерөнхий чуулган дээр үг хэлэхдээ Сүмийн өсөлт хөгжилтийн талаар нэлээд ярьсан юм. “Бид нэгэн агуу дэлхий дахины нийгэмлэг болж байна” гэж тэр хэлжээ. Дараа нь тэр “Бид хувь хүмүүст үргэлж санаа тавьж, анхаарал хандуулж байх хэрэгтэй. . . .

. . . Бид тооны тухай их ярьдаг. Гэхдээ бидний хүчин зүтгэл хүмүүсийн өсөлт хөгжилд зориулагдах ёстой”⁹ гэж хэлэн, энэхүү чухал зарчмыг онцолсон.

Ерөнхийлөгч Хинкли Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байхдаа дайн тулаан болж байсан дэлхийн хамгийн алслагдсан хэсгүүд рүү хувь хүмүүст номлохоор явж байжээ. Ямар ч бүлэг хүн түүнд хэт хол эсвэл хэт өчүүхэн санагдаагүй.

Тэрээр Сүмийн ерөнхийлөгч болсон хойноо ч энэ арга замаар номлож байсан ба 60 гаруй улс үндэстэн рүү хэдэн сая километр аялж очдог байсан. Заримдаа томоохон бүлэгтэй, зарим үед цөөн хэдэн хүнтэй уулздаг байв.

1996 онд ерөнхийлөгч Хинкли, Хинкли эгч хоёр Ази, Номхон далайн найман улс үндэстэн рүү 18 хоног аялжээ. Тэд маш хурдтайгаар аяллаа Японоос эхлүүлж, мянга мянган хүнтэй уулзан, очсон газар бүрдээ дүүрэн хүнтэй байдаг байв. Ерөнхийлөгч Хинкли Солонгост байхдаа “Эдгээр нь миний хувьд үнэхээр сэтгэл хөдлөм туршлага болсон” гэж бичжээ. “Би мөрөөдөж ч байгаагүй зүйлээ 1960 онд анх удаа энд ирэхдээ харсан.”¹⁰ Тэрээр энэ аялалд явж байхдаа бас Хятадын Хонконгийн ариун сүмийг онцгойлон адисалсан юм.

Төлөөлөгчөөс өмнө сүүлийн зогсоол Филиппин байлаа. Ерөнхийлөгч Хинкли Манилад 35000 хүнд

хандан үг хэлснийхээ дараа “Зүрх сэтгэл маань ихэд хөдлөн, би босож зогсоод, тэдэн рүү гараараа далласан ба бид нүд дүүрэн нулимстай буцаж билээ” гэж тэмдэглэн үлдээжээ. Тэрээр тухайн өдрийн өглөө, 1961 онд Филиппин дэх номлолын ажлыг эхлүүлэхийн тулд онцгойлон адислах залбирлаа хэлж байсан тэр газартаа эргэж иржээ. “Тэр үед тэнд ганцхан уугуул филиппин хүн байсан” гэж тэрээр дурссан байна. “Уг ганцхан гишүүнээс Сүм 300000 гаруй гишүүнтэй боллоо өсөж хөгжжээ.”¹¹

Хинклигийнхэн гэр рүүгээ харих замдаа сууж явсан онгоц нь Сайпан арал дээр түлшээ цэнэглэх хэрэгтэйг олж мэджээ. Ерөнхийлөгч Хинкли Сайпанд номлогчид байгаа эсэхийг асуухад цөөхөн номлогч байгаа гэж хариулав. Тэрээр урт аяллын төгсгөлд ихэд ядарсан байсан ч тэдгээр номлогчтой уулзахыг хүссэн байна. “Тэдэнд оройны 7 цагийн үед Сайпанд газардах болно мөн тэдэнтэй мэндлэхээр онгоцны буудлаас гарахыг хичээх болно гэдгийг дамжуулж өгч болох болов уу гэж би асуусан.”

Хэдэн цагийн дараа Сайпанд ирэхэд 10 номлогч, 60 Сүмийн гишүүн Хинклитэй мэндлэхээр ирсэн байв. “Тэд биднийг бүчиж аваад, тэвэрсэн” гэж ерөнхийлөгч Хинкли тэмдэглэн бичжээ. “Тэд биднийг хараад маш их баярласан, бид ч тэднийг хараад туйлын их баярлаж билээ. Онгоцонд түлш хийхэд хэсэгхэн хугацаа шаардах учраас бид маш богино хугацаанд хамт байсан. Бид тэдэнд адислалаа үлдээгээд, онгоц руугаа буцсан.”¹²

Ерөнхийлөгч Хинклигийн хувь хүнд хэрхэн анхаарал, халамж тавьдгийн өөр нэг жишээ 2002 оны Юта мужийн Солт Лэйк хотод болсон Өвлийн олимпын үеэр тохиолдсон юм. Тэрээр бараг өдөр бүр ерөнхийлөгч, элчин сайд, ихэс дээдэстэй уулзаж байв. Нэгэн өдөр Германы ерөнхийлөгчтэй уулзахаасаа өмнөхөн тэр төрсөн өдрөө тэмдэглэж байсан 13 настай залуу эмэгтэйтэй уулзжээ. “[Тэр] ясны чөмөг гэмтсэнээс цусны бөөмийн дутагдалд оруулдаг маш аюултай өвчнөөр өвдсөн байсан. Бид хамтдаа гайхалтай сайхан мөчийг өнгөрөөсөн. . . . Бид түүнийг залбиралдаа оруулах болно гэж би түүнд хэлсэн”¹³ гэж бичсэн байв.

Ерөнхийлөгч Хинкли ялангуяа Сүмийн хүүхдүүд, өсвөр үеийнхнийг маш их хайрладаг байсан ба тэд ч мөн түүнийг хайрладаг байсан. Түүнийг Бразилд үт хэлж байхыг нь сонссон нэгэн залуу эмэгтэй “Би Бурханы Сүнснийг маш хүчтэй мэдэрсэн. Ерөнхийлөгч Хинкли үгээ хэлж дуусгахдаа ‘Та нар эндээс явж, гэртээ очоод, өнөөдөр миний хэлсэн бүх зүйлийг мартаж болно. Гэхдээ намайг та нарт хайртай гэдгийг хэзээ ч битгий

мартаарай’ гэж бидэнд хэлсэн. Би энэ үгсийг хэзээ ч мартахгүй”¹⁴ гэжээ.

Ерөнхийлөгч Хинклигийн эхнэр Маржорий түүнийг хувь хүмүүст анхаарал тавих үед түүний хамтрагч, нөлөө үзүүлэгч болдог байв. Тэрээр “Тэр хүмүүст чин сэтгэлээсээ анхаарал хандуулдаг учраас мэддэг хүн бүр нь түүнийг хайрлаж байгаа юм шиг санагддаг. Тэр тэдний асуудал, хэрэгцээнд санаа тавьдаг. Би



Дээд талаас цагийн зүүний дагуу: Ерөнхийлөгч Хинкли гишүүдтэй уулзаж байгаань; Хятадын Хонконгт эхнэр Маржорийтэйгээ хамт; Ерөнхий чуулган дээр эргэцүүлэн бодож суугаань.

ийм ханьтай ямар азтай хүн бэ!”¹⁵ гэж бичсэн байна.

Таван хүүхэд нь өсөж том болсны дараа Хинклигийнхэн ихэвчлэн хамтдаа аялдаг болсон ба Хинкли эгч дэлхий даяар хайраа түгээн явдаг байлаа. Тэр номлогчидтой уулзсаныхаа дараа гэртээ ирээд, тэдний эцэг эх рүү ярьж, гэнэтийн бэлэг барьдаг байв. Мөн олон үзэгч, сонсогчтой холбоо тогтоож, харилцахдаа авьяастай байсан. “[Маржи] хүмүүст хэрхэн таатай сэтгэгдэл төрүүлэх үгсийг хэлж, бусдад туслахаа мэддэг” гэж ерөнхийлөгч Хинкли орон нутгийн чуулганы дараа бичиж үлдээсэн байна. “Түүнийг хүмүүстэй энгийн яриа өрнүүлж байх хооронд бид номлодог байлаа.”¹⁶

Ерөнхийлөгч Хинклигийн оршуулгын ёслол дээр түүний зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг хийж бүтээсэн зарим зүйлийг нь товч дүгнэн ярьсан билээ. Тэр түүний хийж бүтээсэн бүхэнд ямар нэгэн нийтлэг зүйл байгааг анзаарснаа хэлжээ.

“Тэдгээр нь үргэлж хувь хүмүүст боломж олгон адислах зорилготой байсан. Тэр үргэлж ямар нэг боломжоо алдсан болон өдөр тутмын сорилт бэрхшээлтэй мөн Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрахдаа сорилтуудтай тулгарч буй эгэл жирийн хүмүүсийн тухай боддог байв. Нэгээс олон удаа намайг зөвлөгөө өгөх үед тэр миний чээжин дээр хуруугаараа дараад, ‘Хаал, чи зовлон



Дээд талаас цагийн зүүний дагуу: Ерөнхийлөгч Хинкли Массачусетсийн Бостон ариун сүмд; Хэвлэл мэдээллийнхэнтэй хамт байгаа нь; мөн Ганын гишүүдтэй хамт.



бэрхшээлтэй хүнийг бодож санаж байсан уу?” гэж хэлж байсан”¹⁷

Ирээдүйг бошиглосон алсын хараа

Ерөнхийлөгч Хинклигийн өөдрөг үзэл, хувь хүмүүст тавьдаг анхаарал халамж нь ирээдүйн талаарх бошиглослын суу билэгт алсын хараатай хосолсон байсан юм. Уг алсын хараа нь голчлон ариун сүмүүдэд төвлөрсөн байв. Ерөнхийлөгч Хинкли ариун сүмийн ёслолуудыг “Сүмийн өгч буй хамгийн эрхэм дээд адислал юм”¹⁸ гэж онцолсон байдаг.

Түүнийг 1995 онд Сүмийн ерөнхийлөгч болох үед дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй 47 ариун сүм байжээ. Түүний удирдлаган доор Сүм тавхан жилийн дотор энэ тоог хоёр дахин өсгөв. Түүний ариун сүмүүдийн талаар тавьсан зорилго эрс шийдэмгий, өргөн цар хүрээтэй байсан боловч энэ бүгдийн эцсийн зорилго нь хувь хүмүүсийг нэг бүрчлэн адислах явдал байсан юм.

Ариун сүмүүдийг барих энэхүү шинэ эрийн үеийн талаарх сүнсэлэг өдөөлт ерөнхийлөгч Хинклиг 1997 онд Мексикийн Колониа Хуарэз руу Сүмийн сургуулийн 100 жилийн ойг тэмдэглэхээр явах үед иржээ. Тоос татсан замаар удаан аялах үедээ тэр гүн бодолд дарагдсан байв. Түүний нарийн бичиг Дон Х.Стахэли “Үнэхээр таг чимээгүй болсон. Тэгээд би илчлэлт ирж байгааг ойлгосон. Тэрээр урьд нь жижиг ариун сүмүүдийн талаар бодож байсан ч тэр үед арай л өөр арга зам санаанд нь орсон юм”¹⁹ гэж дурсан ярьжээ.

Ерөнхийлөгч Хинкли энэ үйл явцыг хожим нь дараах байдлаар дүрсэлсэн байдаг. “Энэ хүмүүсийг ариун сүмтэй болгохын тулд юу хийж болох тухай би өөрөөсөө асууж билээ. . . . Ийн бодох зуур нэгэн бодол оюун санаанд минь орж ирсэн. . . . Бид ариун сүмийн бүхий л нэн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг харьцангуй жижигхэн ариун сүмд багтааж барьж болно. . . . Би төлөвлөгөө гаргаж эхэлсэн. . . . Тов тодорхой, бүрэн дүүрэн дүр зураг оюун санаанд минь орж ирсэн. Би үүнийг Их Эзэнээс ирсэн сүнсэлэг өдөөлт, илчлэлт байсан гэдэгт бүх зүрх сэтгэлээрээ итгэдэг. Би гэртээ хариад, энэ тухайгаа зөвлөхүүддээ хэлтэл тэд зөвшөөрсөн юм. Дараа нь Арванхоёрт танилцуулахад тэд бас зөвшөөрсөн.”²⁰

Дөрвөн сарын дараа Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Хинкли том ариун сүм барихад хангалтгүй тооны гишүүнтэй бүсүүдэд Сүм жижиг ариун сүмүүд барьж эхлэх тухай түүхэн зарлалыг хэлсэн. Тэр “Бид хүмүүсийг ариун сүмтэй болгож, тэднийг ариун сүмийн шүтлэг бишрэлээс ирдэг маш үнэ цэнтэй адислалуудын боломж бүрээр хангахаар зориг шулуудсан” гэж хэлжээ.²¹

Дараагийн Ерөнхий чуулганаар ерөнхийлөгч Хинкли 2000 оны сүүл гэхэд үйл ажиллагаагаа явуулж буй 100 ариун сүмтэй болох төлөвлөгөөг танилцуулснаар бас нэгэн түүхэн зарлалыг хэлжээ. “Бид урьд өмнө хэзээ ч ийм өргөн далайцтай ажиллаж байгаагүй” гэж тэр дурдсан байна.²² Тэрээр 1999 оны 4-р сард ариун сүм барих ажлын үйл явцыг тайлагнахдаа “Олон саад бэрхшээлтэй тулгарч байгаа ч энэ нь гайхамшигтай ажил бөгөөд бэрхшээлээс үл хамааран бүх зүйл сайхан болох болно. Бид зорилгодоо хүрнэ гэдэгт би итгэлтэй байна”²³ гэсэн танил үгсийг хэлсэн юм.

2000 оны 10-р сард ерөнхийлөгч Хинкли АНУ-ын Массачусеттс мужийн Бостон хот руу Сүмийн 100 дахь ариун сүмийг онцгойлон адислахаар явсан нь тухайн жилдээ дөрвөн тивд онцгойлон адисалсан 21 ариун сүмийн нэг байлаа. Түүнийг нас барахад 124 ариун сүм баригдаж дуусан, 13 ариун сүм баригдаж байгааг зарлажээ.

Ерөнхийлөгч Хинклигийн ирээдүйн талаарх алсын хараа нь Бурханы хүүхдүүдийг адислах өөр бусад арга замын талаар илчлэлт эрэлхийлэхэд түүнийг удирдсан юм. Тэрээр нүдээрээ олж харсан зовлон бэрхшээл, ядуурлаас болж сэтгэл нь шаналж байсан бөгөөд Сүмийн маш том хэмжээний хүмүүнлэгийн ажлыг удирдаж, үүнд ихэнхдээ Сүмийн гишүүн бус хүмүүсийг хамруулсан байв. Мөн тэрээр ядуу буурай орнууд дахь Сүмийн гишүүдэд туслахын тулд Тасралтгүй Боловсролын Санг үндэслэн байгуулжээ. Тэд энэ сангаас илүү сайн ажилтай болохын тулд шаардлагатай боловсролыг эзэмшихэд шаардагдах зээл авах боломжтой болсон. Энэ нь тэдэнд ядуурлын гинжийг тасдан, бие даасан болоход тусалдаг. 2016 оны байдлаар 80000 гаруй хүн энэхүү сангийн зээлээр дамжуулан боловсрол олж авч, сургалтад хамрагдах боломжтой болсон байна.

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” Чуулганы төвийг барих ажил зэрэг ерөнхийлөгч Хинклигийн бошиглосон зорилгуудын олон жишээ *Teachings of Presidents of the Church: Gordon B. Hinckley* номонд байдаг.



“Миний гэрчлэл”

Ерөнхийлөгч Хинкли 91 нас хүрэхээсээ хэд хоногийн өмнө “Би дахиад мод тарих шаардлагагүй ч тарьсаар

байх болно. Энэ бол миний төрөлх зан”²⁴ гэж хэлжээ. Залуу номлогч байсан ч эсвэл 97 настай бошиглогч байсан ч дэлхий даяарх хүмүүсийн зүрх сэтгэлд сайн мэдээний үрийг суулгаж, арчилж тордох нь түүний төрөлх чанар байсан юм. Тэрээр 20 жилийн турш Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр, дараа нь 14 жилийн турш Тэргүүн Зөвлөлийн зөвлөхөөр үйлчилжээ. Тэрээр 84 насандаа Сүмийн ерөнхийлөгч болсноосоо хойш 13 жилийн турш үсрэнгүй өсөлт хөгжилтийг авчирсаар байв.

Ерөнхийлөгч Хинклигийн амьдралын хамгийн чухал хэсэг Есүс Христийн тухай болон бошиглогч Иосеф Смитийн сэргээсэн Түүний сайн мэдээний тухай гэрчлэл байсан. Тэрээр нэгэн Ерөнхий чуулган дээр “Миний гэрчлэл” үгийг хэлэхдээ үе үе нулимс унаган, дараах гэрчлэлийг хуваалцсан юм.

“Өнөө өглөөний миний хамгийн их талархаж байгаа мөн онцгой санагдаж байгаа зүйл бол Есүс Христийн тухай бодит гэрчлэл юм. . . .

Тэр бол миний Аврагч бас миний Гэтэлгэгч. Тэр үгээр дүрслэхийн аргагүй зовж шаналан, Өөрийн амийг өгснөөр үхлийн дараах мөнхийн харанхуйн гүн ёроолоос намайг болон бидний хүн нэг бүрийг, Бурханы бүх охид, хөвгүүдийг өргөн гаргахаар доош бууж ирсэн юм. . . .

Тэр бол миний Бурхан бас миний Хаан. Мөнхийн мөнхөд Тэрээр хаадын Хаан, эздийн

Эзэнээр хаанчилж, засаглах болно. Түүний эзэгнэлд төгсгөл гэж үгүй. Түүний алдар сууд шөнийн харанхуй гэж үгүй. . . .

Би талархсан сэтгэл, хэзээ ч үл бөхөх хайраар энэ бүхний талаар Түүний ариун нэрээр гэрчилж байна.”²⁵ ■

ЭШЛЭЛҮД

1. Гордон Б.Хинклигийн хувийн тэмдэглэл, 1993 оны 3-р сарын 22.
2. Гордон Б.Хинкли, *Standing for Something: Ten Neglected Virtues That Will Heal Our Hearts and Homes* (2000), 101.
3. *Teachings of Presidents of the Church: Gordon B. Hinckley* (2016), 70.
4. Жэффри Р.Холланд, “President Gordon B. Hinckley: Stalwart and Brave He Stands,” *Ensign*, 1995 оны 6-р сар, 4.
5. *Teachings of Gordon B. Hinckley*, 339.
6. Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 1969 оны 10-р сар, 113.
7. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 412.
8. Хувийн тэмдэглэл, 1973 оны 11-р сарын 4.
9. *Teachings: Gordon B. Hinckley*, 298–299.
10. Хувийн тэмдэглэл, 1996 оны 5-р сарын 22.
11. Хувийн тэмдэглэл, 1996 оны 5-р сарын 30.
12. Хувийн тэмдэглэл, 1996 оны 6-р сарын 1.
13. Хувийн тэмдэглэл, 2002 оны 2-р сарын 22.
14. “The Prophet Spoke to Youth,” *In Memoriam: President Gordon B. Hinckley, 1910–2008* (supplement to the *Ensign*, 2008 оны 3-р сар), 15.
15. Хувийн тэмдэглэл, 1974 оны 11-р сарын 23.
16. Хувийн тэмдэглэл, 1995 оны 5-р сарын 14.
17. Хэнри Б.Айринг, *Teachings: Gordon B. Hinckley*, 202.
18. *Teachings: Gordon B. Hinckley*, 313.
19. Дон Х.Стахэлигийн амаар хэлсэн түүхийн аудио бичлэг (2012), 85, Сүмийн түүхийн номын сан.
20. Хувийн тэмдэглэл, 1999 оны 3-р сарын 6 Энэхүү эшлэл бол Мексикийн Колониа Хуарез ариун сүмийн анхны онцгойлон адислах хуралдаан дээр түүний хэлсэн үгийн товчлол юм. Ерөнхийлөгч Хинкли жижиг ариун сүмүүдийн тухай 20 жилийн турш боджээ (*Teachings: Gordon B. Hinckley*, 33, 309–310-ыг үзнэ үү).
21. Гордон Б.Хинкли, “Some Thoughts on Temples, Retention of Converts, and Missionary Service,” *Ensign*, 1997 оны 11-р сар, 50.
22. *Teachings of Gordon B. Hinckley*, 310.
23. Гордон Б.Хинкли, “The Work Moves Forward,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 4.
24. Хувийн тэмдэглэл, 1995 оны 6-р сарын 18.
25. *Teachings: Gordon B. Hinckley*, 321–323.





Далын
Ахлагч
Кристоффэл
Голдэн

АВРАГЧИЙН ТУХАЙ ГЭРЧЛЭХДЭЭ НЭН ХҮЧТЭЙ БАЙХ НЬ

Бидний хүн нэг бүр хэцүү бөгөөд шийдвэрлэх цаг мөчид үйлдэхээр дуудагдах болно. Эдгээр мөч бидний хэн гэдгийг болон ямар хүн болохыг тодорхойлно.

Олон жилийн өмнө би залуудаа Өмнөд Африк руу цэргийн алба хаахаар дуудагдсан буюу бидний хэлдгээр цэрэгт татагдсан юм. Намайг хувь хүнийхээ хувьд сайн ч цэргийн албанд үйлчилж байгаа эрчүүдэд л байдаг бүдүүлэг зан байдал, хэл яриа бүхий эрчүүдтэй нэг салаанд хуваариллаа.

Би иймэрхүү уур амьсгалтай орчинд ороод, сайн мэдээний жишгүүдийн дагуу амьдрахад үргэлж тийм амархан байхгүй гэдгийг ойлгосон юм. Гэхдээ би цэргийн албанд үйлчилж эхэлсэн үеэсээ л итгэл бишрэлийнхээ төлөө зогсохыг хүссэн. Би буруу гэдгийг нь мэдэж байгаа аливаа үйл ажиллагаанд оролцохгүй гэдгээ тодорхой гэгч илэрхийлсэн билээ. Манай салааны залуус эхэндээ миний баримталдаг жишгүүдэд дурамжхан байдаг байсан ч сүүлдээ хүндэтгэдэг болсон.

Нэгэн бэлтгэл сургуулилтад гарах үеэр бид үзэсгэлэнтэй, бүртийх ч үүлгүй, одод түгсэн шөнийн тэнгэр доор түүдэг гал тойрон сууж байв. Манай салааны зарим залуу шар айраг ууж, харин би ундаа ууж байлаа. Ямар нэгэн зохисгүй яриа хөөрөөгүй, ид сайхан байж байтал өөр салааны хэдэн залуу манай аз жаргалтай багийнхан дээр айлчлан ирэв. Тэдний нэг нь над руу ирээд, ундаа ууж байгааг минь харан, тэдэнтэй хамт шар айраг уугаагүйд шоолж гарлаа. Нэг найз маань намайг хариу хэлэхээс урьтаж, тэр залууг зэмлэн, бүр гайхмаар зүйл болов.

Тэр “Эрхэм ээ, та эндээс явсан нь дээр байх” гээд, “Кристэй ингэж харьцахыг бид хэнд ч зөвшөөрөхгүй. Үнэндээ тэр бидний дундаас жинхэнэ Христэд итгэгчийн амьдралаар амьдардаг цорын ганц эр” гэж хэллээ.

Зэмлүүлсэн эр шөнийн харанхуйд чимээгүйхэн цаашилсаар алга болов. Би гэнэтийн энэ магтаалд бага зэрэг балмагдсан ч “итгэгч хүмүүст үлгэр дуурайл бол” (1 Тимот 4:12) гэсэн Паулын зөвлөгөөг дагахаар сонгосондоо баяртай байв.

Сүнс тань та нарыг хүлээж буй агуу боломжуудад нээлттэй, хүлээж авахад бэлэн байгаа амьдралынхаа энэ онцгой үед та нар сонголтуудтай тулгарах болно. Та нар 5, 10, 20 жилийн дараа эсвэл бүр амьдралынхаа төгсгөлд өөрсдийнхөө тухай юу бичихийг хүсэх вэ?

Нэн хүчтэй байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Бошиглогч Иосеф Смит амилуулагдаж, шүүгдсэний дараа селестиел хаант улсыг өвлөн авах хүмүүсийн нөхцөл байдлыг дүрсэлсэн нь ариун судруудад цэдэглэсэн хамгийн гайхамшигтай үзэгдэлүүдийн нэгэнд ордог. Сургаал ба Гэрээн дэх энэ хэсэг нь (76-р хэсэг) селестиел хаант улсад тохирохгүй боловч террестриел, телестиел хаант улсыг өвлөн авах хүмүүсийн нөхцөл байдлыг илчилдэг.

Террестриел хаант улсыг өвлөн авагчдын тухай илчлэлтэд тэдгээр нь “хүмүүний башир аргаар харалган болсон дэлхийн шударга сайн хүмүүс . . . [мөн] [Бурханы] бүрэн байдлыг бус, харин түүний алдар сууг хүлээн авсан тэд юм” (С ба Г 76:75–76) гэж заадаг. Тийн бид “Эдгээр нь *Есүсийн тухай гэрчлэлд нэн хүчтэй биш* тэд бөлгөө; иймийн тул, бидний Бурханы хаант улс дээрх титмийг тэд олж авах нь үгүй” (С ба Г 76:79; онцлон тэмдэглэлт нэмсэн) гэдэг гайхамшигтай зарчмыг мэдэж авдаг.

Үүнийг хэсэг хугацаанд төсөөлөн бодоод үз. Бид энэхүү богинохон, мөнх бус, сорилтын байдалд Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байгаагүйгээс болж селестиел хаант улсын алдар суу хийгээд үүний бүхий л гүн гүнзгий, мөнхийн адислалыг алдах гэж үү?

Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Их Эзэний өнөө үеийн нэгэн төлөөлөгч:

“Энэ нь дэлхийтэй хийх тэмцэлд бүхий л хүч чадал, эрч хүч, чадвараа ашиглах мөн итгэлийн сайн тэмцлээр тэмцэх эрэлхэг зоригтой байх явдал юм. . . . Зөв шударга шалтгааны учир нэн хүчтэй байх үндэс нь

бүхий л сайн мэдээний хуулинд дуулгавартай байх явдал мөн.

Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх гэдэг нь ‘Христэд [ирж], түүгээр төгөлдөржи[н]’, ‘бүх бурханлиг бусаас’ өөрсдөө татгалзаж, ‘Бурханыг өөрсдийн хүч хүч, оюун, мөн чадлаар хайрлахыг’ хэлдэг (Моронай 10:32).

Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх нь Христэд болон Түүний сайн мэдээнд гуйвшгүй итгэлтэй байх явдал. Энэ нь дэлхий дээрх Бурханы ажлын үнэн бодит, тэнгэрлэг байдлыг мэдэх явдал юм. . . .

Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх нь ‘найварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх’-ийг хэлнэ. Энэ нь ‘эцсээ хүртэл тэвчих’-ийг хэлнэ. (2 Нифай 31:20.) Энэ нь шашныхаа дагуу амьдарч, номлодог зүйлээ хийж, зарлигуудыг сахих явдал билээ. Энэ нь хүмүүний амьдрал дахь ‘цэвэр ариун сүсэглэл’-ийн илэрхийлэл юм. Энэ нь ‘өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг’ эргэж тойрон, ‘өөрийгөө дэлхийгээс толбогүй’ байлгах явдал мөн. (Иаков 1:27.)

Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх гэдэг нь хүслээ хазаарлаж, дур сонирхлоо хянаж, бие махбодын болон хилэнцэт зүйлсийг ялж гарахыг хэлнэ. Энэ бол бидэнд үлгэр жишээ үзүүлсэн, Эцэгийн хүүхдүүд дундаас хамгийн зоригтой нэгэн болох түүнтэй адил ертөнцийг ялах явдал юм. Энэ нь ёс суртахууны хувьд цэвэр ариун байх, аравны нэгээ төлж, мацаг барих, Хүндэтгэлийн өдрийг хүндэтгэх, зүрх сэтгэлийн дүүрэн зорилгоор залбирах, хэрвээ биднийг дуудвал байгаа бүхнээ тахилын ширээн дээр тавихыг хэлдэг.

Есүсийн тухай гэрчлэхдээ нэн хүчтэй байх гэдэг нь бүхий л асуудалд Их Эзэний талд зогсохыг хэлнэ. Энэ нь Түүнтэй адил сонгохыг хэлнэ. Энэ нь түүний итгэдэг

зүйлд итгэж, боддог зүйлийг бодож, адилхан нөхцөл байдалд хэлж, хийх байсан зүйлийг нь хийж, хэлэхийг хэлнэ. Энэ нь Христийн оюун ухааныг авч, тэрээр өөрийнхөө Эцэгтэй нэг байдаг шиг Түүнтэй нэг байхыг хэлнэ”¹ хэмээн тунхагласан билээ.

Бидний Аврагч, Их Эзэн Есүс Христийн дэлхий дээр байх мөнх бус үйлчлэлийнхээ үеэр заасан зүйлийг би яг одоо нэмж хэлмээр байна.

*Нэн хүчтэй,
зоригтой байх
гэдэг нь шашныхаа
дагуу амьдарч,
номлодог зүйлээ хийж,
зарлигуудыг сахих
явдал билээ.*



“Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү бод. Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм.

Би хүүг эцгийнх нь эсрэг, охиныг эхийнх нь эсрэг, бэрийг хадмынх нь эсрэг болгохоор ирсэн.

Хүний дайсан нь өөрийнх нь гэр бүлийнхэн нь болно.

Эцгийгээ эсвэл эхийгээ Надаас илүү хайрладаг хүн Миний хувьд зохистой нэгэн биш юм. Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрладаг хүн ч Миний хувьд зохистой нэгэн бишээ.

Загалмайгаа үүрээд Миний хойноос дагахгүй хүн Миний хувьд зохистой нэгэн биш.

Амиа ологч нь түүнийгээ алдах болно. Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно” (Матай 10:34–39).

Мөнх бус амьдрал дахь бидний зорилго бол хайрт Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд дахин нэгэнтээ амьдарч, Есүс Христтэй хамт өв залгамжлагчид болох

явдал мөн. Эхнэр нөхөр, үр хүүхэд, бусад гэр бүлийнхээ гишүүдтэй хамт байх мөнхийн гэр бүл дэх гайхамшигтай амьдрал нь зарим хүн энэ амьдралын дараа эдгээр адислалыг хүртэх хэдий ч хүн бүрд боломжтой.

Эдгээр адислал загалмайгаа үүрээд, бидний Их Эзэн Аврагчийн тухай гэрчилж, Түүнд үйлчлэхдээ нэн хүчтэй байхыг шаарддаг.

Үйлдэхэд бэлтгэх

Бидний туулах ёстой зам тоолж барамгүй боломж, сорилт бэрхшээлээр дүүрэн байдаг. Бид өдөр бүр жижиг, чухал биш мөн гүн гүнзгий, мөнхийн үр дагавартай олон шийдвэрийг гаргах шаардлагатай байдаг.

Бид хүнд хэцүү боловч шийдвэрлэх мөчүүдэд үйлдэхээр дуудагдах болно гэдэг нь үнэн боловч хүлээн зөвшөөрөхөд хэцүү зүйл юм. Эдгээр мөч бидний хэн гэдгийг мөн хэн болж чадахыг харуулна. Тэдгээр нь ихэвчлэн хүсээгүй үед мөн зөв шударгаар үйлдэж, эр



зориг гаргахад тохиромжгүй үед ирдэг. Та нар амьдралынхаа түүхийг бичихээр ганцаараа байгаа үед хамгийн шийдвэрлэх мөчүүд ирдэг гэдгийг мэдэх болно.

Би агуу эсэргүүцэл дунд ганцаараа зогссон нэгэн хүний тухай түүхийг хуваалцъя. 1838 оны 11-р сард бошиглогч Иосеф Смит, Парли П.Пратт (1807–1857) нарын зарим хүн АНУ-ын Миссури мужийн Ричмондод гинжлүүлж, шоронд хоригдсон.

Ахлагч Пратт шоронд хоригдож байх үедээ дараах үйл явдлыг бичиж үлдээжээ.

“Бид шөнө дунд өнгөртөл унтаж байгаа юм шиг хэвтэж байсан ба Колонэл Прайс тэргүүтэй харуулуудын ичгүүргүй доог тохуурхал, ой гутам ам тангараг, аймшигт хараал зүхэл болон бохир үг хэллэгүүдийг олон цагийн турш сонссоноос болж бидний чих болон зүрх өвдөн шаналж байлаа. Тэд Фар Вестэд болон эргэн тойрон дахь нутгуудад *мормончуудад* үйлдсэн дээрэм тонуул, аллагынхаа тухай ам уралдан ярьцгааж байв. Тэр бүү хэл эхнэр, охин, онгон охидыг нь хүчирхийлж,

эрэгтэй, эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн толгой руу цохин, буудаж байсан тухай сагсууран ярьцгааж байлаа.

Би жигшиж, цочирдон, айдас төрөм тэдний үгсийг сонсож, зэвүүцэх сэтгэлээр дүүрсэн бөгөөд босож зогсон, харуулуудыг буруушаахаас өөрийгөө арайхийн хорьж байлаа. Гэвч Иосефын хажууд хэвтэж, сэрүүн байсныг нь мэдэж байсан ч түүнд бас хэнд ч юу ч хэлсэнгүй. Гэтэл тэрээр гэнэт ухасхийн босож, аянгын эсвээс архирч буй арслангийнхтай адил дуугаар дараах үгсийг хэлснийг би тун тодхон санаж байна.

‘ЧИМЭЭГҮЙ БАЙЦГАА, тамын шулмасууд аа. Есүс Христийн нэрээр би та нарыг зэмлэн буруутгаж мөн дуугүй байхыг тушааж байна. Би ийм яриаг дахин ганц хором ч сонсож, амьд явж тэвчишгүй нь. Ийм яриагаа зогсоо эсвээс та нар эсвэл би ЯГ ОДОО үхнэ!’

Тэр ярихаа больсон ба туйлын сүр жавхлантай зогсож байлаа. Гинжлүүлэн, буу зэвсэггүй тэнгэр элч мэт тайван зогсох тэрээр айж чичирсэн харуулууд руу

хараа бэлчээх аваас тэдний хөл чичирч, буланд зогсон, түүний хөлд сөхрөөд, уучлалт гуйж байсан ба тэд дараагийн харуулууд солигдох хүртэл чив чимээгүй үлдсэн юм.”²

Бошиглогч Иосеф Смитийн энэ эр зориг бошиглогчдод болон Сүмийн ахимаг настай гишүүдэд л байдаг зүйл биш юм. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн (1838–1918) амьдралд тохиолдсон үйл явдал бас энэ зоригийг харуулдаг. 1857 оны намар 19 настай Жозеф Ф.Смит АНУ-ын Хавайд хийсэн номлолоосоо буцаж ирээд, АНУ-ын Калифорнид битүү тэрэгний багтай нийлжээ. Энэ нь гэгээнтнүүдийн хувьд аюултай цаг үе байлаа. Жонстоны арми Юта руу ирж явсан ба тэд Сүмийн талаар таагүй сэтгэгдэлтэй байв.

Нэгэн орой цөөн танхай этгээд битүү тэрэгний баг руу дайрч, тааралдсан мормон хүн бүрийг харааж, заналхийлэв. Битүү тэргэнд байсан ихэнх хүн бут руу орж нуугдсан ч Жозеф Ф.Смит “Би хамт явж байгаа хүмүүсээ орхиод зугтах гэж үү? Би яагаад тэднээс айх ёстой юм бэ?” гэж боджээ.

Тэр гартаа буу барьсан нэгэн танхай этгээд рүү очтол “Чи мормон уу?” гэж ширүүнээр асуужээ.

Жозеф Ф.Смит “Тийм ээ, эрхэм ээ. Би төрөлхийн мормон хүн. Бүрэн дүүрэн гуйвшгүй үнэнч, итгэлтэй мормон” гэж хариулсан байна.

Тэр үед танхай этгээд түүний гараас бариад, “Чи миний уулзаж байсан хамгийн сайн эр байна! Гар барьцгаая, залуу найз минь, итгэл үнэмшлийнхээ төлөө зоригтой зогсдог залууг харсандаа баяртай байна”³ гэж хэлжээ.

Яг одоо та нар амьдралынхаа хамгийн чухал цаг үед байна! Та нар хоромоор, өдөр өдрөөр өөрсдийнхөө түүхийг зохиож бичиж байна мөн бичих ч болно. Зарим үед та нар үйлдэх хэрэгтэй болно. Харин зарим үед зүгээр л чимээгүй байх хэрэг гарч мэднэ. Ашиглах боломж, гаргах

шийдвэр, даван туулах сорилт олон байх болно!

Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын агуу төлөвлөгөөнд та нар ганцаараа биш гэдгийг үргэлж сана! Энэ амьдралд мөн сүнсний дэлхийд олон хүн яг энэ өдөр Их Эзэний өмнө та нарын өмнөөс гуйж байна. Хүлээн авсан ёслол, хийсэн гэрээгээр тань дамжуулан та нарт агуу хүчийг өгсөн. Хамгийн гайхамшигтай нь та нарын хайрт Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү бидний Аврагч Есүс Христ болох бидний Өмгөөлөгч амьдралд тань та нарт туслахаар та нартай үргэлж хамт байх болно. Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ гүн гүнзгий нөлөө бүхий сургаалдаа бодгаль бүрд, бидний хүн нэг бүрд нэгэн урилга өгсөн юм.

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая.

Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас сураалц. Учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн” (Матай 11:28–30).

Би Мөнхийн Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Их Эзэн Есүс Христийн бодит байдлын талаарх чин сэтгэлийн гэрчлэлээ үлдээе. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол бүхий л арга замаар Их Эзэний сэргээгдсэн Сүм, дэлхий дээрх Бурханы хаант улс юм.

Миний бие болон энэ гэрчлэлийг хуваалцаж буй хүмүүс энэхүү агуу учир шалтгааны төлөө үргэлж нэн хүчтэй зогсох болтугай. ■

2014 оны 6-р сарын 17-нд ХҮТ Бизнесийн коллеж дээр хэлсэн “Нэн хүчтэй байх нь” үгээс эш татав. Англи хэл дээрх бүрэн эхийг ldsbc.edu хаягаар орж үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Брүс Р.Макконки, “Be Valiant in the Fight of Faith,” *Ensign*, 1974 оны 11-р сар, 35.
2. *Парли П.Праттын намтар*, хянасан Бага Парли П.Пратт (1938), 210–211.
3. *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 104-ийг үзнэ үү.



ИТГЭДЭГ ЗҮЙЛИЙНХЭЭ ТӨЛӨӨ ЗОГС

“Бид өөрсдийнхөө итгэдэг зүйлсийн төлөө зогсох зоригтой мөн бэлтгэлтэй байх болтугай. Хэрэв бид ганцаар зогсох хэрэгтэй болсон үед, би Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт байхад хэзээ ч ганцаардахгүй гэсэн бодит мэдлэгээр хүчирхэгжин, үүнийг зоригтой хийх болтугай.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Ганцаар зогсох зоригтой бай,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 74.



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

Ахлагч Гари
Э.Стивэнсон

ОЛЖ АВСАН БҮХНЭЭРЭЭ УХААНЫГ ОЛЖ АВ

Жинхэнэ ойлголт таныг судлах, залбирах хоёрыг хослуулахаа ухаарах үед болон суралцах, олж авах үедээ үйлчлэх үед мөн Их Эзэн Есүс Христэд итгэн, найдах үед ирэх болно.

Миний их сургуулийн оюутны амьдралын ихэнх цаг номын сангийн эргэн тойронд өнгөрсөн юм. Намайг орох тоолонд “Олж авсан бүхнээрээ ухааныг олж ав” (Сургаалт үгс 4:7) гэж хаалган дээр бичсэн уриа утгадаг байлаа.

Бид бүгд дахин давтаж хийсний дараа сайн санадаг гэдгийг мэддэг. Тийм ч учраас Сургаалт үгсийн энэ судрыг оюун санаандаа мартагын аргагүйгээр тогтоон, бакалаврын дөрвөн жилийн туршид номын санд орох болгондоо уншдаг байв.

Би та бүхнийг яг ингэж “Олж авсан бүхнээрээ ухааныг олж ав” гэж уриалъя. Би та нарт энэ судрын утгыг болон танд ямар тустай байх талаар тунгаан бодоосой хэмээн уриалж байна. Би үүнийг хийдэг. Намайг оюундаа ахин дахин тунгаахад утгынх нь хөрвүүлэг үнэхээр илэрхий болсон. Миний ажиглаж ойлгосон зүйл та бүгдэд ач тусаа өгч магадгүй.

Бусдыг ойлгох зүрх сэтгэл

Японд залуу номлогч байхдаа би хэцүү хэлийг сурах гэж ихэд чармайн, зарим үгийг байн байн сонсдог байв. Тэрхүү үгсийн хоёр нь *Охаяо гозаймасу*

(өглөөний мэнд) эсвэл *конничиwa* (өдрийн мэнд) гэх мэт мэндлэх үгс байв. Өөр бас нэг үг бол *вакаримасэн* “Би ойлгохгүй байна” гэсэн үг байлаа. Энэ үг гараа дэлгэх дохио зангаатай хамт залуу номлогчдыг яриа өрнүүлэхийг оролдох үед япончуудын хэлэх дуртай үг болсон юм шиг санагддаг.

Би эхлээд “Олж авсан бүхнээрээ ухааныг олж ав” гэсэн үгийн утгыг бодохдоо *ухаан* гэдэг үгийг чихээрээ сонсох, оюундаа ойлгох гэдгээс илүүтгээр боддог байв. *Вакаримасэн* гэсэн япон үгийн талаар би боддоо. Би ойлгож байна уу эсвэл ойлгохгүй байна уу?

Судар болон амьд бошиглогчдын үгэн дэх *ухаан* гэсэн үгийг судлаад, ойлгосон хэдий ч илүү гүн утгатай болохыг би мэдсэн. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлсийн Сүмийн тэргүүлэх бишоп байсан үедээ хэлсэн дараах үгийг бодож үз.

“Эхэндээ бид эхээс төрөх үеийн оюунаараа эхэлдэг. Бид оюун ухаандаа асуултын хариултыг эрж хайн, судалж, өөрсдийгөө боловсруулж байх үедээ мэдлэг нэмж авдаг. Мөн бид өөрсдийн

Planet Nine?

silver
47

Ag

107.868

gold
79

Au

196.967

aurum





ИХ ЭЗЭНД БОЛОН ТҮҮНИЙ ҮГЭНД ИТГЭ

“Итгэлийн үлгэр жишээ байна гэдэг нь бид Их Эзэнд болон Түүний үгсэд итгэдэг гэсэн үг юм. Энэ нь бодол санаа, үйл хөдлөлийг маань удирддаг тийм итгэлийг бид эзэмшиж мөн хадгалдаг гэсэн утгатай. Бидний Их Эзэн Есүс Христэд болон Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэл маань бидний хийдэг бүх зүйлд нөлөөлөх болно. Бидний үе дэх эргэлзээ, ухамсрын зөрчилдөөн, өдөр тутмын амьдралын үймээн самуун дунд байнгын итгэл маань бидний амьдралын зангуу болдог.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Үлгэр жишээ мөн Гэрэл байгтун,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 75.

Бид ойлгохын тулд Ариун Сүнснээс залбирлаар дамжуулан мэдлэг, туршлага, мэргэн ухаан болон тусламж хүлээн авдаг. Ингэсэн тохиолдолд л бид зүрх сэтгэлээрээ ойлгох болно.



мэдлэг дээр мэргэн ухааны түвшинд хүргэх туршлагаа нэмэрлэдэг. Мэргэн ухаан дээрээ бид сүнслэг удирдамж, хүч чадал гүйн, итгэлийн залбирлаараа дамжуулан Ариун Сүнсний тусламжийг нэмж авдаг. Тэгээд зөвхөн тэр үед л ‘алив зүйл тохиовч зөвийг хийхэд’ хөтлөх зүрх сэтгэл дэх ухааныг олж авна. (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, д. 34). Зүрх сэтгэл дэх ухааныг мэдрэмжүүд нь бидэнд нөхцөл байдлаас үл хамааран зөвийг мэдэх, хийх баталгааг өгдөг. Зүрх сэтгэл дэх ухаан нь судлах, залбирахыг нягт хослуулахаас ирдэг.”¹

Одоо дахиад “Олж авсан бүхнээрээ ухааныг олж авах” гэсэн үгийг эргэцүүлэн бод. Энэ хам сэдэвт ухаан гэдэг нь оюун ухаан, мэдлэг, туршлага, мэргэн ухаан, Ариун Сүнсний өдөөлт зэргийн дараа ирдэг бөгөөд эдгээр нь бүгд юуг зөв болохыг мэдэж, түүнийг хийхэд хүргэдэг.

Та нарын олонх нь амьдралдаа чухал эгзэгтэй үеийг дайрч өнгөрдөг. Жил өнгөрөх тусам та илүү бие дааж, амьдралынхаа “олж авсан бүхэн” рүүгээ илүү гүн гүнзгий орж байдаг. Таны олж авах гээд байгаа зүйл юу вэ? Та хань ижил, гэр бүл, ажил гээд хэд хэдэн зүйл олж авах гэж байгаа байх.

Бид “олж авах” эдгээр чухал зүйлийг зохицуулахын тулд судрын заасан “ухаан”-ыг бас олж авах ёстой. “Энэ ухаан нь судлах, залбирахыг хослуулсны үр дүнд ирдэг. Бас бид Их Эзэн Есүс Христэд итгэж найдах ёстой. Алма үүнийг дүрслэхдээ үгийг үртэй зүйрлэжээ. Тэрээр “энэ нь ойлголтыг минь тэлж эхлэв; тийм ээ, энэ нь надад амтат байх болж эхлэв” гэжээ (Алма 32:28; тодотгол нэмэгдсэн).

Ерөнхийлөгч Томас С.Монсон Сургаалт үгсээс энэ ойлголтод нэмэх өөр нэг судар болох “Бүх зүрхээрээ Их Эзэнд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ” (Сургаалт үгс 3:5) гэсэн судрыг байнга эш татдаг.²

Бид Их Эзэнд итгэж, найдсанаар бидний зүрх сэтгэл рүү илүү их ойлголт Түүнээс орж ирдэг юм.

“Их Эзэний мутар биднийг хамгаалж байна”

Өөрийн ойлголтод тулгуурлалгүй, Их Эзэнд найдан, Сэргээлтэд чухал үүрэг гүйцэтгэсэн нэгэн хүчирхэг эмэгтэйн жишээг хэлэхийг зөвшөөрнө үү.

Нью-Йоркийн Палмирад Сүм байгуулагдаад удаагүй байхад Иосеф Смитийн эх Люси Мак Смит нөхөр Иосефоо хүү Иосеф болон өөр хэдэн хүүтэйгээ

түрүүлээд Огайгийн Көртланд руу явсны дараа Нью-Йоркийн Вотэрлу гэдэг газар олон гэгээнтэнтэй хамт үлджээ. Тэрээр бошиглогч хүүгээсээ Огайо руу энэ хэсэг бүлэг хүнийг аваачих захиас авч, үүрэг хүлээсэн байв.

Захиас 1831 оны хаврын эхээр ирсэн байжээ. Люси хэдэн ахын тусламжтайгаар хүмүүсийг Нью-Йоркийн Бафалло руу нүүлгэж эхэлсэн бөгөөд Эри нуурыг хөлөг онгоцоор гатлах санаатай байв. Тэрээр “Ах нарыг хавар усаар аялах цаг болсон гэж үзсэн үед бид бүгд Көртланд руу нүүхэд бэлтгэж эхэлсэн. Бид завь хөлслөв . . . ; бас . . . бид наян бодгаль байв” гэж хэлжээ.

Тэднийг Баффало руу Эри сувгаар усан онгоцоор явж байхад тэрээр “Би тэгээд ах, эгч нарыг хамтад нь дуудаад, бид Эцэг Лихай Иерусалимыг орхин, Их Эзэний зарлигийг даган аялсан шиг аялж байгаа бөгөөд хэрэв итгэлтэй байх юм бол Бурханы адислалыг хүлээн авах адил шалтгаан бий гэж сануулсан. Тэгээд би тэднээс амжилттай байж болохын тулд цог жавхлантай байхыг мөн *үргэлжлүүлэн залбирч, Бурханд зүрх сэтгэлээ өргөхийг* хүссэн” хэмээн хэлжээ.

Баффалогаос Вотэрлу орох замын яг талд нь хүрэх үед сувгаар дайран өнгөрөх зам улам хэцүү болж эхэлжээ. Наян гэгээнтний нөхцөл байдал хүндэрч, тав тухгүй болсон бөгөөд тэр даруй бувтналдаж эхлэв. Люси Их Эзэний хүч чадалд найдан, тэдний итгэлийг нэгдмэл байлгах шаардлагатай болсон байна. Тэрээр “Та нар . . . өлсөхгүй мөн иймэрхүү зүйл ч болохгүй, ах нар аа, гагцхүү тэвчээртэй байж, бувтналдахаа боль. Би өчүүхэн ч эргэлзэхгүй байна. Их Эзэний мутар биднийг хамгаалж байгаа” гэж хэлжээ.

Тэднийг Вотэрлугээс гараад тав дахь өдрөө Баффалод ирэхэд Эри нууранд хүргэх боомтын ус хөлдсөн байв. Тэд Люси Смит болон түүний гэр бүлийнхний танил ахмад Блэйкийн онгоцоор явав.

Хэд хоног өнгөрөхөд усан онгоцны нөхцөл байдал тэдэнд бүгдэд нь явах цагаа хүлээхэд тохиромжтой байгаагүй ч Люси “Ахмад Блэйк зорчигчдыг дохио өгч, явж эхлэхэд бэлэн болох хүртэл онгоцон дээрээ үлдэхийг хүссэн. Түүний зэрэгцээ мөсний зузааныг хэмжих нэг хүнийг илгээсэн бөгөөд тэр хүн мөсний зузаан зургаан метр болсон тул эрэг дээр дахин хоёр долоо


хоног хүлээх хэрэгтэй гэсэн санал хэлж ирсэн” хэмээн мэдэгджээ.

Энэ нь хүмүүсийг цочирдуулсан мэдээ байв. Хангамж муутай, нөхцөл байдал хэцүү байлаа. Люси Мак Смит “Та нар Бурханд итгэл найдвараа тавьдаг гэж хэлдэг атлаа яаж бувтналдаж, гомдол хэлж чадаж байна аа! Та бүгд Израилийн хүүхдүүдээс ч илүү ухаангүй байна. Учир нь энд эгч нар маань түшлэгтэй сандлаа мөрөөдөн санагалзаж, эрч хүч, эрс шийдэмгий байна хэмээн хүлээж байсан ах нар аяллынхаа төгсгөлд хүрэхээс өмнө өлсөж үхнэ гэдэгтэй баттай итгэж байгаагаа тунхаглаад байна. Тэгвэл яагаад ийм байгаа юм бэ? Та нарын хэн нэг нь ямар нэг зүйлээр дутаж байсан уу? . . . Та нарын итгэл хаачив аа? Бурханд итгэх итгэлтэй байдал тань хаана байна вэ? Түүгээр бүх зүйл бүтээгдсэн, тэрээр өөрийнхөө мутраар ажлаа удирддаг гэдгийг ухаарахгүй байна гэж үү? Энд байгаа бүх гэгээнтэн бидний өмнө зам нээгдэж болохын тулд Бурханд хандан залбирч, зүрх сэтгэлээ Түүнд хандуулбал биднийг аян замдаа гарах мөчид мөсийг хага зүсэх нь түүний хувьд хэчнээн хялбар байх билээ!” хэмээн зэмлэсэнэ бичжээ.

Одоо Смит эхийн агуу итгэлийг буюу түүний Бурханд итгэхээ хэрхэн сонгосныг болон тэрээр гэгээнтнүүдээс өөрсдийн ойлголтонд түшиглэхгүй байхыг хүссэнийг анхааралтай унш.

“Ах эгч нар минь, мөс хагарч, бид явах боломжтой болоосой гэж та нар тэнгэрт хандан хүслээ өргөх юм бол Их Эзэн амьдын адил энэ нь хийгдэх болно.” Яг тэр мөчид аянга цахих мэт дуу чимээ сонсогдов. Усан онгоцны ахмад “Хүн бүр байрандаа оч” гэж хашгираа. Мөс хуваагдан, усан онгоцонд явах зам арай чүү гарсан бөгөөд онгоц дөнгөж л явж өнгөрөх төдий нарийн зам байв. Усан онгоцны сэнс мөсийг хэдэн хэсэг болон хагалах чимээ, ахмадын тушаах үгс, далайчдын хариу хашгирах сөөнгөтсөн хоолой, харж байсан хүмүүсийн хашгираан, самуун бүгд тэр үеийн болсон үйл явдлын үнэхээр аймшигтай дүр зургийг илэрхийлнэ. Биднийг дөнгөж дундуур нь гарсны дараа мөс дахин нийлж, Колесвиллийн ах нар биднийг дагаж чадалгүй Баффалод хоцров.

Эргээс биднийг хөдөлмөгц эрэг дагуу байсан хүмүүс “Мормон” компани хөдөллөө! Тэр онгоц усанд есөн



*Люси Мак Смит гарах
гарцгүй болсон ах, эгч
нарыг бутналдахаа
болиод, тэнгэр рүү хүс-
лээ өргөхөд урамшуулан
дэмжсэний дараа, “мөс
хуваагдан, усан онгоц
дөнгөж явах төдий зам
гарсан” хэмээн хэлжээ.
Гэгээнтнүүдийн онгоцыг
явж өнгөрмөгц, мөс эргээд
нийлсэн юм.*

ямх доошилсон байна. Тэр онгоц живэх болно. Живэх нь баттай боллоо' хэмээн дуу алдаж байв. Үнэндээ тэд биднийг живнэ гэдэгт бат итгэлтэй байсан бөгөөд биднийг живсэн гэсэн мэдээг сонинд гаргахаар сонинны газар руу шууд явсан байв. Бид Фэйрпортод ирээд, сонинуудад биднийг амь үрэгдсэн тухай бичсэнийг олж уншсан юм.”³

“Өөрийн ойлголтод бүү түшиглэ”

“Олж авсан бүх зүйлээрээ ухааныг олж ав” буюу өөрөөр “Бүх зүрхээрээ Их Эзэнд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ” (Сургаалт үгс 3:5).

Би хувьдаа дэлхийн арга замаар “олж авах” дээр түлхүү анхаараад, Их Эзэний “ойлголт” дээр түшиглэдгүй хүмүүсийн дээр уй гашуу, гай гамшиг ирдгийг харж байсан. Өөрсдийн ойлголтон дээр түшиглэдэг эсвэл маханбодын гарт найдлага тавьдаг хүмүүс материаллаг байдлыг олж авах, нэр алдар, эрх мэдэл, байр суурийн төлөө тун хэмжээг нь тааруулахгүй анхаарал тавьж, хэт шунан зүтгэх хандлагатай байдаг юм шиг санагддаг. Гэхдээ “олж авах”-ыг “ойлголт өгөх” судрын удирдамжтай хослуулах нь таны энэ дэлхийн дур таашаалыг багасгах болно. Энэ нь танд нийгмийн болон Их Эзэний хаант улсын үр бүтээлтэй гишүүний хувьд үйл ажиллагаанд оролцохдоо зөв нөхцөл байдлыг бий болгоно.

Би хүсэл тэмүүлээр дүүрэн оюутан байхдаа “суралц, олж ав, үйлчил” гэсэн захирамжийн дагуу өөрсдийн дэвших гэсэн хүсэл эрмэлзлийг зөв удирдах ёстой гэж нэгэн хүндэтгэл хүлээсэн, амжилттай яваа багшаасаа сонсож байснаа санаж байна. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Их Эзэнд итгэж, өөрсдөдөө найдахаас илүү Түүнд найдахад хүргэдэг нэгэн загварыг зааж өгсөн. Тэрээр “Бидний хүн нэг бүрд дөрвөн үүрэг байна. Үүнд: Бидэнд Нэгт, гэр бүлийнхнийхээ өмнө, Хоёрт, ажил олгогчдынхоо өмнө, Гуравт, Их Эзэний ажилд, Дөрөвт, өөрсдийнхөө өмнө хүлээх хариуцлага гэж бий” гэжээ.

Бид тэнцвэртэй байдлыг хадгалах ёстой. Ерөнхийлөгч Хинкли гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, гэр бүлээрээ судраас судлах, ажил олгогчдоо үнэнч шударга хандах, Сүмд хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх, хувиараа судраас судлах, амралт, чөлөөт цагийг

хөгжилтэй өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн хийх зэргээр дамжуулан тэрхүү дөрвөн үүргийг биелүүлэхийг санал болгосон.⁴

Америкийн философич, яруу найрагч Ральф Уолдо Эмерсон “Энэ цаг бол хэрэв бид тэр цагийг хэрхэн ашиглахаа мэддэг бол бусад цагийн адил бас л сайхан цаг юм” хэмээн хэлжээ.⁵

Аз болоход, хожмын үеийн гэгээнтнүүд юу хийхээ мэдэхийн тулд холоос эрэх шаардлагагүй. Та Тэнгэрлэг Эцэгийн тухай болон аз жаргалын агуу төлөвлөгөөний тухай мэдсэнээрээ усанд залууртайгаа байна. Одоо сэлүүрээ усанд гүнзгий дүрж, хүчтэй бөгөөд нэгэн жигд хурдаар сэлүүрд.

Нэгэн Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Монсон Сургаалт үгсээс “Бүх зүрхээрээ ЭЗЭНД итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ” гэсэн хэсгийг эш татсан. Өөрийн бүх арга замаар Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно” гээд, тэрээр “энэ бол миний амьдралын түүх юм” хэмээн хэлжээ.⁶ Даган дуураймаар ямар гайхалтай амьдрал вэ.

Эцэг, Хүүгийн нэгэн адил би та нарын хүн нэг бүрээс маш том зүйл хүлээж байдаг. Би үгээ эхлэхдээ хэлсэн Сургаалт үгсийн “Олж авсан бүхнээрээ ухааныг олж ав” гэсэн хэсгийг дахин хэлье.

Жинхэнэ ойлголтыг олж ав. Жинхэнэ ойлголт таныг судлах, залбирах хоёрыг хослуулахаа ухаарах үед болон суралцах, олж авах үедээ үйлчлэх үед мөн Их Эзэн Есүс Христэд итгэн, Түүнд найдах үед ирэх болно. ■

2015 оны 1-р сарын 14-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “Өөрийн ойлголтод бүү тулгуурла” үгээс авав. Англи хэл дээрх бүрэн эхийг уншихыг хүсвэл speeches.byu.edu хаягаар орж үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Робэрт Д.Хэйлс, “Making Righteous Choices at the Crossroads of Life,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 10; тодотгол нэмэгдсэн.
2. Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Хаалтын үг,” *Liahona*, 2010 оны 5-р сар, 112-ыг үзнэ үү.
3. Люси Мак Смит, *History of Joseph Smith by His Mother; Lucy Mack Smith* (1979 он), 195–199, 202-205-ыг үзнэ үү. Тодотгол нэмэгдсэн.
4. Гордон Б.Хинкли, “Rejoicing in the Privilege to Serve,” *Дэлхий даяарх удирдагчдын сургалт*-ыг үзнэ үү, 2003 оны 6-р сарын 21, 22, 23.
5. Ральф Уолдо Эмерсон, “The American Scholar,” 1837 оны 8-р сарын 31, Кэмбрижийн Их сургууль дээр хэлсэн үг.
6. Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Хаалтын үг,” 112; Сургаалт үгс 3:5–6-аас эш татав.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ НАС ХАРГАЛЗАХГҮЙ ХҮНДЛЭХ НЬ

Намайг нэг ням гарагт Аароны санваартнуудад эмэгтэйчүүдийг хүндлэх талаар хичээл заа хэмээн дуудсан юм. Хичээлийн үеэр нялх хүүхдээс эхлээд насанд хүрсэн бүхий л эмэгтэйчүүдийг хүндэтгэж байх тухай Аароны санваарын гарын авлагад заасныг бид ярилцаж билээ.

Ангид байсан залуу эрэгтэйчүүдийн нэг болох Габриэл (нэрийг өөрчлөв) эмэгтэй хүн бол түүний эх байхаар настай байна, түүнээс дүү эмэгтэйчүүд харин түүнийг эр хүнийх нь хувьд хүндлэх ёстой гэж үздэгээ хэлэв. Ангид байсан хүмүүсээс хэн нь ч түүнтэй санал нийлэхгүй байв. Энэ нь түүний хувьд итгэмээргүй зүйл байлаа.

Бид эмэгтэйчүүдийг хүндлэх арга замуудын талаар үргэлжлүүлэн ярилцаж, би тэдэнд өөрийнхөө хийдэг нэг зүйлийг буюу нийтийн тээврийн хэрэгсэлд эмэгтэй хүн орж ирэхээр очих газар хүртлээ 30–40 минут явахаар байсан ч суудлаа тавьж өгдөг гэж хэлсэн юм.

Удалгүй нэгэн настай эмэгтэйг орж ирэхэд би босоод, суудлаа тавьж өгөв.

Би тэдэнд эрэгтэй хүмүүс зогсоод, эмэгтэй хүмүүс суудалд суух ёстой гэж хэлэв. Габриэл хичээлд тийм ч их дуртай биш байв.

Хоёр өдрийн дараа би автобусанд ороод, урд суудалд суув. Бүх суудал хүнтэй байсан бөгөөд нэг эрэгтэй охиныхоо хамт орж ирээд, автобусны хойд хэсэг рүү явав. Удалгүй нэгэн настай эмэгтэйг орж ирэхэд би босоод, суудлаа тавьж өгөв.

Нэг эрэгтэй миний мөрөн дээр тогшоод, ар тийшээ зааж, нэг залуу намайг дуудуулсан гэж хэллээ. Би хойшоо алхаад, тэр залуу хэн байсныг мэдэхийг хүсэв. Тэр залууг саяхан дөрвөн настай охинтойгоо автобусанд орж ирсэн хүнд суудлаа тавьж өгсөнд ойролцоох хүмүүс нь тун баяртай байсан. Тэр залуу бол Аароны санваарын ангид эмэгтэйчүүдийг хүндлэх тухай хичээлд тийм ч дуртай байгаагүй Габриэл байлаа.

Тэрээр “Би таныг автобусанд орж ирсэн эмэгтэйд суудал тавьж өгөх


нь үү, үгүй юу гэдгийг ажиглаж байсан юм. Тэгээд таны хийсэн зүйлийг хараад, миний сэтгэл их хөдөллөө. Ням гаргийн хичээлээ санаад, бяцхан охин, аав хоёрт суудал тавьж өгөх болсон” гэж хэлж билээ.

Сүм дээр заалгасан зүйлийнхээ дагуу амьдардаг залуу эрэгтэйчүүдийг харахдаа би хэчнээн баяртай байдаг гээч. Тэрээр зөвхөн настай эмэгтэйчүүдийг л хүндэлнэ гэж боддог байсан бөгөөд тэрхүү ням гаргийн хичээлээс хойш дөрвөн настай охиныг ч хүндлэхээр шийджээ.

Би ч бас заасан зүйлийнхээ дагуу амьдарч, бүх насны эмэгтэйчүүдийг хүндлэх талаар суралцахад нь түүнд тусалсандаа баяртай байв. Хэрэв би автобусанд орж ирсэн эмэгтэйд суудал тавьж өгөөгүй бол түүнд ямар санагдах байсан бол доо гэж надад бодогддог. “Хэрэв та нар эдгээрийг мэдэж, үйлдвэл та нар ерөөлтэй” (Иохан 13:17) гэсэн судрын хэсэг санаанд минь орж ирэв. ■

Өүи Осарэтин Фрайдэй, Эдо, Нигер





Өвөг эцгийнхээ хэсэг рүү очих хүртэл нэг шугамаас нөгөө рүү Ариун Сүнс намайг хөтөлж байгаа нь эргэлзээгүй байлаа.

ОДОО ХЭН БЭЛЭН БАЙНА ВЭ?

Нэгэн Ерөнхий чуулганы төгсгөлийн хуралдаан болсон ням гарагт би Гэр бүлийн хайлтын систем рүү нэвтэрч, гэр бүлийн түүхийн ажлаа хийх онцгой сүнслэг өдөөлт мэдэрсэн юм. Би урьд өмнө хэд хэдэн удаа хийх гэж оролдож үзээд, бүтэлтэй болоогүй учир гэр бүлийн түүхийн ажлыг хийхдээ хойрго хандаг байв. Гэр бүл маань гэр бүлийн түүхийн ажлаа сайн хийдэг болохоор би тэр үед надад ч хийх юм байхгүй дээ гэж боддог байж билээ.

Би сууж, урамгүйхэн санаа алдахдаа олон жилийн туршид оролдож үзээд мухардалд орсноо харан, ямар нэгэн мэдээлэл нэг л өдөр олдоно гэж найдаж байв. Хүн амын тооллого, гэрлэлт, төрсний гэрчилгээнээс хайж эхлээд, нэг цаг болсон ч би юу ч олсонгүй. Тэгтэл Ариун Сүнс тэр Ерөнхий чуулганы хуралдаанаар

дамжуулан долоо хоногийн сүүлийн өдрүүдийн туршид ажил нь хийхэд бэлэн болсон хүмүүсийг олж мэдэхийн тулд залбир гэсэн өдөөлт өгч байсан ажээ.

Би залбираад, өөрийнхөө нэр рүү очин, тэгээд шугамаар нь цааш урагшлуулав. Өвөг эцгийнхээ хэсэг рүү очих хүртэл нэг шугамаас нөгөө рүү Ариун Сүнс намайг хөтөлж байгаа нь эргэлзээгүй байлаа. Дараагийн нэг цагийн туршид Ариун Сүнс өрөөг дүүргэн, би ариун сүм рүү авч явах зургаан нэртэй боллоо. Би ариун сүмд нэрс явуулах хүсэлт илгээж дуусаад, мэдээлэл авсан бүртгэлийнхээ заримыг доош гүйлгэн харав. Мэдээлэл миний өвөг дээдсийн бүртгэлийг оруулахаар сайн дураараа цагаа зориулсан индексжүүлэлт хийсэн хүмүүсээс ирсэн болохыг мэдээд, зүрх сэтгэл

минь баяр хөөрөөр дүүрч, би нүдээ бөлцийтөл уйлж билээ. Би талархан, хариу болгон дараагийн нэг цагийн турш бусдын төлөө нэрс индексжүүлэв.

Тэр өдөр миний гэрчлэл хоёр шалтгаанаар өссөн юм. Нэг нь Ерөнхий чуулганы үеэр Ариун Сүнс надад гэр бүлийн түүхийн ажлаа хийх, эрж хайх нэрсийг мэдэж авахад хөтөлсөн явдал байлаа. Хоёр дахь нь гэвэл, над шиг хүмүүс өвөг дээдсээ хурдан бөгөөд ойлгомжтой олох боломжтой бөгөөд нэрсээ индексжүүлдэг дэлхий даяарх Сүмийн гишүүд тэдний ажлыг яаравчуулдаг явдал байв. Энэ бол Бурханы ажил бүхий л дэлхий даяар түгэн тархаж байгаа гэсэн тун ойлгомжтой бөгөөд хүчирхэг гэрчлэл байв. ■ Лэйза Вимпий, АНУ, Невада

СКАУТЫН МАСТЕРЫН ЗАЛБИРАЛ

Би АНУ-ын өмнөд Ютад хорин залуу эрэгтэй, хоёр удирдагчийг ахалдаг скаут мастер байсан юм.

Биднийг лагерь руу салсан зам дээр ирэхэд би зогсоод, өмнө харагдах эзгүй газрыг ажиглалаа. Би ийм аялал олон удаа хийж байсан ч яагаад ч юм бэ энэ удаа миний мэддэг байсан зүйл огт харагдахгүй байв. Би баруун, зүүн тийш харж, ямар нэгэн мэдэх зүйлээ хайлаа.

Олон замаар явсан ч бүгд мухар зам болж таарав.

Харанхуй болж байлаа. Эцэст нь би зогсоод тэдэнд бүү хөдөл гэж хэлэв. Би гар чийдэнгээ авч, явган яваад, замаа олмогцоо дохио өгнө гэж тэдэнд хэлсэн.

Үнэндээ миний хийсэн зүйл гэвэл өвдөг сөгдөн суугаад, Тэнгэрлэг Эцэгээс ийм будилуу нөхцөл байдлаас гарахад минь туслахыг гуйсан явдал байсан юм. Би зүрх сэтгэлээ Түүнд нээж, хэр бэлтгэлтэй байгаага, хөвгүүдэд хэчнээн их хайртайгаа мөн бидэнтэй хамт эцгүүд нь ирсэнд талархаж байгаагаа болон миний залбиралд Түүнийг хурдан хариулна гэдэгт туйлын итгэлтэй байгаа зэргээ нэгд нэгэнгүй хэлэв. Би залбирч дуусаад, босож зогсов. Өвдгөн дээрээсээ өндийгөөд, харанхуй руу гар чийдэнгээрээ заан, зөв зам руу багийг маань тэр даруй оруулахыг би хүлээж байсан юм.

Гэтэл юу ч болсонгүй.

Би чийдэнгийн гэрэл тусч болох газрыг чимээгүйхэн сайтар гүйлгэн харав.

Бас л юу ч болсонгүй.

Би юу ч болохгүй байгаад итгэж чадахгүй байлаа. Босож зогсоод замаа харна гэдгээ л би *мэдэж байсан*. Бурхан намайг, ялангуяа надад олон хүн найдаж байгаа энэ үед орхихгүй гэдгийг би *мэдэж байлаа*.

Тэгээд би сэтгэлээр унасан эцгүүд, хэдэн машин дүүрэн суусан сахилгагүй, бухимдсан хөвгүүдийн бүгд л “Очих болоогүй байна уу” гэж асуухтай нүүр тулахаас аргагүй болсон доо.

Би уучлалт гуйн, ийм аяллыг

Үнэндээ миний хийсэн зүйл гэвэл өвдөг сөгдөн суугаад, Тэнгэрлэг Эцэгээс ийм мухардмал нөхцөл байдлаас гарахад минь туслахыг гуйсан явдал байсан.

амьдралдаа хорин удаа хийсэн, зам энд байсныг мэддэг байсан гэдгээ мэдэгдэв. Би ердөө л олж харахгүй байлаа.

Эцэст нь бид хот руу явж, буудлын хоёр өрөө хөлслөхөөр болов. Бид бямба гаргийн өглөө шинээр эхлэхээр боллоо.

Нэгэнт л авчирсан хүнсээрээ оройн хоол хийх гал асааж чадахгүйгээс хойш хотын захад байсан пиццаны газар руу явав.

Пицца амттай байсан бөгөөд хөвгүүд баяртай байсан ч надад буудлын өрөө, оройн хоолны төлбөрийн хувьд өөрийгөө буруутгасан мэдрэмж төрөөд байлаа.

Хоолоо идэж байх үедээ Тэнгэрлэг Эцэг яагаад миний залбиралд хариулаагүйг гайхан бодож суутал гэнэт нүржигнэсэн чанга чимээ гарыхыг сонсов.

Би босоод, пиццаны газрын хаалгыг нээгээд өмнө нь үзэж байгаагүй их аадар бороо орж байхыг харав. Баруун хойд зүгт буюу цаг хүрэхгүйн өмнө миний хариулт хүсэн залбирч байсан газрын яг урд цахилгаан цахиж байлаа. Тэр үед Ариун Сүнс надад ирсэн бөгөөд Их Эзэн миний залбиралд хариулсан *байсныг* би ухаарсан.

Маргааш өглөө нь тэнгэр цэлмэг байсан бөгөөд бид шавар шалбааг болсон толгой эргүүлсэн зам руугаа буцаж явав. Урд орой нь хайж байсан тэр замын салаа руугаа шууд л давхив. Заримдаа залбирал үгүй гэсэн хариултаар хариулдаг ч *дандаа* хариулагддаг гэдгийг би мэднэ. ■

Тони Рожерсон, АНУ, Юта

Унтах
Дахин эхлэх
Унтраах

Гарах



Хүүхдүүдээ асарч халамжлах, тэдэнтэйгээ тоглох, унших, судлах зэрэгт зарцуулж байгаа маш олон цагийг би нөхөж олж авсан юм.



НЭН ТЭРГҮҮНД ХИЙВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛЭЭ ЗОХИЦУУЛАХ НЬ

Би гэр бүлийн блог нээгээд тун удаагүй байхдаа блогоо шинэ мэдээгээр шинэчлэх, хэрхэн илүү бүтээлч байж, хүмүүсийн анхаарлыг татах вэ зэрэгт чөлөөт цагийнхаа ихэнхийг зориулж байгаагаа мэдсэн юм. Бусдын блогийг уншихад ч бас их цаг зарцуулж байв.

Хэдхэн долоо хоногийн дотор л блог хөтөлж явуулах нь миний өдөр тутмын судар судлах, бусад унших зүйлээс илүү чухал зүйл болсон байлаа. Би хичээлээ хийж байхдаа хичээлдээ анхаарч чадахгүй, унших ч нэг их хүсэлгүй, амьдралд минь Ариун Сүнс дутагдаж байгааг мэдэрсэн. Хүүхдүүдтэйгээ харьцахдаа тэвчээргүй зан гаргаж, тэдэнтэйгээ өнгөрүүлэх цагаа компьютер дээр сууж өнгөрүүлдэг болов.

Блог зөв зохисгүй байгаагүй ч энэ бүхний эцэст харахад гэр бүл, найз нөхөдтэйгээ харьцаа холбоотой байх нь үнэхээр сайхан арга зам юм. Гэхдээ би маш хүчтэй сүнслэг суурь болох зүйлсээсээ холдсон учраас ямар нэгэн зүйлийг өөрчлөх хэрэгтэй гэдгийг мэдсэн.

Би өдөр бүр блог руугаа орох хэрэггүй, бусдын блогийг ч бас

өдөр болгон шалгаад байх хэрэггүй гэдгээ хүлээн зөвшөөрлөө. Зөвхөн судар судлах болон бусад унших зүйлээ хийснийхээ дараа л компьютер дээр чөлөөт цагаа зарцуулж болох юм гэж шийдэв. Хамгийн чухал гэсэн зүйлээ хийж дуусахад блог руугаа орох нэг их цаг үлдээд байдаггүй ч дажгүй байсан. Би хүүхдүүдээ асарч халамжлах, тэдэнтэйгээ тоглох, унших, судлах зэрэгт зарцуулж байгаа маш олон цагийг нөхөж олж авсан юм.

Хамгийн чухал зүйлээ зохицуулсан хэдхэн хоногийн дараагаас л би амьдралдаа Ариун Сүнсийг улам их мэдрэх болсон.

Би сүнслэг байдлаар надад тус нэмэр болох зүйлийг өдөр бүр хийхээ эн тэргүүнд тавихдаа Ариун Сүнсийг өдөр тутмынхаа зүйл дээр улам илүү их мэдрэх болно гэдгийг мэднэ. Судар судлах, Сүмийн сэтгүүл, бусад сайн уран зохиолын ном унших, мөнхийн асуудалд хамаатай зүйлсийн талаар эргэцүүлэн бодох зэрэг нь илүү сайн эхнэр, ээж, Их Эзэний Сүмийн илүү сайн гишүүн байхад тусалж чадна. ■

Жинни Дэвис, АНУ, Техас



Далын
Ахлагч С. Скотт Грэй

ИТГЭЛТЭЙ БАЙДЛЫН ТУХАЙ БОШИГЛОЛЫН ЗАРЧМУУД

Хорь гаруй жилийн өмнө би Хойд Америк дахь номлолын ерөнхийлөгчийн үйлчлэлээ дуусгасан юм. Би эхнэр Рондагийнхаа хамт номлогчдын амьдралын аз жаргалтай бас гуниг харуусалтай үеийг хорин жилийн турш харлаа.

Номлогчдын маань ихэнх нь ариун сүмд баяртайгаар лацдан холбогдож, зөв шударга хүүхдүүдийг өсгөн, тэднийгээ номлолд явуулж, Сүмийн туслах бүлгийн болон санваарын дуудлагуудад итгэлтэй үйлчилж байна. Гэсэн хэдий ч зарим нь гэрлэсэн боловч гэрлэлтээ цуцлуулан мөн зарим нь Сүмийн гишүүнчлэлээс хасагджээ.

Эргэж ирсэн номлогчдын амьдралыг юу өөрчилдөг вэ? Тэдний зарим нь хувийн сорилт бэрхшээлээс зайлсхийхийн тулд юуг арай өөрөөр хийж болох байсан бэ? Та нар яах вэ? Та нар хорин жилийн дараа хаана байх вэ? Та нар итгэлтэй хэвээр үлдэхийн тулд одоо мөн ирээдүйд ямар шийдвэр гаргаж, ямар амлалт өгөх ёстой вэ?

Би та нарт туслах арван зарчмыг хэлмээр байна.

1 ГЭРЧЛЭЛЭЭ БАЙНГА АРЧИЛЖ ТОРД

Сүнсээр дүүрэн номлолын туршлагаууд амьдралын тань турш та нарыг адислах итгэлийн үндэс суурийг тавьж өгдөг. Энэ итгэлийн суурь нь зөвхөн үл тоомсорлох юм уу нүгэл үйлдэх үед сулардаг.

Би саяхан идэвх султай болж, өөрийгөө итгэлээ алдсан гэж тунхагласан нэгэн эргэж ирсэн номлогчтой ярилцсан юм. Би түүнээс номлогч

**Та нар итгэлтэй
хэвээр үлдэхийн тулд
одоо мөн ирээдүйд
ямар шийдвэр
гаргаж, ямар амлалт
өгөх ёстой вэ?**

байсан үеийнх шигээ залбирч, Мормоны Номыг уншиж байгаа эсэхийг асуусан. Тэр Йосеф Смитэд итгэх итгэлээ алдсан учраас эдгээрийг хийхгүй байгаа гэж хэлэв.

Би түүнээс “Чи порнограф үзэж байгаа юу?” гэж асуух өдөөлтийг хүлээн аваад асуухад тэр тийм гэж хариулсан. Би итгэлээ алдсан нь гайхах зүйл биш байна гэж түүнд хариулав.

Гэрчлэл бол Ариун Сүнс бодгальд маань сайн мэдээний тухай мөн сэргээгдсэн Сүмийн тухай үнэнийг гэрчилж буй зүйл гэдгийг би тайлбарласан юм. Биднийг залбирахаа мөн судар судлахаа болих үед бидний амьдрал дахь Сүнсний нөлөө суларч, уруу таталтыг эсэргүүцэх хүч багасдаг. Бид нүгэл үйлдэж, цэвэр бус болсон үедээ Ариун Сүнсний нөхөрлөлийг бүрмөсөн алддаг. Сүнсний гэрч ирэхээ больсноор бид өөрсдөдөө гэрчлэл байхгүй мөн хэзээ ч байгаагүй гэдэг дүгнэлтэд маш хялбархан хүрдэг.

Бид гэрчлэлээ байнга арчилж тордох хэрэгтэй. Хувиараа залбирч, өдөр бүр судрыг, ялангуяа Мормоны Номыг судлан, амьдралынхаа турш Сүмд үйлчилснээр гэрчлэлээ арчилж торддог юм.



2 АМЬД БОШИГЛОГЧ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЗӨВЛӨГӨӨГ ДАГА

Би та нарт аз жаргалтай гэрлэлт, итгэлтэй гэр бүл, амжилттай амьдралтай байхад тань туслах бошиглолын суу билэгт зөвлөгөөг хэлж өгье.

Би “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг хэлж байна. 1995 онд Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гаргасан тунхгийн зарим нэг чухал хэсгийг би хуваалцмаар байна. Бид энэ ах нарыг бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн дэмждэг. Тэд дэлхий дээрх Бурханы хүүхдүүдэд хандан, Түүний өмнөөс ярьдаг юм.

Сүм зохион байгуулагдсан өдөр Бурхан бошиглогчдынхоо талаар “түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой” хэмээн хэлсэн. Биднийг бошиглогчдын зөвлөгөөг дагах үед Их Эзэн энэ дэлхийн болон мөнхийн адислалыг хоёуланг амладаг. “Учир нь эдгээр зүйлүүдийг хийснээр тамын үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно” (С ба Г 21:5–6).

Энэ нь энэхүү хүнд цаг үед өгөгдсөн үнэхээр гайхалтай адислал юм.



3 АРИУН СҮМИД ЛАЦДАН ХОЛБУУЛЖ, ГЭРЭЭГЭЭ САХЬ

Бошиглогч, үзмэрч, илчлэгчид “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг” гэж тунхагладаг. Тэд мөн “Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг. Ариун сүмийн ёслол, гэрээнүүд нь хувь хүн Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжийг олгодог”¹ гэж нэмсэн.

Та нарын энэ амьдралдаа хийх хамгийн чухал шийдвэр бол “зөв хүнтэй, зөв газарт, зөв эрх мэдлээр гэрлэн,”² ариун сүмийн гэрээнүүдээ сахих явдал юм. Ариун сүмд лацдан холбогдохгүйгээр өргөмжлүүлнэ гэж байхгүй.

Хосууд өргөмжлүүлэхийн тулд “шинэ бөгөөд үүрдийн гэрээн[нд орж], [энэ нь] амлалтын Ариун Сүнсээр . . . тослогдсон түүгээр тэдэн дээр лацдагдах” ёстой. Хэрэв бид гэрээгээ сахих юм бол “хаан ширээнүүд, хаант улсууд, вант улсууд, мөн хүчнүүд, эзэгнэлүүд, бүх өндөрлөгүүд хийгээд гүнүүдийг өвлөх болно . . . тэрхүү алдар суу нь бүрэн дүүрэн мөн үүрд хийгээд мөнхөд үр удмынх нь хувьд үргэлжлэл байх” (С ба Г 132:19; 7-р шүлгийг мөн үзнэ үү) болно.

Ариун сүмийн лацдан холболт нь ирэх амьдрал дахь мөнхийн адислалуудын амлалтыг багтаадаг ба энэ амьдрал дахь гэр бүлийн аз жаргалыг нэмэгдүүлдэг. Та нар Бурханы ариусагдсан охид, хөвгүүдийн хувьд энэ цаг үед Бурханы хаант улсыг байгуулахаар дэлхий дээр ирэх гэрээнд орсон. Та нарын ариун сүмийн гэрлэлт нь хаант улсыг барих нэг хэлбэр юм.

4 БУРХАНЫ СҮНСЭН ХҮҮХДҮҮДИЙГ ДЭЛХИЙ ДЭЭР АВЧРАХДАА БУРХАНТАЙ НЭГД

Гэр бүлийн тунхагт “Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүдээ өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ хэмээн өгсөн зарлиг хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна” гэж гардаг.

Өнөөдрийн гэр бүлүүд, бүр ХҮГ гэр бүлүүд хүртэл хэдэн үеийн өмнөхөөс ам бүлийн тоогоор цөөн болсон байна. Бид хүүхдүүдийнхээ тоог хязгаарлаж эсвэл хойшлуулж байгаагаа зөвтгөх шалтаг үргэлж олж чадна. Жишээ нь, “Бид эхлээд сургуулиа төгсөх ёстой,” “Бид илүү их мөнгөтэй болохын тулд илүү сайн ажил олж хийх хэрэгтэй,” “Яагаад хүүхэдтэй болж, гэрлэлтээ уйтгартай болгох ёстой гэж?” гэх мэт асуултауд тавьж болно.

Та нар Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний гэрчлэлээр адислагдсан. Та нарт үр хүүхдүүдээ өвлүүлэх мөнхийн адислал бий. Хүүхдүүдээ дэлхийн бүхий л материаллаг зүйлээр хангах ёстой гэсэн бодолд битгий дарагдаарай. Та нарын хүүхдүүдээ өгөх хамгийн агуу бэлэг бол Бурханы хаант улс дахь бүхий л сүнслэг зүйл юм.

Та нар ханьтайгаа хамт залбирч, хүүхдүүдтэй болох талаар зөвлөлдөхдөө өөрсдийгөө язгууртан гаралтай өв залгамжлагчид гэдгээ санаарай. Шийдвэр гаргахдаа Бурханыг оролцуул. Энэхүү өв залгамжлах эрхээ Бурханы аль болох олон охин, хөвгүүнтэй хуваалцаарай. Бурхан тэднийг танай гэр рүү явуулахаар бэлдсэн байгаа. Эцэст нь хэлэхэд тэд таны хүүхэд болохоос бүр урьд Бурханы хүүхдүүд байсан.

Бурханд болон Түүний бошиглолын үгсэд итгэх итгэлээр, ямар нэгэн шалтаг тоочиж, хойшлуулалгүйгээр урагш алхаж, мөнхийн гэр бүлээ үүсгэ.

5 ПОРНОГРАФТ ЭСВЭЛ ӨӨР ЯМАР НЭГЭН ЁС БУС ҮЙЛД БҮҮ ОРОЛЦ

“Хүүхдүүд гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй” гэж гэр бүлийн тунхагт дурддаг.

Үнэнчээр сахих гэдэг нь хань ижилдээ бие махбод, оюун санааны хувьд үнэнч байна гэсэн үг юм. Порнограф, онлайн харилцаа зэрэг нь оюун санаагаараа үнэнч биш байхын жишээ юм. Эхнэр, нөхрүүд порнографт оролцсон үедээ ариун нандин, дотно итгэлийг сүйрүүлдэг. Гэм зэмгүй хань ижилд тань хууран мэхлэгдсэн мэт сэтгэгдэл төрнө. Гэрлэлтийн итгэл, найдвар буурдаг. Садар самуун явдал порнографыг үзсэнээс эхлэлтэй байдаг.

Ариун сүмд лацдан холбогдсон боловч порнограф болон нэгэн эмэгтэйтэй онлайн харилцсанаас болж гэр бүлээ алдсан эрэгтэйн бодол мэдрэмжээс би та бүхэнд хуваалцъя. Тэр “Хэрвээ Сатанд боломж өгөхгүй л бол тэр амьдралд маань нөлөөлөх хүчгүй байх болно гэсэн патриархын адислал дээрх үгсийг би сонсож дагаагүй юм. Би түүнд хангалттай их боломж өгсөн ба тэр алгуур, итгэлтэйгээр эхнэр хүүхдүүдтэйгээ хамт байсан амьдралыг маань устгахад тэрхүү хүчийг ашигласан юм. Би тэднийг бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж байсан, хайрлаж ч байгаа, хайрлах ч болно. Гэхдээ Сатанд амьдралыг минь сүйтгэ гэж өгсөн тэр хүчийг ялан дийлэхэд хайр дангаараа хангалтгүй байсан. Хэрвээ би Сүмийн сургаалуудыг сонсож, дагасан бол бидэнд энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд лацдан холбуулсан гэр бүлийн хувьд Тэнгэрлэг Эцэгтээ буцах арга замыг энэ сургаал олгох байлаа. Гэвч эцэст нь би тэгээгүй юм” гэж харууссан сэтгэлээр дурссан юм.

Ямар эмгэнэлтэй хэрэг вэ!





6 ГЭР ОРОНDOO САЙН МЭДЭЭГ ЗААЖ, САЙН МЭДЭЭНИЙ ДАГУУ АМЬДАР

Гэр бүлийн тунхаг бидэнд гэр орондоо хийх ёстой зүйлсийн талаар заадаг. “Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт, гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна.”

Эхнэр бид хоёр залуухан хос байхдаа өдөр бүр гэр бүлээрээ судар уншдаг хэвшлийг бий болгохын тулд ахин дахин хичээсэн юм. Хамгийн том хүүхэд маань долоон настай байхад бид үүнийг өдөр тутмын хэвшил болгож чадсан. Бид өглөө босоод хамгийн түрүүнд судар уншдаг ба уншсаныхаа дараа өдрийн турш итгэл дүүрэн явдаг байв. Хүүхдүүд маань тэр хэвшлийг дагаж эхэлсэн ба бага хүүхдүүд маань хангалттай том болсон үедээ судар унших дуртай болсон. Бид өглөө эрт хичээллэдэг семинараас болж 6 цагаас өмнө унших хэрэгтэй болдог байв.

Залуу хосууд өдөр бүр гэр бүлээрээ судар судлах, залбирах, хүүхдүүдээ номлолд болон ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэх зэрэг зөв шударга гэр бүлийн уламжлалуудыг бий болгож эхлэх үүрэг хариуцлагатай байдаг.

7 ХҮҮХДҮҮДЭЭ ӨСГӨН ХҮМҮҮЖҮҮЛЭХДЭЭ ЭЦЭГ, ЭХИЙН ҮҮРГЭЭ ХҮНДЭТГЭ

Гэр бүлийн тунхаг хүүхэд өсгөх талаар зарим чухал зөвлөгөөг өгдөг. “Эх хүний үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ *адил тэгш* туслах ёстой.”

Зарим үед эцэг эхийн аль нэг нь хүүхдүүдээ өсгөж, хүмүүжүүлэхдээ арай илүү чадвартай юм шиг санагдаж болно. Энэ эрин үеийн бошиглогчид эхнэр, нөхөр гэрлэснээр хамтрагчид болж, гэр бүлтэй хамаатай бүх шийдвэрийг хамтдаа, эв нэгдэлтэй гаргах ёстой гэж ахин дахин заасан юм.

Эрх тэгш хамтрагчид бол эрх тэгш хамтрагчид л байх ёстой. Хамтдаа зөвлөлдөж, хамтдаа залбир. Хүүхдүүдээ өсгөх хамгийн үр дүнтэй аргыг мэдэхийн төлөө Сүнсээр удирдуул. Таны шийдвэр тэдний мөнхийн хувь заяанд нөлөөлөх болно.

8 АВРАГЧИЙГ ДАГАХААР СОНГОХЫН ТУЛД ЁС СУРТАХУУНЫ СОНГОХ ЭРХЭЭ АШИГЛА

Та нар 20 жилийн дараа эсвэл 20 зууны дараа хаана байх эсэх нь бүхэлдээ та нараас шалтгаална. Та нар сонгох эрх чөлөөтэй ч та нарын сонголтоос мөнхийн үр дагавар ирэх болно. Аврагчийн Цагаатгалын ачаар “тэд уналтаас гэтэлгэгдсэний учир тэд үүрдийн чөлөөт, сайныг муугаас ялгаж мэдэх болсон; *өөрсдийн төлөө үйлдэх* мөн Бурханы өгсөн зарлигуудын дагуу, агуу хийгээд эцсийн өдөр хуулийн шийтгэлээс бусдаар өөрсөд дээрээ үйлдүүлэх нь үгүй болой.

Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй; учир нь тэрээр бүх хүмүүн өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг бөлгөө” (2 Нифай 2:26–27; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Сатан та нарыг хэн гэдгийг мөн хэн болохыг мэддэг учраас үзэн яддаг. Тэр та нарыг өөртэйгөө адил зовлонт

болгохыг хүсдэг. Есүс Христ та нарт хайртай. Тэр та нарын нүглийн төлөөсийг төлсөн. Тэр та нарын төлөө Өөрийн амийг өгсөн. Тэр шаардлагатай бол та нарыг Өөр рүү нь ирж, наманчлахад урьдаг. Та нар Аврагчийг дагахыг сонгох үедээ “энэ амьдралд баяр баясгаланг, ирэх амьдралд мөнх амьдралыг”³ олох болно.

9 ЭЦСЭЭ ХҮРТЭЛ ТЭВЧИХ ИТГЭЛИЙГ ХӨГЖҮҮЛ

Та нарыг Их Эзэнд хөрвөгдөхийн хэрээр итгэл тань хүчирхэгждэг. Бошиглогч Нифай “Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно” (2 Нифай 31:20) гэж заажээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон саяхны чуулган дээр “Ирээдүй та нарын итгэл лүгээ адил гэрэл гэгээтэй байна”⁴ хэмээн хэлсэн юм. Энэ нь эцсээ хүртэл тэвчих мөн гомдох, хууран мэхлэх, гуньж гутрах зэрэг бэрхшээлүүдийг давах итгэлийг багтаадаг. Эцсээ хүртэл тэвчих та нарын итгэл хувь заяаг тань, бүр мөнхийн хувь заяаг тань тодорхойлно.

10 ӨӨРИЙНХӨӨ ХҮСЛИЙГ БУРХАНЫ ХҮСЭЛТЭЙ НИЙЦҮҮЛ

Илүү сайн хийх, илүү сайн болох, амьд бошиглогчдын зөвлөгөөг дагах хүслээр бодгалийг тань адислаасай

хэмээн би Бурханд залбирдаг. Бурханы урьдчилан томилсон хүн болохын тулд та нарыг амлалтаа бататгах хүслийг мэдэрсэн байх гэж найдаж байна.

“Ах дүүс минь, ийм агуу учир шалтгааны төлөө бид урагш явахгүй гэж үү? Арагшаа биш, харин урагшаа явагтун. Зориглогтун, . . . тэгээд ялаат өөд ахь ахь! . . . Тиймийн тул, бид Сүмийн хувьд болон хүмүүсийн хувьд, мөн хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл өргөцгөөе” (С ба Г 128:22, 24-ийг үзнэ үү).

Энэхүү өргөл нь хувь хүнийхээ хувьд Бурханд өгч болох ямар өргөл байх вэ? Тэр та нараас энэ бэлгийг хэзээ ч шаардахгүй. Энэ нь өөрийнхөө хүслийг Их Эзэнийхтэй нийцүүлэх өргөл юм. Энэ нь хувийн золиослолын тахилын ширээн дээр сонгох эрхээ өргөл болгон өгөх явдал юм.

Энэ эрин үед эрт үеийн ах нарын бэлдэж байсан *Итгэлийн тухай лекцүүдийн нэгэнд* “Бүх зүйлээ золиослохыг шаарддаггүй шашинд амьдрал, авралд шаардлагатай итгэлийг бий болгох хангалттай хүч байдаггүй”⁵ гэж дурдаг.

Бурханд өргөл болгон өгч болох та нарт байдаг нэг зүйл бол та нарын сонгох эрх юм. Та нар сайн дураараа өөрсдийнхөө хүслийг Түүний хүсэлтэй нийцүүлснээр Түүнтэй адилхан болох болно.

Би Аврагчийн тухай гэрчлэлээр үгээ төгсгөө. Та нар Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, өөрсдийнхөө хүслийг Бурханы хүсэлтэй нийцүүлэн, Түүний бошиглогчдын зөвлөгөөг дагаж, Сүнсний өдөөлтийг дагахын хэрээр итгэлтэй, аз жаргалтай, амжилттай байх болно. ■

2012 оны 5-р сарын 15-нд Айдахо дахь Бригам Янгийн Их сургууль дээрх онцгой цугларалт дээр хэлсэн “Where Will You Be in 20 Years?” үгээс эш татав. Бүрэн эхийг (англи хэл дээр) web.byui.edu/devotionalsandspeeches хаягаар орж үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Liahona*, 2010 оны 11-р сар, 129; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
2. Брюс Р.Макконки, “Agency or Inspiration?” *New Era*, 1975 оны 1-р сар, 38.
3. Гордон Б.Хинкли, *Caesar, Circus, or Christ?* Brigham Young University Speeches of the Year (1965 оны 10-р сарын 25), 8; мөн Рассэлл М.Нэлсон, “Spiritual Capacity,” *Ensign*, 1997 оны 11-р сар, 16-г үзнэ үү.
4. Томас С.Монсон, “Зоригтой бай,” 2008 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 99.
5. *Lectures on Faith* (1985), 69.



АСУУ

Иаков 1:5-6



Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалтгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно.

“Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн нь салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ.”



Яагаад энэ уриаг сонгосон бэ? Энэ уриа та нарын хувьд ямар утга учиртай вэ? Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Стэфэн В.Өүн ах, Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон эгч нар үзэл бодлоо хуваалцаж байна.

ЯАГААД СУДРЫН ЭНЭ ХЭСГИЙГ СОНГОСОН БЭ?

Оскарсон эгч: Их Эзэн та нарт ямар захиас хэрэгтэй болохыг мэддэг бөгөөд жилийн туршид гарч ирдэг асуудлуудын заримд уриа хэрхэн хариулт болдог мөн та нарын амьдралд тохиолдож байгаа зүйлд хэрхэн тохирдог гэдэг нь үнэхээр гайхамшигтай зүйл байдаг.

Биднийг Иаков 1:5–6-г энэ жилийн уриа байж болох талаар ярилцаж байхад Ариун Сүнс бидний өрөөг дүүргэж билээ. Энэ нь хэд хэдэн зүйлтэй холбоотой учраас манай өсвөр үеийнхэнд агуу судар болно гэдгийг бид бүгдээрээ зөвшөөрсөн. Энэ нь Сүмийн түүхтэй холбоотой. Энэ бол Иосеф Смитийн уншсан, Ариун төгөл рүү очин залбирах сүнслэг өдөөлт өгсөн судар юм. Хоёр дахь том холбоо бол Иосеф Смитийн тэнгэрлэг номлолын тухай гэрчлэлийг хуваалцаж явдал. Энэ бол түүний нэр хүндийн талаар болон Сүмийн түүхийн тухай дэлхийнхнийг эргэлзэнгүй асуусан үед хэрэгтэй зүйл юм. Энэ нь бас амьдралдаа хэрхэн хувийн илчлэлт хүлээн авч болох хүн бүрийн мэдвэл зохих захиас мөн.

Өүн ах: Өнөөдөр та бүхний амьдралд олон зүйл тохиолдож

байна. Та нарт олон асуулт байгаа. Бидэнд байгаа мэдээллийн бүх хэрэгслийг оруулаад итгэлийн талаарх асуултууддаа хариулт авах эх сурвалж олон байна. Энэ гол судар Иосеф Смитийн илчлэлт хэрхэн хүлээн авсныг харуулдаг бөгөөд энэ судар бидний мөрдөж болох загвар юм.

ӨСВӨР ҮЕИЙНХЭН ИАКОВ 1:5–6-Г ХЭРХЭН ӨӨРСӨД ДЭЭРЭЭ ТУСГАН АВААД, АШИГЛАЖ БОЛОХ ВЭ?

Оскарсон эгч: Энэ судар маш гайхамшигтай захиасыг агуулдаг. Судрын тэр хэсэгт “Ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг” (Иаков 1:6) хэмээн хэлсэн байдаг. Энэ нь яг таарсан судар юм. Та нар ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйх хэрэгтэй.

Өүн ах: Итгэлээр гуйна гэдэг нь жинхэнэ хүсэлтэйгээр гуйх гэсэн утгатай. Иосеф Смит аль сүмд нэгдэх тухай хариултаа авахдаа “За, энэ мэдэхэд сайхан байлаа, гэхдээ . . .” гэж хэлээгүй, харин итгэлээр урагшилсан билээ.

Оскарсон эгч: Зөв шударга залбирал бол хүсэж байгаа зүйлээ гуйх биш, харин Бурханы юу хүсэж байгааг мэдэх явдал юм.

ТА ӨСВӨР ҮЕИЙНХЭНД АМЬДРАЛДАА ЗАЛБИРЛАА ХЭРХЭН АШИГЛАХ ТАЛААР ЯМАР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ БАЙСАН БЭ?

Оскарсон эгч: Залбирахыг дадал хэвшил болго. Та үүнийг мартаж болохгүй. Та үүнийг анхаарахгүй

орхиж болохгүй. Жаредын ах үүний нэгэн жишээг үзүүлсэн (Ифер 2:14-ийг үзнэ үү).

Өүн ах: Залбирахаа хааяа мартаж нэг хэрэг. Харин илүү түвэгтэй зүйл бол Бурханаас холдон, залбирахыг хүсэхгүй байх явдал юм. Танд залбирах хэрэггүй гэж бодогдсон үед л та залбирах хэрэгтэй. Хэрэв та залбирч, судраас уншиж байгаа бол Сүнстэй хөг нийлэх болно. Хэрэв эдгээрийг хийхгүй бол та өөрийгөө Сүнснээс холдуулж байна.

Оскарсон эгч: Бид Бурхантай шууд ярьж чадна. Тэрээр цагийн хязгаар тавьдаггүй. Бид үүнийг хийж чадна. Тэрээр үргэлж бидний төлөө байдаг гэдгийг мэдэх нь ямар сайхан бэлэг гээч.

ТА УЧИР УТГАТАЙ АРГА ЗАМААР ЗАЛБИРАХАД СУРАЛЦАЖ БАЙСАН УУ?

Оскарсон эгч: Би ямар нэг тодорхой туршлагыг санахгүй байна. Энэ бол амьдралынхаа турш олж авсан зүйл юм. Залбирах нь миний өдөр тутмын хамгийн учир утгатай зүйлсийн нэг бөгөөд би тогтмол залбирч байхын тулд хүчин чармайлт гаргадаг. Би илүү сайн сонсдог, хариултаа авдаг болж байгаа. Бид үүнийг илүү их хийх тусмаа суралцан, илүү сайн болдог. Энэ бол ердөө өдөр болгон тууштай байж, Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярих боломжоо алдахгүй байхад анхаарах явдал юм. Бид олон залбирах тусмаа тэдгээрийн хариултыг улам сайн сонсдог болдог.

Өүн ах: Би өсвөр насандаа нэг зүйлийг мэдэж авах маш их

хэрэгтэй байсан юм. Тэр үед би Анхны үзэгдлийн тухай санаад, “Иосеф Смит үүнийг хийсэн” гэж бодож билээ. Надад гайхалтай үзэгдэл хэрэггүй ч хариулт хэрэгтэй. Тэгээд итгэлээр би тийнхүү тэр загварыг дагасан. Би өвдөг сөгдөн суугаад, толгойгоо бөхийлгөн, чанга залбирсан юм даг. Тэрхүү загварыг үргэлжлүүлэн дагаж байсан минь хувийн илчлэлт хүлээн авахад миний амьдралыг олонтоо адисалсан.

ЭНЭ СУДРААС ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ МЭДЭЖ БОЛОХ ХАМГИЙН ЧУХАЛ ЗҮЙЛ ЮУ ВЭ?

Өүэн ах: Би Иосеф Смитийн тогтоосон залбирлын загварыг өөр үгээр илэрхийлье. Арван дөрвөн настайдаа тэрээр ихэд эргэлзэж байсан учраас судраа уншсан. Анхны үзэгдэл бол Иосефын өвдөг сөхрөн суусан тэрхүү агшин зуурын үе биш юм. Өмнө нь маш их зүйл хийгдсэн байсан. Тэрээр асуултаа ахин дахин тунгаан бодсон. Тэрээр Иаков 1:5–6-г уншаад, “Судрын ямар ч хэсэг энэ удаад надад тохиолдсоноос илүү хүчтэйгээр хүмүүний зүрх сэтгэлд ирж байсан нь хэзээ ч үгүй бөлгөө” (Иосеф Смит—Түүх 1:12) хэмээн хэлсэн. Тэр хэсэг түүний зүрх сэтгэлд агуу их хүчээр нэвтрэн орсон бөгөөд түүний дагуу үйлдсэн. Тэр үнэн сэтгэлээр залбираад, итгэлээр урагшилсан билээ. Яг л энэ зүйлийг та нар 2017 оны туршид энэ судраас мэдрэх боломжтой байгаасай хэмээн бид найдаж байна. ■



ОНЛАЙН ЭХ СУРВАЛЖУУД

Та ямар нэгэн үйл ажиллагаа эсвэл чуулган төлөвлөх, уриагаа бодох үедээ lds.org/go/11752 руу орвол энэ жилийн Мючелийн уриатай холбоотой уран зураг, хөгжим, нэмэлт эх сурвалжуудыг олж үзэх болно.

АСУУ

Иаков 1:5-6



“Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалтгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно. Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн нь салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ.”

Иаков 1:5-6

ЗАЛБИРЛЫН ТАЛААРХ ТАВАН АМЛАЛТ

Карлиса Крамэр

Тэнгэрлэг Эцэг Өөрт нь талархал өргөж, Өөрөөс нь адислал хүсэж, сүнслэгээр өсөж хөгжихийн тулд Өөртэй нь шууд харилцах арга зам болгон залбирлыг өгсөн. Заримдаа толгой бөхийн, гараа урдаа аваад, цөөн хэдэн энгийн бөгөөд чин сэтгэлийн үгс хэлэхэд л хангалттай. Гайхалтай биш гэж үү? Залбирснаар хүлээн авдаг таван амлалт буюу адислал байдаг.

1

ДАВАН ТУУЛАХ ХҮЧ ЧАДАЛ

Хүн төрөлхтөн бид бие махбод, сэтгэл санаа, сүнс, оюун санааны хувьд маш олон арга замаар сул дорой байдаг. Бид уралдаанд түрүүлж, шалгалтаа амжилттай өгөн, уруу таталтыг эсэргүүцэж эсвэл бүр Сүнсийг мэдрэхийн тулд хичээн чармайж болох ч залбирал л бидэнд амьдралд тохиолдож болох ямар ч зүйлийг даван гарахад шаардлагатай хүч чадлыг өгч чадна.

Нифайн хэлснээр “Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7). Хэрэв Их Эзэний хүсэл мөн бол хийхийг хичээж буй ямар ч сайн зүйлээ хийх хүч чадлыг Их Эзэн бидэнд өгөх болно.

Уруу таталтыг эсэргүүцэх хүч чадлын төлөө залбир.

Шалгалтандаа төвлөрч, үр бүтээлтэй суралцах хүч чадлын төлөө залбир. Гүйхдээ үл ядран, алхахдаа үл цуцах хүч чадлын төлөө залбир. Хүч чадлын төлөө залбир, тэгээд Тэр таныг хүчирхэг болгох болно.



2

УУЧЛАЛ

Төгс төгөлдөр байх тухай бодох сайхан ч бид бүгд төгс бус. Бид алдаа

гаргадаг. Энэ бол амьдралын нэг хэсэг. Гэхдээ Их Эзэн тэдгээрийг засаж залруулах боломжоор буюу Есүс Христийн Цагаатгалын хүчээр хангадаг. Түүний хүч чадлыг олж авах нэг арга зам бол залбирал юм.

Бид залбирлаар дамжуулан өршөөлийг эрэх үедээ Аврагчийн Цагаатгалаар дамжуулан нүглээсээ өршөөгдөж чадна. Илүү ноцтой нүгэл үйлдсэн хүмүүст бишопын эсвэл салбарын ерөнхийлөгчийн тусламж хэрэгтэй байдаг ч хувийн, чин сэтгэлийн залбирал үргэлж өршөөлийн хамгийн анхны алхам байх болно. Энэ нь Тэнгэрлэг Эцэгээс өршөөл гуйж байна уу эсвэл хэн нэгнийг уучлахад туслахыг гуйж байна уу адилхан үйлчлэх болно. Тэр бүү хэл тэрээр бидэнд өөрсдийгөө уучилж сурахад туслах болно.



3

МЭДЛЭГ БА УДИРДАМЖ

Хувийн илчлэлт нь та нарын бодож олсон, ялангуяа шинэ Мючелийн урианаас бодож олсон залбирлаас ирдэг хамгийн анхны амлагдсан адислал байж болно.

Иосеф Смитэд аль сүмд нэгдэх талаар мэдлэг дутсан учраас Ариун ойн цоорхойд өвдөг сөгдөн суугаад, асуултаа тавьсан бөгөөд маш чухал арга замаар хариултаа хүлээн авчээ.

Гэхдээ илчлэлт нь зөвхөн бошиглогчдод өгдөг зүйл биш бөгөөд өвөрмөц онцгой туршлага байх албагүй. Хэрэв бид ямар нэгэн зүйл дээр мэргэн ухаанаар дутвал Бурханаас асууж болно мөн асуух ч хэрэгтэй. Тэрээр заримдаа бидний хүсэн хүлээсэн арга замаар хариулдаггүй ч ямар ч байсан хариулах болно.

Их Эзэн асуултуудад маань хариулж, амьдралаа удирдахад тусалж чадна. Гэхдээ бид өөрсдөө эхэлж гүйх ёстой.



4

ИХ ЭЗЭНИЙ ТААЛЛЫГ ГҮЙЦЭЛДҮҮЛЭХ ХҮСЭЛ

Үнэндээ зарим үед бид Их Эзэний бидэнд байгаасай гэж хүсэхгүй байгаа зүйлсийг байлгахыг хүсдэг учраас үүнийг адислал гэж үзэхэд хэцүү байж болно. Гэхдээ бид жинхэнээсээ хөрвөгдөж, Их Эзэний тааллыг гүйцэлдүүлэх хүсэлтэй байхаар залбирах үедээ бидний хүсэж байгаа зүйл Түүний хүсэж байгаа зүйлтэй адилхан болж эхэлж байгаа гайхамшигийг анзаарах болно.

Энэхүү зүрх сэтгэлийн өөрчлөлт тэр даруй ирдэггүй. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар “Бидний олонхын хувьд хөрвүүлэлт нь цаг хугацаа шаардсан үйл явц бөгөөд энэ нь хүчтэй буюу сэтгэл хөдөлгөсөн үйл явдлын үр дүнд бий болдог нэг удаагийн явдал биш юм. Шат шатаар, дүрэм дүрмээр, яваандаа, бараг мэдэгдэлгүйгээр, бидний үйл хөдлөл, бодол, үгс, үйлс нь Бурханы хүсэлтэй нэгдэн нэг болдог” (“Их Эзэнд хөрвүүлэгдэв,” 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 132) гэж хэлсэн.



5

АМАР АМГАЛАН

Биднийг залбирах үед ирдэг амлагдсан нэг адислал бол Ариун Сүнснээс ирдэг тайтгарал, амар амгалан юм. Эцсийн эцэст Түүнийг Тайтгаруулагч гэж нэрлэдэг шүү дээ. Амар амгалан нь хүнд хэцүү цагт ч ирдэг гэдэгт бүү эргэлз. Иохан 14:27 дээрх Их Эзэний амлалтыг сана. “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.” Хэрэв бид гуйвал эцэстээ амар амгалан ирэх болно.



Залбирал нь хайрт Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах шулуун зам юм. Үүнийг ашигла мөн үүний төлөө таныг адислах боломжийг Түүнд олго. Эдгээр адислалыг чин сэтгэлийн залбирлаар дамжуулан хүлээн авсныхаа дараа залбирлаар дамжуулан зүрх сэтгэлийн талархлаа илэрхийлэхээ санаарай. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

5

Залбирлын хариулт ирэхгүй байгаа юм шиг санагдах үед ТАВИХ ТАВАН АСУУЛТ

Маргарэт Виллдэн

Та хэзээ нэгэн цагт хэзээ ч биеллээ олохгүй юм шиг санагдсан зүйлийг залбирч, гуйж байсан уу? Та ганцаараа биш. Тэнгэрлэг Эцэг таны залбирлыг сонсож байгаа гэдэгт итгэж болно. Хариулт таны хүссэн *цагт* эсвэл хүссэн *арга замаар* ирэхгүй байж болох ч Тэнгэрлэг Эцэг хамгийн сайн арга замыг үргэлж мэддэг гэдгийг санах нь чухал юм.

Залбирлын хариултаа хүлээж авахдаа бэрхшээлтэй тулгарч байгаа үед өөрсдөөсөө асуух цөөн асуулт байдаг.

2 Би чадах бүхнээ хийсэн үү?

Та найзуудтайгаа гадуур зугаалсан учраас шинжлэх ухааны шалгалтандаа бэлдээгүй гэж бодъё. Хэрэв та Тэнгэрлэг Эцэгээс зүгээр л нэг шалгалтандаа тэнцэхэд туслаач гэж гуйвал танд туслах болов уу?

Бид адислал авахын тулд өөрсдөөсөө шалтгаалах зүйлийг хийх хэрэгтэй. Харин та нар шалгалтандаа бэлдэх үедээ бэлтгэлийнхээ дагуу шалгалтаа сайн өгөхөд туслах хүч чадлын төлөө залбирч болно.

Онцгой хичээл зүтгэл гарган, номлогчийн ажлаа амжилттай хийсэн Мозаягийн хөвгүүдийн жишээг бодоод үз. “Тэд өөрсдийгөө их залбирал, мөн мацаг барилтанд зориулсан байв; тиймийн тул тэдэнд бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг байлаа, мөн тэд зааж байхдаа Бурханаас хүлээн авсан хүч мөн эрх мэдэлтэйгээр тэд зааж байв” (Алма 17:3).

1 Би хүлээн авсан хариултынхаа дагуу үйлдэхэд бэлэн үү?

Итгэлээр залбирах гэдэг нь таны хүссэн хариулт биш байлаа ч хүлээн авсан хариултынхаа дагуу үйлдэхэд бэлэн байхыг хэлдэг. Бошиглогч Иосеф Смит нэгэн удаа “Чамд миний өгөх гэж буй заавруудыг хүлээн авч мөн дуулгавартай дагахад зүрх сэтгэлээ бэлтгэгтүн; учир нь энэхүү хууль өөрсдөө нь илчлэгдсэн тэд бүгд мөн үүнийг дуулгавартай дагах ёстой” (С ба Г 132:3) гэсэн зааврыг хүлээн авсан юм. Та ямар нэгэн үдэшлэгт оролцох хэрэгтэй эсхийг залбирч асуухдаа (залбирлын хариулт ирээгүй байсан ч) ямар ч тохиолдолд дагахаар шийдэх үү?

3 Та ирсэн хариултыг үл тоомсорлосон уу?

Тэнгэрлэг Эцэг таныг сонсдог учраас аль хэдийнээ залбиралд тань хариулсан байх боломжтой! Сургаал ба Гэрээ 6:14-т “чи асуух тоолондоо, чи миний Сүнснээс заавар хүлээж авсан бөлгөө” гэж дурдсан байдаг. Заримдаа залбирал нь бусдын үйлдэл гэх мэт шууд биш арга замаар ирдэг учраас хариултаа олж харах сүнслэг нүдтэй байхын төлөө залбирч болно.

Мөн сонсох цаг гаргахаа бүү мартаарай. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт “Тэнгэрлэг Эцэгийн” хариултууд өвдөг сөгдөн залбирах үед тань цөөхөн тохиолдолд л ирнэ. . . . Харин Сүнс зүрх сэтгэл, оюун санаанд тань хамгийн үр дүнтэй нөлөөлж чадах аниргүй намуухан үед таныг өдөөх болно” (“Using the Supernal Gift of Prayer,” *Liahona*, 2007 оны 5-р сар, 9) гэж тайлбарласан юм.

4 Миний хүсэл зөв шударга байна уу?

Та өөрийнхөө сайн сайхны төлөө биш ямар нэгэн зүйлийг гуйвал бараг л хариулахгүй болов уу. Аврагч “[Есүс Христийн] нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой” (3 Нифай 18:19) гэж заасан ба энэ нь зөв зүйл гуйсан үед хариулт нь ирэх боломжтой гэдгийг харуулж болно. “Аврагчид миний хүсэж байгаа зүйл ямар санагдах бол?” гэж өөрөөсөө асуу. Хэрэв таны хүсэл амин хувиа хичээсэн байдалд эсвэл зөв шударга бус байдлын аливаа хэлбэрт суурилсан бол зүрх сэтгэлийн өөрчлөлтийн төлөө мөн Аврагч өөрийг чинь юу хүсээсэй гэж хүсэж байгааг мэдэхийн төлөө залбир.

5 Зөв цаг нь мөн үү?

Бидний гуйж байгаа зүйл зөв байх ёстой ба цаг хугацааны хувьд ч бас зөв байх ёстой. Тэнгэрлэг Эцэг бидэнд агуу төлөвлөгөө бэлдсэн байдаг ч бидний хуваарь заримдаа Түүнийхээс бага зэрэг өөр байдаг. “Миний үгс лавтай бөгөөд биелэгдэхгүй болох нь үгүй, . . . Гэвч бүх зүйл тэдний цаг үед тохиохоор ирэх ёстой” (С ба Г 64:31–32). Шархаа эдгэрэхийг хүлээх эсвэл алдсан хайртай амьтнаа олохын тулд дахиад бага зэрэг хүлээх нь таагүй санагдаж болно. Их Эзэний цаг заримдаа ирэх дэлхийд байдаг боловч Тэр таныг сонсож, туслах болно гэдэгт итгэлтэй байж болно.

Тэвчээр гаргахад, ялангуяа залбирлын хариулт тодорхой бус санагдаж байгаа үед тэвчээр гаргахад хэцүү байж болно. Гэхдээ та үнэн хүсэлтэйгээр асуух аваас хариултаа үргэлж олох болно гэдгийг мэдсэнээр хариултаа эрж хайхдаа зориг гаргаж чадна. “Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно” (Иеремиа 29:13). ■
Зохиогч нь АНУ-ын Нью-Йоркод амьдардаг.

БУРХАНААС ГҮЙ

Үг, аяыг Ник Дэй

Нэг хэмнэлээр ♩ = 156-170

First system of the musical score. It consists of a vocal line on a single staff and a piano accompaniment on two staves. The key signature has two flats (B-flat and E-flat), and the time signature is 4/4. The piano accompaniment features a steady bass line and chords in the right hand.

Second system of the musical score. The vocal line begins with the lyrics: "1. Чин ү - нэн ит - гэ - лийг олж Өөд у - руу - 2. Бага ба - гаар чамд ө - гөгд - сөөр, И - лүү то -". The piano accompaniment continues with chords and a bass line.

Third system of the musical score. The vocal line continues with the lyrics: "- гүй су - рагла - саар Ү - нэ - нээ - сээ - дор - хой бол - но. Бага - хан хуга - цаа,". The piano accompaniment provides harmonic support.

Fourth system of the musical score. The vocal line concludes with the lyrics: "эрж сур - сан бол Үү - нийг мэ - дэх ганц зам бий. найд - ва - раар чи Бат зог - сох ит - гэ - лийг ол - но." The piano accompaniment ends with sustained chords.

24

А - суу - вал — Тэр чамд ха - риул - на. — Сөгд - вөл Тэр бү - тэн — бол - гоно.

28

— Нү - дээ аньж — шив - нэ - хэд чинь — Тэр сэт - гэлд чинь ха - риу — шив - нэнэ. — Өв - дөж бай -

33

- вал Тэр эд - гээ - нээ. Да - руу бай - вал Тэр ир - нэ. —

37

Coda руу очно
(Гурав дахь удаагаа дуулахдаа)

Мэр - гэн у - хаан дут - вал Бурха - наас гуй. Бурха - наас гуй. —

41

Амьд - ра - лын да - лайд хөл ал - даж, даарч, ха - яг - дан, ай - сан бол Ит - гэл ча -



46

- майг чиг - лүүл - нэ. _____ Сал - хинд нааш цааш _____ тууг - дан яв - сан ч,

46 Cm Bb/D Eb Ab

51

Хө-дөлш-гүй _____ хад шиг бат бөх, ү-нэн суурь _____ дээр зог-сож байна. _____ Чи а - суу-вал

51 Eb/G Fm7 Eb/G Ab Bb

57

CODA Бурха - наас гуй. _____

57 Bb Ab Eb Bb

62

62 Eb Eb/G Ab Eb Bb Eb

D.S. al CODA
 (25-р такт руу буцаж очоод,
 CODA хүртэл үргэлжлүүлнэ §)

Иаков 1:5-6

Иаков Бурханаас хариулт хүлээн авахын тулд хэрхэн асуух талаар заасан.



Итгэлээрээ гүй

“Итгэлээрээ гуйх гэдэг нь зөвхөн асуух биш үйлдэл болгох хэрэгцээг, гуйх мөн гүйцэтгэх

давхар үүрэг хариуцлагыг, ярих мөн үйлдэх шаардлагыг хэлдэг.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, “Ask in Faith,” *Liahona*, 2008 оны 5-р сар, 94.

МЭРГЭН УХААНААР ДУТВАЛ

Бид бүгд ямар нэгэн хэмжээгээр зөвхөн Бурханы бидэнд өгч чадах мэргэн ухаанаар дутдаг. “Бурханы-хыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй” (1 Коринт 2:11). Тиймээс бид бүгд Түүнээс гуйх хэрэгтэй.

ӨГӨӨМРӨӨР

Өгөөмрөөр гэдэг нь “ойлгоход хялбар” гэсэн утгатай үгнээс хөрвүүлсэн грек үг. Энэ нь бидэнд ил тод, өгөөмрөөр өгөх Бурханы хувиршгүй зорилгыг хэлж байж болно.

БУРУУШААЛГҮЙ

Бурхан таны залбиралд хариулдаг бөгөөд даруухнаар чин сэтгэлээсээ асуусны тань төлөө хэзээ ч *буруушаахгүй* (шүүмжилж, загнахгүй эсвэл зэмлэхгүй).

⁵ Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно. ⁶ Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн нь салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ.

Бүх хүнд өгөгч

“Тэрээр түүнд ирэх хэнээс боловч үл татгалздаг, . . . Бурханд бүгд адил.”

2 Нифай 26:33



Ямар ч эргэл-зээгүйгээр

“Өвчин эмгэг, гай зовлон ирэх үед гэрээнүүдээ эрхэмлэн, дуулгавартай

дага. Дараа нь ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуй. Хэрэгцээний тань дагуу Бурхан хариулах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон, “Гэрээнүүдийн хүч,” 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 22.

БУРХАНААС ГҮЙ

“Залбирлууд нь Есүс Христийн нэрээр Тэнгэрлэг Эцэгт хандсан байдаг. . . .

Залбирлын зорилго нь Бурханы тааллыг өөрчлөдөггүй боловч биднийг аюулгүй байлгаж мөн бусдын төлөөх залбирлуудыг Бурхан соёрхоход бэлэн байдаг хэдий ч бид үүнийг олж авахын төлөө гуйн хүсэх ёстой.”

Судруудын удирдамж, “Залбирал,” scriptures.lds.org.

Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол Төгс эзэмших сургаалын сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш бөгөөд зөвхөн таны судар судлах судалгааны эхлэх цэг юм.

Селестиел ЦАГ МӨЧ

Заримдаа тэнгэр тийм ч холгүй мэт санагддаг.

Холли Мэган Лора Хантэр

Нэг өдөр манай Залуу эмэгтэйчүүдийн удирдагчид Ариун Сүнснийг жинхэнээсээ мэдэрч, Бурхантай ойр байгаагаа мэдэх онцгой цаг мөчийн тухай заасан юм. Тэд тэр үеийг “селестиел цаг мөч” хэмээн санахад хялбар үгээр нэрлэжээ. Миний хувьд яг юу “селестиел цаг мөч” байдгийг би мэддэг бөгөөд ийм зүйлийг урьд нь мэдэрч байсан. Тухайлбал: селестиел хаант улсад амьдрал ямархуу байх тухай өчүүхэн ч гэсэн сүүмийх гэрэл, амт мэдэрсэн тийм үе юм. Надад ийм хором мөч маш олон удаа тохиолдож байсан.

Манай удирдагчдыг тухайн санааг танилцуулсны дараа бид гадагшаа гарсан. Нар моддын дундуур гэрлээ цацруулж байв. Бид нүдээ анилаа. Бүлээн сэвэлзүүр салхи үлээн, нар нүүрийг минь ээж байлаа. Шувууд жиргэж, модод салхинд найгахад бид Бурханы бүтээлүүдэд баясав. Энэ бол селестиел цаг мөч байсан юм.

Бас нэг өөр селестиел цаг мөч тохиосон нь найз минь баптисм хүртсэний дараа байлаа. Биднийг үйлчлэл хийгээд Сүмийн цуглааны байр руу буцаад явж байхад тэрээр миний гарыг атган, бидний найз байгаа нь хэчнээн сайхан болохыг мөн үүрд найз хэвээрээ байх болно хэмээн хэлж билээ. Би тэр өдрийг хэзээ ч мартаггүй. Би догдлон баярлаж, талархаж байсан.

Нэг жилийн дараа бид хоёул усан сангийн дэргэд зогсоод, түүнийг ээжийг баптисмын ус руу орж байхыг харж байхдаа тэрхүү баяр баяслыг дахин хамтдаа мэдрэх боломжтой байсан. Эргэн тойронд үзэсгэлэн гоо оршиж байв.

Ийм зүйлийг мэдрэх хамгийн сайхан газар бол мэдээж Их Эзэний өргөөн дотор билээ. Би ариун сүмд анх удаа орж байхдаа эцэг эх болон эгчтэйгээ хамт очих боломжоор адислагдсан юм. Би эмэг эхийнхээ өмнөөс баптисм хүртсэн бөгөөд түүнийг аз жаргалтай байгааг мэдэрсэн.

Селестиел цаг мөч хэзээ ч, хаана ч тохиолдож болно. Энэ нь хөгжим сонсож байхад юм уу гэр бүлийн үдшээ хийж байхад эсвэл сургууль дээр ч тохиож болно. Нэг гэр бүлийн үдшээр бүтд элгээ хөштөл инээцгээснийг тодхон санаж байна. Тэр миний хамгийн дуртай хормуудын нэг байсан.

Тийм селестиел цаг мөч миний гэрчлэлийг хүчирхэгжүүлэн, илүү талархах мэдрэмжтэй байхад тусалсан. Тийм цаг мөч надад гайхалтай сургамж өгч байсан. Ихэнх нь надад аз жаргал авчирч, сайн мэдээний тухай сайхан мэдрэмжтэй болгодог. Хэрэв би сайн мэдээний зарчмуудын агуу амьдрахаар үргэлжлүүлэн сонговол селестиел цаг мөчид л мэдэрдэг бүхий л гоо үзэсгэлэн, аз жаргал, амар амгалан, хайр бүтд селестиел хаант улсад хавьгүй их мэдрэх зүйл байх болно. ■

Энэхүү өгүүллийн зохиогч Шотландын Хойд Ланаркширд амьдардаг.



Иллиной Наувугийн ариун Сүмийн зургийг Микейла С. авав, АНУ, 2014

АРИУН СҮМД ОРОХ УРИЛГЫГ ХҮЛЭЭН АВАХ НЬ

Би 2012 онд баптисм хүртсэн бөгөөд Бразилийн Ипомеиа дүүргийн нэгэн салбарын цуглаанд оролцдог байлаа.

2014 оноос хойш би гэр бүлийн түүхийн ажилд идэвхтэй оролцож эхэлсэн юм. Ингэж оролцох болсон нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэны РүүтсТек дээр өгсөн гэр бүлийнхнийхээ өмнөөс баптисм хүртэхэд урьсан урилгаас эхэлсэн билээ. Би “тогшвол” “нээгдэнэ” гэснийг мэдээд, гэр бүлийн түүхийн ажлаа хийх шийдвэр гаргасан (Матай 7:7-г үзнэ үү).

Одоо надад илүү олон үеийн мэдээлэл, зураг, баримт бичиг, хамгийн чухал нь бас сэтгэл хөдөлгөм зүйл болох гэр бүлийн түүхүүд байна. Би ийм мэдээллээ ашиглаад гэр бүлийнхээ түүхээс сэдэвлэсэн зурагтай ном бичив. Номыг бичих төсөл надад Сүмийн гишүүн бус гэр бүлийнхээ гишүүдтэй холбоо барихад тусалсан бөгөөд гэр бүл мөнхөд хамтдаа байна гэсэн гэрчлэлээ хуваалцах боломжийг олгосон.

Энэ ажил ариун газарт зогсох, Сүмийн идэвхтэй гишүүн хэвээр байх, Их Эзэнд үйлчлэх дуудлага хүлээн авч номлолд гарах боломж өгсөн.

Хөшигний хоёр талд Сүмийн хийдэг авралын ажил үнэн бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн маань сүнсээр өгсөн зүйл юм гэдэг гэрчлэл надад бий. Би номлолд гарахаасаа өмнө өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм хүртэх боломжтой байсан бөгөөд одоо номлолдоо амьдралаа үүрд өөрчлөхийг хүсдэг амьд хүмүүст баптисм хүртээх боломжтой байна. ■

Ахлагч Бага Клаудио Клаус, Аризона Меса номлол

Дээд талд: Энэ зураг намайг болон миний бүрэн цагийн номлогч эгчийг хайрласан Бурханы хайрыг харуулдаг. Есүс Христийн сайн мэдээ бидний амьдралд үгээр хэлшгүй баяр баясгаланг авчирдаг.

Кэниа Р. Мехико Монтеррейгийн ариун сүмд байгаа нь



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
**Ахлагч М.Рассэлл
Баллард**

САЙН МЭДЭЭГ ХЭРХЭН ХУВААЛЦАХ ВЭ?

Бид итгэл үнэмшлийнхээ төлөө уучлал гуйх хэрэггүй. Үнэн гэж мэддэг зүйлээсээ ухрах хэрэггүй. Бид ойлгох гэсэн хандлага, **зоригтой, итгэлтэй байдлаар** болон Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулснаар мөн сонсож байгаа хүмүүсээ шахаж шаардалгүй, бидний итгэдэг зүйлийг тэр даруй хүлээн аваагүйнх нь төлөө сэтгэл санаагаар уналгүй сайн мэдээг хуваалцаж болно.

Бид Ариун Сүнстэй нөхөрлөж байгаа үедээ Сүмийн идэвх султай гишүүдийн төдийгүй бидэнтэй итгэл нэг биш хүмүүсийн амьдралд ч сайн мэдээний илүү дээр ойлголтыг авчрахын тулд энгийн зүйлсийг хийж чадна. Үүнийг хийхийн тулд шинэ хөтөлбөр гаргах шаардлагагүй. Бидэнд гарын авлага, дуудлага эсвэл сургалт хэрэггүй. Сүмийн сайн гишүүдэд хэрэгтэй цорын ганц зүйл бол **Ариун Сүнсний хүчинд найдаж** суран, энэхүү хүчээр Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн амьдралд хүрч, туслах явдал юм. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний ойлголтоор дутмаг хүмүүстэй **хувийн гэрчлэлээ** хуваалцахаас өөр агуу үйлчлэл гэж байхгүй.

Ах эгч нар аа, бид ямар нэгэн зүйл хийхэд бэлэн үү? Бидний хүн нэг бүр өнөөдөр Ариун Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлснээр **хувийн сүнслэг бэлтгэлээ хангаж**, Түүний хүчээр Тэнгэрлэг Эцэгийн илүү олон хүүхдийг Сүм үнэн гэсэн ойлголт, мэдлэгээр адислах шийдвэрийг гаргах уу?

Аврагч амьд бөгөөд хэрэв Түүний Сүмийн энэ агуу ажлыг урагшлуулахын тулд чадах бүхнээ хийвэл бидний хүн нэг бүрийг адислах болно гэдгийг би гэрчилж байна. Бид бүгдээрээ ямар нэгэн зүйлийг хийх шийдвэр гаргах болтугай. ■

2000 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.



ТА ҮҮНИЙГ ХЭРХЭН ХИЙСЭН БЭ?

Би Сүмд өсөж том болсондоо маш их талархалтай байдаг. Би сайн мэдээг хуваалцах дуртай. Найз нөхөд маань болон бусад олон хүн, нэн ялангуяа Тэнгэрлэг Эцэг намайг харж байгаа учраас би сайн үлгэр жишээ үзүүлэхийг хичээдэг. Тэнгэр дэх Эцэг та нарын хийж байгаа ямар ч зүйлийг үл тоомсорлож, анзаарахгүй өнгөрдөггүй. Та нар зөв зүйл хийж, Түүний хүүхдүүдтэй сайн мэдээг хуваалцахыг хичээх ёстой. Эдгээрийг хийх боломж хязгааргүй байдаг учраас та нар зөвхөн харах нүдтэй байхын төлөө залбирч, боломжоо ашиглах хэрэгтэй.

Чари Г, АНУ, Арканзас

Яагаад үл уучилдаг хүнд илүү их нүгэл үлддэг вэ?

Их Эзэн “та нар бие биенээ уучлах ёстойг та нарт хэлнэ би; учир нь ах дүүгийнхээ зөрчлийг үл уучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой.

Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана” (С ба Г 64:9–10) хэмээн заасан.

Бид уучлахаа хойшлуулснаар өөрсдийнхөө мөхөс шүүлтийг Их Эзэний төгс шүүлтээс илүү дээр гэж үздэг. Түүнд хүмүүсийн зүрх сэтгэл, нөхцөл байдлын талаар төгс ойлголт байдаг ба зөвхөн Түүнд шүүлт хамаардаг. Тэрээр эцсийн эцэст буруутгагдсан мөн буруутгасан бүх хүнд төгс шударга ёс, нигүүлслийг үзүүлэх болно.


Их Эзэн биднээс уучлахыг шаардахаас гадна бидэнд зовлонгоос илүүтэй жаргальг сонгож, уур бухимдал, өшөө хорслоо хаяж, Түүний ач ивээлээр дамжуулан эдгэрэхэд тусалдаг. Тийн бид ахлагч Кэвин Р.Данканы сануулснаар “Аврагчийн Цагаатгал нь зөвхөн наманчлах шаардлагатай хүмүүст төдийгүй бусдыг уучилж чадахгүй байгаа хүмүүст ч гэсэн зориулагдсан юм” (“Өршөөлийн эдгээх тос,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 19) гэдгийг олж мэддэг. ■

Сэтгэл гутралын талаарх Сүмийн байр суурь юу вэ? Би сэтгэл гутралын талаарх асуудалд хэрхэн хандах вэ?

Хүн бүрд үе үе гутрах зүйл гардаг ч Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ, гэр бүл, удирдагчид, бусдын дэмжлэг зэрэг нь биднийг тайтгарал, баяр баясгалан, амар амгаланг дахин олоход тусалж чадна. Гэхдээ Сүмийн удирдагчид архаг гутрал буюу сэтгэл гутралын өвчин тун ноцтой нөхцөл байдал бөгөөд хувь хүний чадварт нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд гутранги байдлын хурцадмал үе тохиолдвол хийх зарим зүйлийг санал болгосон. Үүнд:


- Тэнгэрлэг Эцэгт болон Есүс Христэд итгэх итгэлээ бүү алд.
- Амьдралд тань Ариун Сүнснийг авчрах зүйлсийг хий (залбирах, судар судлах гэх мэт).
- Бас эцэг эх, санваарын удирдагчдаас зөвлөгөө хүс.
- Санваарын адислал ав.
- Долоо хоног бүр ариун ёслолоос хүрт. Есүс Христийн Цагаатгалын амлалтуудаас зууран барь.
- Ядаргаа гэх мэт сэтгэл хямралын үзүүлэлтээ ажигла. Тэгээд өөрчлөлт хий.
- Хэрэв танд асуудал байвал сайн мэргэжилтнээс зөвлөгөө авах талаар эцэг эх, санваарын удирдагчидтайгаа ярилц.

(“Эвдэрсэн сав шиг,” 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 40–42-ыг үзнэ үү.) ■



СЭРГЭЭЛТ

Бид энэ жил *Аиахона* дээрээс Сүмийн түүхийн талаар суралцаж байгаа. Таны болон танай гэр бүлийн энэ жилийн турш уншиж болох судруудын жагсаалтыг 68-р хуудсаас харна уу. Уншсаныхаа дараа юу мэдэж сурснаа ярилц. Мөн тохирох дугаартай хэсгийг будна уу. Энд байгаа зураг бүр Есүс Христийн сэргээгдсэн үнэн Сүмийн нэг хэсгийг харуулж байгаа.





СУДРЫН ЖАГСААЛТ

Эдгээр судрын ихэнх нь Их Эзэний Иосеф Смитэд өгсөн илчлэлт юм. Судруудыг уншихдаа 66–67-р хуудсан дээр хавсаргасан тайлбар зургуудыг будна уу.

1. Иосеф Смит—Түүх 1:10–13	27. Сургаал ба Гэрээ 59:9–10; 15–19
2. Иосеф Смит—Түүх 1:14–17	28. Сургаал ба Гэрээ 64:9–11
3. Иосеф Смит—Түүх 1:30, 33–34	29. Сургаал ба Гэрээ 64:33–34
4. Иосеф Смит—Түүх 1:51–53	30. Сургаал ба Гэрээ 76:19–24; 40–41
5. Иосеф Смит—Түүх 1:66–69	31. Сургаал ба Гэрээ 78:17–19
6. Сургаал ба Гэрээ 1:37–38	32. Сургаал ба Гэрээ 81:5–6
7. Сургаал ба Гэрээ 2:1–2	33. Сургаал ба Гэрээ 82:3, 10, 14
8. Сургаал ба Гэрээ 4:1–7	34. Сургаал ба Гэрээ 84:46–47, 62
9. Сургаал ба Гэрээ 6:34–37	35. Сургаал ба Гэрээ 88:78–80
10. Сургаал ба Гэрээ 8:2–3; 9–10	36. Сургаал ба Гэрээ 88:118–120
11. Сургаал ба Гэрээ 10:5, 69	37. Сургаал ба Гэрээ 88:123–126
12. Сургаал ба Гэрээ 11:6–7	38. Сургаал ба Гэрээ 89:1, 18–21
13. Сургаал ба Гэрээ 13:1	39. Сургаал ба Гэрээ 90:15, 24
14. Сургаал ба Гэрээ 18:10–13	40. Сургаал ба Гэрээ 97:15–16, 21
15. Сургаал ба Гэрээ 18:15–16	41. Сургаал ба Гэрээ 98:11–12
16. Сургаал ба Гэрээ 19:16–19, 23–24	42. Сургаал ба Гэрээ 100:5–8
17. Сургаал ба Гэрээ 20:75–79	43. Сургаал ба Гэрээ 101:16, 32, 36
18. Сургаал ба Гэрээ 25:10–13	44. Сургаал ба Гэрээ 105:39–41
19. Сургаал ба Гэрээ 27:15–18	45. Сургаал ба Гэрээ 107:6, 8, 13
20. Сургаал ба Гэрээ 39:20–23	46. Сургаал ба Гэрээ 110:1–10
21. Сургаал ба Гэрээ 46:10–12; 32–33	47. Сургаал ба Гэрээ 119:4, 6–7
22. Сургаал ба Гэрээ 49:25–28	48. Сургаал ба Гэрээ 121:7–9, 46
23. Сургаал ба Гэрээ 50:40–46	49. Сургаал ба Гэрээ 121:41–45
24. Сургаал ба Гэрээ 51:13, 19	50. Сургаал ба Гэрээ 122:7–9
25. Сургаал ба Гэрээ 58:26–28	51. Сургаал ба Гэрээ 130:20–23
26. Сургаал ба Гэрээ 58:42–43	52. Сургаал ба Гэрээ 131:1–4



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Даллин
Х.Өүкс

Тэнгэрлэг Эцэг миний залбиралд БАЙНГА хариулах уу?

Тэнгэрлэг Эцэг биднийг өөрсдөөс маань илүү сайн мэддэг. Тэрээр хамгийн сайн гэсэн арга замаар бидний залбиралд хариулах болно.



Бид Тэнгэрлэг Эцэгт болон Есүс Христэд итгэж байгаа үедээ Тэдэнд найддаг.



Тэнгэрлэг Эцэг та нарыг мэддэг бөгөөд та нарт хайртай гэдэгт итгэ. Тэрээр таны залбирлыг сонсоод, таны хувьд хамгийн сайн гэсэн арга замаар залбиралд тань хариулах болно гэдэгт итгэ. (3 Нифай 18:20-ийг үзнэ үү.)



"Faith in the Lord Jesus Christ," Ensign, 1994 оны 5-р сар, 98–100-аас авав.

БИДНИЙ ХУУДАС



Александра М, 10 настай, АНУ, Мэрилэнд



Их Эзэн Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн төлөө бүхнийг бүтээсэн. Би ан амьтан, байгаль дэлхийд хайртай.

Самуэл М, 7 настай, Испани, Мадрид




Лиссэттэ Н, 5 настай, Испани, Мадрид



Би ариун ёслолын цуглаан болон ням гаргийн хичээл дээр зарим зүйл бусад зүйлтэй адил тийм ч чухал биш байдаг гэдгийг мэдсэн. Хамгийн чухал зүйл бол Есүс Христийн сайн мэдээ ба Тэнгэрлэг Эцэгт дуулгавартай байх явдал юм. Би суралцах дуртай.

Иан А, 5 настай, Мексик, Морэлос



Би гэр бүлийнхэнтэйгээ хамт ариун сүмд орохдоо Их Эзэнийг надтай хамт байгааг мэддэг учраас Сүнсийг маш хүчтэй мэдэрдэг. Тэр "Хүүхдүүдийг зөвшөөр, Над уруу ирэхийг бүү болиул" гэж хэлсэн (Матай 19:14-ийг үзнэ үү).

Хэйтор А, 10 настай, Бразил, Парана



Далын ерөн-
хийлөгчийн
зөвлөлийн

**Ахлагч Волтэр
Ф.Гонзалэз**

НОМЫН ТАВИУР ДЭЭРХ НОМ

“Залбирч, эргэцүүлж, эрэлхийлэх нь миний хийх ёстой зүйлүүд” (Children’s Songbook, 109).

Би анх Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаар сонсоходоо арван хоёр настай байсан. Би хоёр ХҮТ номлогчтой автобусанд танилцсан ба тэд манай гэр бүлд зааж болох эсэхийг надаас асуусан юм.

Номлогчид бидэнд Мормоны Ном болон Иосеф Смитийн гэрчлэлийн товхимлыг

үлдээгээд явж билээ. Эцэг эх маань гайхамшигтай хүмүүс байсан ч тухайн үед Сүмд нэгдээгүй юм.

Номлогчдын үлдээсэн хоёр зүйл манай номын тавиур дээр олон жил болж билээ. Би арван найман настай байхдаа нэг удаа ямар нэгэн уншчихмаар гайгүй ном олохоор номын тавиур руугаа харж, Мормоны Номыг аваад, эхний бүлгийг уншив. Унших үед нэгэн онцгой мэдрэмж төрсөн юм.

Надад уг ном үнэн гэдгийг мэдэрсэн онцгой туршлага байдаг. Мормоны Номонд Есүс Христийн Цагаатгалын тухай онцгой захиас байв. Би өөрийнхөө амьдралын талаар мөн Тэнгэрлэг Эцэгийн адислалын талаар илүү ихийг мэдэж авсан.

Иосеф Смит ердөө арван дөрөвхөн настай байсан ч судар уншиж, Тэнгэрлэг Эцэгээс аль сүм үнэн болохыг асуухаар зориглосон гэдгийг би дараа нь ойлгож мэдсэн.

Тэр цагаас хойш би үргэлж Иосеф Смитийн үлгэр жишээг дагах болсон билээ. Би судруудыг судлан, Тэнгэрлэг Эцэгээс тусламж, удирдамж гуйдаг. Залбирал, Мормоны Ном хоёр миний амьдралын маш чухал хэсэг болсон.

Асуудалтай тулгарах үедээ Мормоны Номыг уншаад, залбир. Та надтай адил сайн мэдээний талаар илүү ихийг мэдэж аван, хэрэгтэй хариултаа олох болно. Үүнийг хийхдээ юу мэдэрч байгаагаа анзаараарай. ■



Мин Жун шалгуурт тэнцсэн нь

Кэлли Хансакэр

Бодит түүхээс сэдэвлэв

“Есүс бол бидний хайртай найз. . . . Хүүхэд бүр эрхэм” (Children’s Songbook, 58).

Мин Жун цонхоор Мүүд ширтэн зогсож байв. Тэр “маргааш бороо орох нь дээ” гэж хэлэхэд өвөө нь сонины цаанаас өнгийж хараад, толгой дохив. Өмнөд Солонгост бараг зун дуусаж байсан ба борооны улирал удахгүй эхлэх гэж байв.

Мин Жун ням гарагтаа бэлдэн, хувцасныхаа хажууд шүүхрээ тавилаа. “Бид маргааш өглөө эрт явах хэрэгтэй байх.”

Өвөө инээмсэглэв. “Сайхан санаа байна. Зам усанд автаж болзошгүй болохоор бид удаж очих байх.”

“Та Сүмийн байр усанд автахгүй



гэж бодож байна уу?” гэж Мин Жун асуулаа. Өнгөрсөн жилийн борооны улирлаар Сүмийн подвал усанд автсан юм.

“Тийм ээ” гэж өвөө хариуллаа. “Залбирал үргэлж тустай байдаг.”

“Би өнөө орой сүмийн төлөө залбирна аа. Тэгээд бид сүмдээ аюулгүй очих болно. *Сайхан амраарай.*” Мин Жун бөхөлзөөд, ор руугаа явав.

Маргааш өглөө нь тэд өглөө эрт гэрээсээ гараад, Мин Жун тэнгэрт бүрхсэн бараан үүлийг харлаа.

Өвөө нь “Итгэлтэй бай” гэж хэлэв.

Мин Жун өвөөгөө даган, гэрийнхээ ойролцоох гүвээ рүү шатаар өгсөв. Тэд гүвээний орой дээр гараад, түр амсхийхээр зогсол тэдний цагаан цамц чийглэг агаарт аль хэдийн норсон байлаа.

Өвөө борооны дуслуудыг мэдэрэхээр гараа дэлгэв. “Чи мэдэрч байна уу? Бороо орж эхэлж байна.”



ХИЧЭЭСЭЭР БАЙ

“Бид үргэлж амжилттай байхгүй байлаа ч *оролдлогыг* маань үнэлдэг нь сайн мэдээний агуу давуу тал билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Маргааш Эзэн та нарын дунд гайхамшигт зүйлсийг хийх болно,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 115.

Тэд шүхрээ дэлгэв. Тэднийг дараагийн шат хүрэх үед бороо хүчтэй орж эхлэв. Мин Жун бороон дундуур шат бүрийг харах гэж хичээж байсан ч халтирч, өвдгөөрөө унаад, “Ёо ёо” гэж уйллаа.

“Чи гэмтчихээ юү?” гэж өвөө асуув. Тэр өвдөглөн суугаад, Мин Жуны өмдний цоорхойг харлаа.

“Жоохон л шалбарсан байна” гэж Мин Жуны хоолой чичрэн хэлэв.

“Сүм дээр очоод учрыг нь олбё” гэж өвөө хэллээ.

Мин Жун өвөөтэйгөө дээд талын зам руу өгслөө.

“Салхи бүр ширүүсчихлээ” гэж өвөө шүхрээ арай ядан зууран хэлэхэд Мин Жун бараг л шүхрээ алдчих шахаж байв. Тэд удалгүй ширүүн салхи гарч, дотор гаднагүй салхилан, шүхрийг оёдлоор нь ураг нь тэр. Мин Жун мөрөө унжууллаа.

Өвөө шүхрийг авав. “Миний шүхрэн доор зогс. Бид бараг л ирчихлээ.”

Мин Жун өвөөгийнхөө шүхрийг хэрэглэж байсан ч ширүүн бороонд нэмэргүй байв. Тэд сүмийн ойролцоо ирэхэд Мин Жун хөгжим тоглож байгааг сонсов.

“Аль хэдийн эхэлчилжээ.” Мин Жун урд талын хаалга руу гүйв. Тэр өөрийнхөө дүрсийг шилэнд хартал үс нь шалба норж, өмд нь урагдаж, гутал нь шавхай болсон байлаа. Тэр хаалганаас холдон, буцаад алхаж эхэллээ.



“Би . . . би орж чадахгүй нь ээ” гэж Мин Жун итгэлгүйхэн дуугарав.

“Чи зүгээр л байна шүү дээ” гэж өвөө хэллээ.

“Гэхдээ би нойтон бас халтар харагдаж байна.”

Өвөө Мин Жун руу хараад, хашаанд бөхөлсөн бороо хэмжигчийг харав.

“Бороог хэмжихэд амархан. Мин Жун, гэхдээ бид өөрсдийгөө яаж хэмжих вэ?”

Мин-Жун өвөө рүүгээ нүдээ цавчлан харав.

“Чи шавартай гутал, шалбалсан хөл, арзайсан үсээ хараад өөрийгөө зохисгүй гэж бодож байна уу?” гэж өвөө хэлэв. Есүс илүү дээр арга замаар дүгнэдэг. Тэр чиний зүрх сэтгэлийг хардаг бөгөөд чамайг зөв зүйл хийж байгааг мэддэг. Хэрэв чи өөрийгөө Түүний шалгуураар хэмжих юм бол


бороо хэмжигч дүүрсэн байхыг олж харах болно.

Мин Жун бороо хэмжигч рүү хараад, дусал бүр хэмжигчийг улам бүр дүүргэж байгааг харав. Тэр сүм рүү ирэхийн тулд ямар их хичээл зүтгэл гаргаснаа мөн ирээд ямар халуун дулаан, аз жаргалтай мэдрэмжийг мэдэрснээ бодов. Тэр Аврагчид ямар их хайртайгаа мөн Аврагч өөрт нь хэчнээн их хайртайг бодов.

Мин Жун өвөөгөө тэврээд, тэд хамтдаа сүм рүү оров. ■

Зохиогч нь АНУ-ын Колорагод амьдардаг.

ЭРИКИЙН ТӨЛӨӨ ЗАЛБИРАХАА МАРТУУЗАЙ



Жюли Корнелиус Хуанг

Бодит түүхээс сэдэвлэв

“Бодгаль бүр өөрийнхөө амьдралыг мөн хэн болохоо шийдэх эрх чөлөөтэй” (Нумns, дугаар 240).

Каригийн гэр бүл хамтдаа залбирахаар буйданыг дэргэд өвдөг сөгдөв. Хүн бүр хүндэтгэл бишрэлтэйгээр гараа урдаа авлаа. Аав нь Каригийн дүү Ливээс залбирахыг хүсэв.

Аав нь түүнд “Тэнгэрлэг Эцэгт хүлээн авсан олон адислалынхаа төлөө талархахаа мартав аа” гэж хэлжээ.

“Эрикийн төлөө залбирахаа мартуузай” гэж ээж нь нэмж хэлэв. Ээж нь үргэлж тэдэнд Эрикийн төлөө залбирахыг сануулдаг.

Эрик бол Каригийн ах юм. Түүнийг их сургуульд явахаас өмнө Кари тэр хоёр хамгийн сайн найзууд

байв. Тэр хамтдаа байсан хөгжилтэй мөчүүдээ үнэхээр их үгүйлж байлаа.

Хэдэн сарын өмнө Эрик аав, ээж хоёртоо цаашид Сүмийн гишүүн баймааргүй байна гэж хэлжээ. Кари гэр бүлийнхээ хамт маш их гайхширан, гунигласан байна. Тэд Эрикийн төлөө орой бүр залбирдаг болов. Заримдаа тэд Эрикийг Ариун Сүнсний мэдрээд, сүмд эргээд явахыг хүсээсэй гэж залбирдаг байв. Аав нь Эрикийн ухаан санаа сайн сонголт хийхүйц саруул байгаасай гэж мөн ээж нь түүний итгэдэг хэн нэгэн хүн зөв замыг олоход нь түүнд туслаасай гэж залбирдаг байв. Эдгээр бүх залбирлын дараа Кари уурлахгүй байж чадсангүй. Тэнгэрлэг Эцэг яагаад Эрикийг сүмд авчрахгүй байгаа юм бэ?

Эцэст нь Ливийг залбирахаар амаа нээх мөчид

Кари тэр үгсийг хэлэхгүй байж чадсангүй. “Тэнгэрлэг Эцэг яагаад Эрикийг сүмд авчрахгүй байгаа юм бэ?”

гэж тэр тэссэнгүй хэлж орхив. Бүгд Кари руу гайхан харж байсан ч түүнд анзаарах ч тэнхэл байхгүй байв. Хэсэг хугацаанд хэн ч юу ч ярьсангүй.

Аав нь “Кари, чи өнөөдөр сургуулиасаа ирэхдээ цүнхээ газар шидчихсэн үү?” гэж асуув.

“Юу гэнэ ээ?” гэж Кари эргэлзсэн байртай асуулаа. Түүний цүнх энэ үйл явдалтай ямар хамааралтай юм бол? Тэр хаалга руу хараад, цүнх нь Ливийн цүнхний хажууд биш харин газар байгааг харжээ. “Үгүй ээ . . . уучлаарай”.

“Ээж чинь өлгөж бай гэж хэлээгүй бил үү?”

“Тийм ээ” гэж Кари хэлэв. Тэр газар ширтэв.

“Ээж чинь өлгөж бай гэж байнга хэлдэг биз дээ.”

“Тийм ээ” гэж Кари хэлэв. Тэр энэ ямар хамааралтайг нэг л ойлгохгүй байв. Аав нь түүний асуултад ач холбогдол өгсөн болов уу?

“Биднийг Эрикийн төлөө залбирах үед Тэнгэрлэг Эцэг үргэлж залбирлыг маань *сонсдог* гэдгийг би мэднэ. Эрик яг одоо сонсохгүй байгаад л асуудал нь байгаа юм. Чи цүнхний талаар хэлсэн ээжийнхээ үгийг сонсон дагах эсэхээ шийддэгтэй адил Эрик ч Ариун Сүнснийг сонсох эсэхээ шийддэг. Гэхдээ ээж чинь чамаас цүнхээ өлгөхийг хүсэх үед чи *үргэлж* сонсохгүй байна гэж байхгүй биз дээ?”

“Үгүй байх аа” гэж Кари хэлэв.

“Нэг л өдөр тэр сонсох болно” гэж ээж нь Кари рүү нүдээ ирмэлээ. Кари инээмсэглэв.

“Нэг өдөр Эрик ч бас сонсож магадгүй шүү дээ” гэж Кари хэлэв.

“Мэдээж хэрэг” гэж ээж нь хэллээ. “Ариун Сүнснийг сонсох нь чиний хөгжүүлэх ёстой чадвар. Эрик энэ чадварыг хөгжүүлж амжаагүй байж магадгүй.” Кари-гийн сэтгэл уужрав.

Тэд Ливийг залбирлаа хэлж эхлэхэд толгойгоо бөхийлгөлөө. Тэр Эрикийг Ариун Сүнснийг сонсож сурахын төлөө залбирав. Ливийг залбирч байх хооронд Кари амар амгалан, халуун дулаан мэдрэмж мэдэрлээ. Тэнгэрлэг Эцэг тэдний залбирлыг сонсож байгааг тэр мэдэж байв. Ливийг гэр бүлийнхээ адислал хүлээн авсан арга замуудыг тоочиж байх хооронд Кари залбирлын талаар илүү сайн мэдэж авснаа энэ адислал дээр нэмье гэж бодож байв.

Залбирал дуусахад Тэнгэрлэг Эцэг Эрикийг мартаагүйг Кари ойлгож авлаа. Тэр түүнийг хэзээ ч мартаагүй гэдгийг тэр мэдэж байв. ■

Зохиогч нь АНУ-ын Невада мужид амьдардаг.


СОНГОХ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

Сонгох эрх бол Тэнгэрлэг Эцэгийн хүн бүрд өгсөн бэлэг юм. Энэ нь юу хийхээ сонгох бэлэг юм. Тэнгэрлэг Эцэг бидэнд тусалдаг боловч ямар нэгэн зүйлийг хийлгэхээр биднийг хүчилдэггүй. Харин Тэр бидэнд өөрсдийнхөө төлөө сонгохыг зөвшөөрдөг.



Есүс надад хайртай

Ким Вэбб Рэйд



Дэлхийг бүтээхээс өмнө бид бүгдээрээ тэнгэрлэг эцэг эх болон хамгийн том ах Есүстэйгээ хамт тэнгэрт амьдарч байсан. Бид аз жаргалтай байж, нэг нэгнээ маш их хайрладаг байсан.

Нэгэн өдөр Тэнгэрлэг Эцэг бидний амьдрах дэлхийг бүтээх болно гэдгээ хэлсэн юм. Бид дэлхий дээр байх хугацаандаа зарим үед Түүний зарлигуудыг дагахгүй гэдгийг Тэр мэдэж байсан. Бидэнд Түүн рүү гэртээ эргэж очихын тулд Аврагч хэрэгтэй байсан бөгөөд Тэнгэрлэг Эцэг Есүсийг бидний Аврагчаар сонгосон.



Есүс дэлхийд ирээд,
амьдрах зөв арга
замыг бидэнд харуулж,
хүмүүст тусалсан. Тэр
тэдэнд бие биенээ
хайрлахыг заасан.




Есүс Гетсеманий цэцэрлэгт
болон загалмай дээр зовж
шаналсан юм. Бидэнд
наманчилж, нас барсныхаа
дараа дахин амьдарч болох
боломжийг өгөхийн тулд
Тэрээр үүнийг хийсэн билээ.



Би Есүсийн тухай суралцахдаа намайг
хайрлах Түүний хайрыг мэдэрдэг. ■

Би Тэнгэрлэг Эцэг Эхийн хүүхэд





Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх
**Ерөнхийлөгч Хью
Б.Браун (1883–1975)**

АМЬД БОШИГ- ЛОГЧИЙН ОРШИХ ШАЛТГААН

1939 онд Дэлхийн II дайн дэгдэхээс өмнө Браун ахыг Английн Нийтийн Танхимын нэгэн гишүүн Иосеф Смитийг бошиглогч байсан эсэхийг тунхаглах хууль ёсны мэтгэлцээнд урьжээ. 1955 оны 10-р сарын 4-нд Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн “Бошиглогчийн хувийн хэрэг” хэмээх үгэндээ ерөнхийлөгч Браун тэрхүү ярилцлагын талаар дүрсэлжээ (speeches.byu.edu-г үзнэ үү).

“Та нар энэ цаг үед Бурхан хүнтэй ярьсан гэдэгт итгэх миний итгэлийг уран зөгнөлт, утгагүй зүйл гэж хэлж байна” гэж би хэлсэн.

“Энэ нь миний хувьд тийм юм.”

“Бурхан хэн нэгэнтэй ярьсан гэдэгт та итгэдэг үү?”

“Мэдээж, үүний нотолгоо нь Библиэр дүүрэн байдаг.”

“Тэр Адамтай ярьсан уу?”

“Тийм ээ.”

“Енох, Ноа, Абрахам, Мосе, Иаков, Иосеф болон бусад бошиглогчтой ярьсан уу?”

“Түүнийг тэдэнтэй бүгдтэй нь ярьсан гэдэгт би итгэдэг.”

“Бурхан, хүн хоёрын хоорондох холбоо Есүсийг дэлхий дээр ирснээс хойш байхгүй болсон гэдэгт та нар итгэдэг үү?”

“Үгүй. Ийм харилцаа тэр үед оргил үедээ, дээд цэгтээ хүрсэн.”



“Эрхэм ээ, та Есүсийг амилсны дараа асар хийдэг байсан Тарсын Саул гэгч нэгэн хуульч Дамаск руу явах замдаа цовдуулж, амилан, тэнгэр рүү одсон Назарын Есүстэй ярилцсан гэдэгт итгэдэг үү?”

“Тийм ээ.”

“Саул хэний дуу хоолойг сонссон бэ?”

“Тэр бол өөрийгөө танилцуулсан Есүс Христийн дуу хоолой байсан.”

“Энэ бол Бурханы хүнтэй ярьсан Библийн цаг хугацааны жишиг горим байсан гэдэг буурь суурьтай дүгнэлт хийж байна.”

“Би үүнийг хүлээн зөвшөөрч байна, гэхдээ энэ нь Христийн эрин үеийн I зууны дараахан зогссон.”

“Яагаад энэ нь үргэлжлээгүй гэж та бодож байна вэ?”

“Би хэлж мэдэхгүй байна.”

“Бурхан түүнээс хойш ярихаа больсон гэж та бодож байна уу?”

“Үгүй гэдэгт итгэлтэй байна.”

“Үүнд шалтгаан байх ёстой.

Та надад нэг шалтгаан хэлж өгч чадах уу?”

“Би мэдэхгүй байна.”

“Би магадлалтай хэд хэдэн шалтгаан хэлж болох уу? Бурхан чадахгүй учраас хүнтэй ярихаа больсон байх. Тэрээр хүчээ алдсан.”

Тэр “Тэгж хэлэх нь мэдээж Бурханыг доромжилсон хэрэг болно” гэж хэлэв.

“Тэгвэл та үүнийг хүлээн зөвшөөрөхгүй юм бол Бурхан биднийг хайрлахаа больж, хүмүүний үйл хэргийг сонирхохоо больсон учраас хүнтэй ярьдаггүй байж болох юм.”

Тэр “Үгүй ээ. Бурхан бүх хүнд хайртай ба хэнийг ч ялгаварладаггүй” гэж хэлэв.

“За, тэгвэл Тэр ярих чадвартай, биднийг хайрладаг юм бол бидэнд Тэр хэрэггүй гэсэн ганцхан боломжит хариулт үлдэж байна. Бид шинжлэх ухаанд үсрэнгүй дэвшилтэт алхам хийж, боловсролтой болсон учраас бидэнд Бурхан хэрэггүй болсон.”

Тэгээд тэрээр айсуй дайны тухай юу бодсоноо чичирхийлсэн хоолойгоор “Ноён Браун дэлхийн түүхэнд Бурханы дуу хоолой энэ дэлхийд хэзээ ч байгаагүйгээр тийм их хэрэгтэй байна. Магадгүй та Түүнийг яагаад ярьдаггүйг хэлэх байх” хэмээн хэлэв.

Би: “Тэр ярьдаг, ярьсаар ч ирсэн, гэхдээ хүмүүнд Түүнийг сонсох итгэл хэрэгтэй” гэж хариулсан. ■



**АНХНЫ ҮЗЭГДЭЛ, ЖОРЖ
КОККО СЭНТЭНГИЛО**

"Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд алдар сууг нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—Энэ бол миний Хайртай Хүү, Түүнийг сонс!" (Жозеф Смит—Түүх 1:17).

Мөн энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



44-р
хуудас

ИТГЭЛТЭЙ БАЙДЛЫН ТУХАЙ БОШИГЛОЛЫН ЗАРЧМУУД

Та ирээдүйд итгэлтэй хэвээр үлдэхийн тулд одоо ямар шийдвэр гаргах хэрэгтэй вэ? Эдгээр арван зарчмын талаар эргэцүүлэн бод.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

2017 ОНЫ МЮЧЕЛИЙН СЭДЭВ

Тэнгэрлэг Эцэгт илүү ойртохыг хүсэж байна уу? Залбирлын тухай энэ жилийн Мючелийн уриаг судал.



50-р
хуудас

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Сэргээлт

Сургаал ба Гэрээнд хүрэхийн тулд энэ үйл ажиллагааг хөгжилтэй арга замаар хий.

66-р
хуудас



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ



MONGOLIAN